

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

6-71

1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслүүд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 72 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

7-65

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

65-67

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07 -ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

67-68

4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

68-71

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 30 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Заяабал, П.Мөнхтулга, Б.Түвшин, Г.Тэмүүлэн;
Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Ч.Номин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ж.Ганбаатар.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслүүд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 72 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Ж.Төрболд, Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, мөн газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн Анагаахын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан шинжээч Д.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хүнсний худалдаа, тусгай зохицуулалтын асуудал хариуцсан шинжээч Х.Майцэцэг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, мөн газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Стандарт, хэмжилзүйн газрын тамхины асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Пүрэвдулам, судлаач Н.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам,

зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Р.Батболд, Г.Ганбаатар, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, Д.Үүрийнтуяа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, мөн газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, М.Нарантуяа-Нара, Л.Мөнхбаясгалан, Д.Үүрийнтуяа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, судлаач Н.Ганбат, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн Анагаахын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан шинжээч Д.Ганзориг, Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Нарантуяа-Нара, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, М.Бадамсүрэн, Д.Үүрийнтуяа, П.Сайнзориг нар үг хэлэв.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, П.Сайнзориг нар үг хэлэв.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

4.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Ж.Төрболд Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Хүний хөнжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07 - ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа нар байлцав

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1.5 тэрбум” гэснийг “2.5 тэрбум” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, 26.2 дахь хэсэг, 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “05-ны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “05-ны” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21

52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу Сангийн сайд байхгүй байгааг мэдэгдэж, уг асуудлыг хойшлуулав./15:14/

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 30 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
11 цаг 30 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.3 хувьтай бүрдсэн тул 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний тойрог, нэрээр нь танилцуулна.

Ирсэн гишүүд Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Гомбын Ганбаатар, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвжавын Сайнзориг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Далайн Батбаяр, Жамбын Батсуурь, Хассуурийн Ганхуяг, Нанзадын Наранбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Ринчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Даваахүүгийн Пүрэвдаваа, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 72 гишүүн 2025 оны 09 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

4.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

6.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 2 гишүүн 2026 оны 03 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэгдэх асуудал. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ирцэд Жаргалсайхан гишүүн, Бадамсүрэн гишүүд орж ирсэн байна. Өшөө хэн нэмэгдсэн байна? Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийг танилцуулна. Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Цэрэнчимэд Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга, Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганзориг Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газар Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн Анагаахын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан шинжээч, Майцэцэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнсний худалдаа, тусгай зохицуулалтын асуудал хариуцсан шинжээч, Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч, Төрболд ирээгүй байна. Пүрэвдулам Стандарт хэмжил зүйн газрын тамхины асуудал хариуцсан мэргэжилтэн, Ганбат Судлаач.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй.

Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын

гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан хугацаанд урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

2.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дагалдаж орж ирсэн. Энэнээс энэ хүний эрүүл мэндэд бас хор хөнөөл нь багатай гэж яригдаад байгаа энэ тамхинууд дээр тавигдаж байгаа татварын асуудал уламжлалт тамхитайгаа ижил байх юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Энэ ямар тооцоолол, ямар дүгнэлт юман дээр тулгуурлаж гарч ирэв ээ гэж?

Тэр жишээ нь 2.6.1.2 дахь хэсгийн 1 дээр халаадаг тамхи нь орчхоод байгаа юм. Бусад өнөө янжуурууд гэдэг юм уу, бусад тамхинуудтайгаа нэгэн ижил татвартай байхаар орчхоод байгаа гэж. Нэг.

Хоёрдугаарт тэр электрон тамхи цэнэглэдэг шингэн гэж юм байгаад байх шиг байна янз нь. Тэгэхээр нэг тэр төхөөрөмжийг хэдий хэмжээний миллилитрээр цэнэглэгддэг юм бэ? Бид бол миллилитрт нь 30 он гэхэд 5000 төгрөгийн татвартай байхаар тооцогдоод байх шиг байна. Гэтэл юуг хэдээр цэнэглэдэг юм, тэр ямар хэрэглээтэй байдаг юм? Үүн дээр тодорхой хариулт авчихмаар байна.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг. Нэр, албан тушаалаа хэлээд тэгээд хариул. Байж байгаарай сая мик нээгдсэн. Одоо индрийн микийг нээгээрэй.

С.Цэрэнчимэд: Гаалийн төв лабораторийн дарга Цэрэнчимэд. Батжаргал гишүүний асуусан саяын асуултад хариулъя гэж бодож байна. Нөгөө никотин, цэнэглэгч шингэн гэдэг талаар. Цэнэглэгч шингэн гэдэг нь болохоор нөгөө электрон тамхи буюу электрон тамхи дээр чартераа цэнэглэж байгаа юм. Тэр нь болохоор соролтын тооноосоо хамаарна. 30 соролттой юм уу, 10 соролттой, 10 мянган соролттой юм уу, 20 мянган соролттой юм уу, 33 мянган соролттой юм уу гэдгээсээ хамаараад шингэн нь өөр байдаг.

Жишээлбэл, 30 мянган соролттой электрон тамхи дээр 22 миллилитр байна. 16 мянган соролттой дээр, 20 мянган соролттой, 15 мянган соролттой дээр 16 миллилитр байна гээд ингээд бүгдээрээ тоо нь өөр байдаг. Тэгэхдээ шингэн маань орж ирэхдээ 5-10 миллилитрээр орж ирж байгаа.

Тийм учраас энэ бол энэ харьцангуй тоо. Тэгэхээр бид нар бол яаж оруулж ирж байгаа вэ гэхээр нөгөө их, аль болохоор сүүлийн үед бол анх удаа орж ирж байхдаа бол нөгөө электрон тамхинууд маань их соролт бага байсан. 800 удаагийн соролттой, 1000 удаагийн соролттой, 10 мянган удаагийн, 6 мянга, 8 болоод 12 болоод явсан. Одоо бол 30 мянган соролттой болоод ороод ирж байгаа юм.

30 мянган соролттой гэхээр 1 электрон тамхийгаа 30 мянган удаа сорж дуусах нь. Тэр нь 22 миллилитр, 3 процентын никотин агуулсан шингэн байх нь гэж гарч ирж байгаа юм. Тэгэхээр бид нар бол энийг нь айн? Халаадаг тамхи маань болохоор ширхгээр явж байгаа. Тэгэхээр 20 мянган ширхэг гээд. 1 ширхэг тамхи нь болохоор 20 мянган ширхэг байгаа. 1 хайрцаг нь.

Тэгэхээр янжуур тамхитайгаа ижилхэн. Янжуур тамхи дээр бол бид нар 100 ширхэг тутам гээд тавьчихсан байгаа бол халаадаг тамхиа бас 100 ширхэг тутам оруулж ирсэн байна.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Одоо тэгвэл хэдүүлээ их тодорхой болгож, хүнд ойлгомжтой болгоё. 1 ширхэг утаат янжуур татах, тэр шингэнтэй тамхи татахаар зэрэг хэдэн ширхэг янжууртай 1 миллилитр нь тэнцдэг юм бэ? Тэр дээр хариулт авъя даа.

Н.Наранбаатар: Индрийн микрофон өгье хариулт.

Ч.Чимгэрэл: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн дарга Чимгэрэл. Бид Онцгой албан татварын тухай хуулийн төсөл дээр тамхин бүтээгдэхүүний биет нэгжид тооцох хэмжээг бид нар электрон тамхийг янжуур тамхитайгаа дүйцүүлээд тооцсон байгаа. Энэ дээр 1 миллилитр шингэн бол 1 хайрцаг янжууртай адилтгах хэмжээгээр оруулж өгсөн. Энэ нь өөрөө бас бусад оронд яг энэ хэмжээсээ аваад явдаг юм байна лээ. Тийм учраас 1 миллилитрийг 1 хайрцагт тамхитай дүйцүүлж оруулсан байгаа.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: 3 асуулт байна. Нэгдүгээр асуулт яг энэ онцгой албан татвартай холбоотой асуудлыг Засгийн газраас ер нь энэ дээр онцгой албан татварын санал оруулж ирэх эсэхийг нэгдүгээрт тодруулчихмаар байна.

Хоёрдугаарт би энэ соролтоор онцгой албан татвар ноогдуулна гэдгийг бол их сайн ойлгохгүй байна. Тийм жишиг байдгийг ч ер нь сайн мэдэхгүй байгаад байна. Энэ чинь нөгөө никотины агууламж байдаг юм уу, никотин миллиграмм байдаг юм уу тийм байдлаар энэ чинь онцгой албан татвар ноогдуулдаггүй юм уу? Соролтоор онцгой албан татвар ноогдуулна гэдгийг чинь би бол ерөөсөө ухаж ойлгохгүй байгаад байна л даа. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авчихмаар байна. Тийм жишиг нь юу байдаг юм гээд?

Гуравдугаарт энэ бүх төрлийн тамхины татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл дээр онцгой албан татвар тавьчихсан байна л даа. Тэгээд би энийг бас ерөөсөө ухаж ойлгохгүй байгаад байна л даа. Энэ архины хундага дээр онцгой албан татвар байдаг юм уу? Машины дугуйн дээр онцгой албан татвар байдаг юм уу? Тэрнээс биш бол энэ цахилгаан тамхийг бол татвартай байх асуудлыг бол дэмжиж байгаа юм. Гэхдээ энэ асуудлыг ерөөсөө ухаж ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ яаж гаргаж ирэхээрээ ингэж гаргаж ирдэг юм бэ? Соролт гэдгээ яг яаж тайлбарлаад байгаа юм? Хүн их уушги томтой хүн бол арай өөр сорох байх. Манай Булгантуяа шиг жижигхэн уушгитай хүн бол арай өөр л сорох байх. Үгүй та нар чинь ер нь яаж ингэж гаргаж ирэх юм? Шинжлэх ухааны үндэслэлтэй юм жоохон гаргаж ирмээр байх юм. Айн? Ганбаатар гишүүн бол 2, 3 сорох юмыг Булгантуяа гишүүн бараг 30 сорно. Үгүй ийм энгийн логиктой юмыг яаж ингэж оруулж ирэх ингэж оруулж ирдэг юм? Би ерөөсөө ойлгохгүй байгаад байна л даа. Тэгээд яах юм машины дугуй, машины тэр дээгүүр бүтээдэг бүтээлгэн дээр нь онцгой албан татвар авах юм уу? Архины хундага, архины даруулга дээр онцгой албан татвар авах юм уу? Энэ дээр яг тайлбар авчихъя тэгэх үү.

Н.Наранбаатар: Индрийн микрофон хариулна.

Ч.Чимгэрэл: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Соролтоор ерөөсөө онцгой албан татвар дээр нэгжээр тодорхойлоогүй байгаа. Миллилитрээр тодорхойлсон байгаа. Онцгой албан татварын хуулийн төсөл тайл.../минут дуусав./

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг хүндэлж төрийн албан хаагчид үнэн, бодитой, зөв асуултад товч, тодорхой хариулах ёстойг сануулъя. Индрийн микрофон нээгээрэй. Хариулт .

Ч.Чимгэрэл: Залруулга хийе. Түрүүн бол ажлын хэсгийн гишүүн соролтоосоо хамаараад миллилитр нь их, бага хэмжээтэй байдаг талаар дурдсан. Одоо бол хуулийн төсөл дээр бол нэгжид ногдох электрон тамхины шингэнд ногдох нэгж нь 1 миллилитр байгаа. 2 миллилитр нь бол 1 хайрцагтай тэнцэх ийм дүйцүүлсэн байдлаар оруулж ирсэн байгаа. Миллилитрээр тооцогдож байгаа. Шингэний. Электрон тамхи чинь өөрөө дотроо шингэн. Электрон тамхи.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Сандаргасан бол уучлаарай. Би 2 юм тодруулах гээд байна нэмээд. Энэ тэгэхдээ юмаа жоохон эсвэл сайн судлаагүй юм уу, эсвэл сайн бэлдэж орж ирээгүй юм уу. Миллилитр гээд шингэн яриад байх юм. Шингэн доторх тэр никотины агууламж чинь өөр өөр байж болно тийм ээ? Архины нөгөө градустай л адилхан байхгүй юу. Энэ чинь сөжү гэдэг архи чинь 17 градустай байдаг. Монголын архи чинь 40 градустай. Тэгээд тэрийг миллилитрээр тооцох юм бол наадах чинь агууламж нь өөр, тавигддаг татвар нь өөр байх ёстой шүү дээ. Тэгээд

жиших юм чинь уг нь никотин байгаад байна. Никотиныхоо агууламжаар яагаад энийгээ оруулж ирээгүй юм бэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт энэ тамхины дагалдах төхөөрөмжийг, дагалдах хэрэгслийг бас зөвшөөрөлтэй болгочихсон байгаа байхгүй юу. Энэ чинь Зөвшөөрлийн хуулиараа та нар тэр Зөвшөөрлийн хуульд оруулах, Зөвшөөрлийн зөвлөлөөр оруулах гэсэн тэр процесстой шүү дээ энэ өөрөө хууль нь. Ингээд хуульд аваад шууд ингээд салбарын хуулиар зөвшөөрөлтэй болгоно гэж орж болдог юм уу? Та нар энэ хуулиа судалсан юм уу?

Н.Наранбаатар: Гишүүний асуултад хууль санаачлагч хариулна. Номинчимэг гишүүний микрофоныг өгье. Номинчимэг гишүүний микийг нээгээрэй.

О.Номинчимэг: Энэ хуулиар бол яг энэ ямар ч зохицуулалтгүй байгаа электрон тамхины стандарт, хэрэглээ, татвар гээд бүхий л юмыг бид нар судалж орж ирсэн. Тэгээд хуулийн төсөлд бол яг таны дурдаж байгаа никотины агууламж ямар байх вэ гэдэг асуудлыг энэ хуульд оруулж ирсэн байгаа. Тэгээд бид нар энэ хуульд бол яг тэр Европын холбооны улсад дагаж байгаа стандарт буюу шингэний хэмжээ, түүн дотор агуулагдах никотины дээд хэмжээг стандартаар оруулж өгсөн. Тэгээд энэнийхээ дагуу судлаад татвар дээрээ бол улс орон бол янз бүр байна.

Жишээ нь, Израйл бол нэлээн хатуу бодлоготой. Электрон тамхийг илүү өндөр татвар авдаг. Англи улс бол арай зөөлөн аргаар үздэг. Тэгэхээр бид нар бол Англи улсын электрон тамхины шингэн дээр оногдож байгаа тэр никотиных нь хэмжээнээс хамаараад оногдож байгаа татварыг нь дүйцүүлж авч үзэж байгаа юм. Тэгэхээр ийм дүйцүүлэл орж ирсэн. Таны хэлж байгаа тэр никотины буюу энэ донтуулах шинж чанартай стандартыг нь оруулаад тэрнийхээ дагуу миллиграммаас нь тооцож, татварыг нь тооцож оруулж ирсэн гэдгийг хэлмээр байна.

Зөвшөөрлийн тухай хуультай холбоотой бол хөндсөн зүйл байхгүй. Бид нар Засгийн газраас санал авахад өөр төрлийн зөвшөөрөлтэй холбоотой санал өгсөн. Тэрийг нь бид нар хууль дээрээ тусгаад хасчихсан байгаа. Тамхин бүтээгдэхүүн гэдэг юманд тооцогдож байгаа бол угаасаа тамхин бүтээгдэхүүн бол зөвшөөрөл авдаг. Энэнийхээ дагуу байгаа. Энэ шинэ зөвшөөрөл үүсгэж байгаа биш. Тамхин бүтээгдэхүүн импортлох, худалдаалах зөвшөөрөл бол бүгдэд нь үйлчилнэ. Тэгэхээр электрон тамхийг болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн тэр наадаг юу билээ зажилдаг энээ тэрээ гэж байна тамхин бүтээгдэхүүндээ тооцоод ороод ирэхээр угаасаа л байдаг зөвшөөрлийн хүрээнд шийдэгдэж байгаа учраас Зөвшөөрлийн зөвлөлөөс шаардлага авахгүй гэсэн. Энэ бол засгийн өөрийнх нь санал байгаа. Засгийн газраас ирсэн саналыг харах юм бол энэ ойлгомжтой байгаа гэдгийг бас нэмж тайлбарлая.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тийм хуулийг хоёр өөрөөр тайлбарлаж болохгүй л дээ. Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг асуудал дээр никотинтой холбоотой 1 ч үг, үсэг алга байна л даа. Тэр стандарт гэдэг юм чинь хамаагүй. Онцгой албан татвар яаж туссан бэ гэдгээрээ л энэ чинь татвар авна гэсэн үг. Нэг ёсондоо ингээд экспортоор 500 миллилитртэй архи орж ирэхэд 500 граммаар нь хэмжиж татвар авна гэсэн л ийм л хуулийн зохицуулалт энд орж ирсэн байгаа байхгүй юу. Энэ чинь градусын зохицуулалттай байдаг байхгүй юу даа жишээлбэл

архи дээр бол. Машинаар бол тэр моторын багтаамжаар нь болон үнийн дүнгээр нь онцгой албан татвар ноогдуулдаг.

Тэр онцгой албан татвар гэдэг маань маш тодорхой, тэр хэмжих нэгж нь маш тодорхой байх ёстой юм. Тэгэхээр энэ дээр бол тэр чинь алга байна шүү. Тэгээд энийг хэрвээ хэлэлцээр хэсэг нь явчихвал тэр ажлын хэсэг нь энийгээ анхаарах ёстой.

Хоёрдугаарт дагалдах хэрэгсэл дээр зөвшөөрөлтэй болно гээд энэ хууль дээр чинь бол орчихсон л байгаад байна л даа. Би тэгээд тэрийгээ тодруулж асууж байгаа юм.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Та хуулийн төслийн 6.7.2 дээр харах юм бол энэ никотины агууламжийн талаар байгаа. Тэгээд Онцгой албан татварын тухай хууль дээр харах юм бол янжуур тамхины никотин байдаг юм уу, таарын хэмжээнээс хамаараад ийм татвар байна гэсэн юм бол байхгүй. Энэ бол өөрөө стандарттай. Тамхины хяналтын тухай хууль дээрээ, үндсэн хууль дээрээ байдаг. Үүнийхээ дагуу татвараа байдаг.

Тэгээд Тамхины тухай хууль дээрээ энэ стандартууд байгаа. 6.7.2 дээр харах юм бол электрон тамхины шингэний хэмжээ 2 миллилитрээс цэнэглэгч шингэнийг 10 миллилитрээс ихээр савлах, шингэн дэх никотины агууламж 20 миллилитрээс их байхыг хориглоно гээд энэ стандартыг оруулчихсан. Энэнийх нь дагуу ийм стандартын дагуу татвар гэж байгаа. Янжуур тамхины хувьд ч гэсэн бид нар никотины хэмжээ, таарын хэмжээ бүгд стандарттай. Энэнийхээ дагуу онцгой албан татвар дээр тэр хэмжээгээсээ хамаарахгүйгээр татвар оногддог. Тэгэхээр энэ бол нэгдсэн зохицуулалт. Архитай бол зүйрлэхгүй архи бол өөр төрлийн бүтээгдэхүүн. Тамхи дээр бол ийм байгаа учраас энэ стандартын дагуу онцгой албан татварын бичилт хийгдэж орж ирсэн байгаа. Энэ дээр бол хэн ч маргахгүй байх гэж бодож байна.

Төхөөрөмжийн хувьд бол ингэж байгаа. Төхөөрөмж бол өөрөө энэ төхөөрөмжгүйгээр энэ тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэх ямар ч боломжгүй тийм бүтээгдэхүүн учраас салшгүй нэг хэсэг гэж үзээд энэ тамхи болон тамхин бүтээгдэхүүний угаасаа тодорхойлолтод ороод ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тамхи, тамхин бүтээгдэхүүн чинь өөрөө тусгай зөвшөөрөл авдаг болохоор энд шинэ тусгай зөвшөөрөл гэж үзэгдэхгүй байгаа. Одоо байгаа тусгай зөвшөөрлийн хүрээнд шийдэгдэх асуудал байгаа юм.

Тэгээд тэр тамхин бүтээгдэхүүний төхөөрөмжөөс татвар авах уу, үгүй юу гэдэг асуудал дээр бол мэргэжлийн байгууллагууд олон төрлийн саналууд өгсөн. Мэдээж ажлын хэсэг бол ажиллаж байгаа байх. Гэхдээ энэ бол Зөвшөөрлийн хууль бол зөрчсөн ас асуудал биш. Тамхи, тамхин бүтээгдэхүүний тодорхойлолттой ороод ирж байгаа учраас Зөвшөөрлийн хууль зөрчигдөхгүйгээр одоо байгаа зөвшөөрлийн хэмжээнд орж ирж байгаа асуудал гэдгийг бас ойлгоосой гэж бодож байна.

Н.Наранбаатар: Болохгүй. Батболд гишүүн.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ татвартай холбоотой нэг зүйл асуух гэсэн юм. Би ажлын хэсэгт уул нь ажиллаж байсан. Тэгэхдээ бас Номинчимэг гишүүнтэй саналаа хуваалцаад явсан. Энэ татаж хэрэглэх зориулалттай навчин, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй гээд энэ янжуурын талаар бас ярилцаж байсан. Энийг бас та санаж байгаа байх. Тэгээд одоо янжуур тамхи үйлдвэрлээд байгаа үйлдвэрлэгч улсууд маань өөрөө дотооддоо зарж байгаа тамхины үнэ нь 11 мянгаас дээшээ ингээд бүр 48 мянган төгрөг хүртэл ч юм уу 1 хайрцаг тамхи тийм үнэтэй байгаад байгаа.

Тэгээд дээрээс нь тухайн оронд зарагдаж байгаа тэр тамхинуудыг нь аваад татахаар үнэр, амтны хувьд манай улсад зарагдаж байгаа тамхинаас хамаагүй ондоо байгаад байдаг. Тэгэхээр бид нар энэ чанартай тамхийг оруулж ирээд зарах тийм боломж байгаагүй юм уу? Заавал онцгой албан татвар одоо бид нар байгаа энэ хортой тамхиа л илүү татаад байна л гэж ойлгоод байна л даа. Бүүр их хортой тийм ээ. Тамхи өөрөө хор. Тэгэхдээ арай илүү хортойг нь манайхан татаад байна гэж ойлгоод байгаа юм. Тийм. Тэгэхээр тухайн улсад нь тэр стандартад нь нийцсэн тухайн үйлдвэрлэгчийн тухайн орондоо зарж байгаа стандартад нь нийцсэн тамхиа оруулж ирж болохгүй юм уу гэдэг асуудлыг л хөндөөд байгаа юм. Тэгэх юм бол угаасаа өөрөө тамхины чинь үнэ өсчихөөр онцгой албан татвар чинь өөрөө бас адилхан нэмэгдээд өсөөд явах ёстой юм.

Тэгэхээр одоо байгаа бид нар бодвол бөөний үнээрээ 4 мянга орчмоор тамхи авч татаад байгаа. Гадаадад үйлдвэрлэгч улстай болохоор энэ нь 12 мянга юм уу, 10 мянга, тэгээд тэрнээс дээшээ байгаад байдаг. Энэ стандартыг нь зааж өгөөд зүгээр хуучин онцгой албан татвараар нь явуулж болохгүй байсан юм уу л гэж асуух гээд байгаа юм.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя. Хэн хариулах вэ? Индрийн микрофон дээр ажлын хэсгээс хариулъя. Хэн хариулах вэ? Батболд гишүүн ээ хэн хэн хариулах ёстой вэ? Татвар, гааль, лаборатори байна. Хэн хариулах ёстой вэ? Лабораторийн хүн хариулах юм байна. Индрийн микрофон.

С.Цэрэнчимэд: Батболд гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын стандарт байгаа. Янжуур тамхины стандарт. Тэр дээр бол никотин, бохины хэмжээг зааж өгсөн байдаг. Бохь нь болохоор 14 миллиграмм ширхэг, никотин 1.3 миллиграмм ширхэг гэж зааж өгсөн байгаа. Энэ стандартын дагуу Гаалийн төв лаборатори бол бохины агууламж, никотины агуулж, гарч байгаа СО, энэ нүүрсхүчлийн хийн агууламжийг тодорхойлж гаргаж байгаа. Энэ дээрээ яг стандартын шаардлага хангаж байгаа бүтээгдэхүүнүүд орж ирж байгаа.

Үнийн хувьд бол би тогтоодог хүн биш учраас энэ талаар ярих асуудал байхгүй. Чанарын хувьд бол чанарын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнүүд орж ирж байгаа ийм асуудал байгаа. Тухайн газартаа бол ер нь бол ямар байдаг вэ гэхээр тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа түүхий эдээсээ хамаардаг. Түүхий эд нь хаанаас ямар түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа вэ гэдгээсээ хамаараад олон улсын түвшинд бол 4 төрлийн түүхий эд байгаа. Тэгээд гашуун амттай, чихэрлэг амттай, кофены хатуу, тэгээд зөөлөн гэсэн ийм 4 төрлийг оруулж ирээд тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ ямар төрлөөс нь ямар хэмжээг хийвэл ямар никотинтой, ямар бохитой бараа, бүтээгдэхүүн гарч ирэх вэ гэдэг нь тухайн үйлдвэрлэгч судалгаагаа хийгээд судалгаа хийснийхээ үндсэн дээр тэр түүхий эд болгоноос нь грамм, жинг нь тогтоогоод өгчихдөг. Тэгж

байгаад үйлдвэрлэдэг байгаа. Тэгсний дараа энэ никотин, бохины хэмжээ байх ёстой гээд үзүүлэлт дээрээ байна уу гэдэг ийм асуудал яригддаг.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн нэмж хариулъя.

О.Номинчимэг: Батболд гишүүнтэй бид нар бас хамтдаа тамхи импортлогч үйлдвэрлэгч, вэйпийн үйлдвэрчидтэй төлөөлөлтэй уулзсан. Тэгээд яг үнэнийг хэлэхэд тэд нар бол наанаа хэлж чадахгүй ч гэсэн сүүл рүүгээ бүр тэвчээр алдаад тийм ээ энэ зарим улсуудад үйлдвэрлэж оруулж байгаа бүтээгдэхүүн чинь хамаагүй өөр чанартай байдаг юм. Тэр филтер нь байна уу юу нь байна вэ бүгдийг нь илүү бага орлоготой арай ийм улсуудад зориулаад чанар муутай тамхи бас үйлдвэрлэдэг юм гэдгийг бараг хэлсэн шүү дээ.

Тэгээд манай Монгол улсын хувьд тэд нар энэ тамхи үйлдвэрлэгч нар чинь маш тийм айхтар судалгаатай байдаг. Тооцоо, судалгаа хийгээд худалдан авах чадвар нь хэд юм, орлого нь хэд юм, яаж явах юм бол, хүүхэд, залуучууд ийм их байгаа хүн амын суурь дээр нь хурдан орох уу гэдгээс хамаараад маш тактикийн ажилладаг юм байна лээ. Тэгээд хамгийн хямдхан бодвол тэр чанартай, муу чанартай лайнаараа гардаг бүтээгдэхүүнээ бодвол оруулдаг юм шиг байгаа юм. Хилээр орж ирж байгаа 1 хайрцаг янжуур тамхи чинь бараг 900 төгрөгөөр орж ирж байгаа. Орж ирээд тэр чинь 3, 4 мянгаар зарагдаж байгаа. Ийм л чанартай юм бид нар зарж байгаа.

Тэгээд энэ бол улсад нь тааруулаад маш хямдхан янжуур тамхи оруулж ирж байгаад хэрэглээг нь тэл л гэсэн тамхины компаниудын бодлого. Тэгэхээр таны хэлж байгаа зөв. Би ч гэсэн бас санал хэлж байгаа. Стандартыг нь сайжруулах ёстой. Ядаж тэр арай нөгөө чанартайг нь авах ёстой. Тэгж байж үнэтэй болно. Гэхдээ энийг бас хийхийн тулд бид нар энэ татварын бодлогоороо энд нь хөшүүрэг хийх гэж өгөх ёстой. Тэгээд стандартын асуудлыг бол цаашид анхаар. Болохгүй бол бид нар бараг сонсгол хийж болно. Ер нь та нар Монгол Улсад ямар төрлийн ямар чанартай тамхи оруулж ирээд байгаа юм гэдгийг энэ үйлдвэрлэгч нартай сонсгол хийвэл яасан юм гэдэг ч бас ийм санал гарч байсан. Тэгэхээр энэ бол ялт ч үгүй ийм юм байна лээ. Монгол Улсын иргэдийг чанар муутай ийм тамхиар л хордуулж байгаа асуудал байгаад байгаа юм.

Н.Наранбаатар: Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Нөгөө ажлын хэсгийнхэн гээд асуугаад байгаа чинь бас учиртай. Тэгээд гаалийн лаборатори байж байдаг. Би зүгээр харьцуулаад ядаж үзсэн юм байдаг юм болов уу л гэж асууж байгаа юм. Та гаднын duty-гээс авсан тамхийг янжуурыг тийм Монголд зарагдаж байгаа янжууртай хоёуланг нь харьцуулаад бохины хэмжээ байдаг юм уу тэр үнэр утааг нь үзчихсэн юм байдаг юм уу л гэж асуугаад байгаа юм. Түүнээс биш өөрөөр их юу байхгүй. Манайд орж ирж байгааг бол та нар тэртээ тэргүй шинжилж л байгаа байлгүй. Тэгээд манай өөрийн стандарттай тохирч л байдаг юм байлгүй дээ бодвол. Тэгээд л орж ирдэг байх.

Ер нь бол бид нар үнэтэй тамхиа, чанартай тамхиа утаатай ч байсан, утаагүй ч байсан тэр чанартай тамхиа оруулж ирээд бас арай хор багатай юм иргэддээ өгч байвал яасан юм гэдэг санаа.

Хоёрдугаарт гэх юм бол тамхины үнэ өсөх тусам хэрэглээ багасдаг гэдэг нь бас ерөнхийдөө харагдаад байна л даа. 20, 30 жилийн өмнө гадаад улсад явж байсан тэр үед бол нийтээрээ яг гудамжиндаа тамхи татаад л зогсож байдаг байсан. Тэгээд тухайн газар жишээлбэл Америкийн улсад тэнд чинь 1 хайрцаг тамхи нь 15, тэгээд 15 доллароос дээшээ болчихсон. Харьцангуй гудамжинд тамхи татах юм уу, утаат тамхи татаж байгаа байдал нь хамаагүй багасчихсан байгаа. Тэгэхээр одоо утаатай тамхи татах гэж байгаа бол ядаж бид нар чанартай тамхиа татъя л даа л гэж. Тэгээд үнэтэй болсон ч хамаа алга. Чанартай юмаа оруулж ирээд энэ иргэдээ жоохон арай бага хордуулбал яасан юм бэ л гэдэг санаа хэлэх гээд байгаа юм. Гааль бол тэгж харьцуулж үзсэн юм бол байхгүй байх тээ.

Н.Наранбаатар: Байж байгаарай мик нээнэ. Асуулт ингээд байна шүү дээ. Duty-гийн тамхи энэ манай байгаа тамхи хоёр хор нь хэр ялгаатай вэ л гээд байна.

С.Цэрэнчимэд: Гаалийн төв лабораторийн дарга Цэрэнчимэд. Яг duty-гээс орж ирж байгаа тамхи дээр бид нар бол “Change Esse” дээр хийж үзсэн. Яг шинжилгээний үр дүн бол адилхан гардаг. Никотин нь ч, бохь нь ч гэсэн адилхан гардаг. Түүхий эдийн хувьд яриад байгаа түүхий эд маань өнөөдөр нөгөө филтерээрээ дамжиж гардаг учраас тухайн филтер нь, тухайн түүхий эд нь ямар бүтээгдэхүүнээр үйлдвэрлэж гарч ирж байгаа гэдгийг бол бид нар мэдэхгүй шүү дээ. Бид нар бол шинжилгээ хийгээд гарч ирж байгаа нийт никотины хэмжээгээр л стандарт тавигдаж өгсөн байгаа болохоос биш түүхий эд нь тийм байна гээд стандарт дээрээ тавьсан тийм шаардлага байхгүй. Тэгэхээр яах вэ үнэхээрийн чанартай бүтээгдэхүүн оруулж оруулж оруулж ирье гэх юм бол бид нар түүхий эд дээд дээрээ тавих чанарын хяналтыг сайжруулах шаардлагатай. Тэрийг бол хүлээн зөвшөөрч байна.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Энэ тамхины онцгой албан татвартай холбоотойгоор би тамхи хэрэглэдэггүй учраас танин мэдэхүйн асуулт маягийн юм байж магадгүй шүү. Нэгдүгээрх нь ерөнхий асуулт. Өнгөрсөн жил бид нар чинь нөгөө Евразийн гэрээ соёрхон батлаад 368 ч билүү 370-аад бараан дээр чөлөөт худалдааны гэрээ байгуулсан. Тэгээд тэр хэлэлцэж явж байх үед манай улсын тамхины миний тухайн үед авч байсан мэдээллээр нийт импортын 56 хувь нь Солонгос улсаас, 23 хувь нь Казакстан улсаас орж ирдэг юм байна. Манай улс энэ 2 улсаас үндсэндээ 80 хувь нь л импорт тамхиа авдаг л юм байна л даа. Тэгээд Евроазийн гэрээнд чинь нөгөө Казакстан гол тамхи импортолдог Казакстан улсын тэр нөгөө юунд ороогүй. 24 оны 07 сарын онд 04-нд нөгөө хоёр талаасаа аж ахуйн нэгж татвартай барааныхаа гэрээг нийлэхдээ яагаад тамхины асуудал үлдчихсэн юм мэдэхгүй. Энэ асуудал тэр Тамхины онцгой албан татварын хууль дээр энэ асуудал яригдах уу гэдэг асуудал байна.

Хоёр дахь нь тэр энэ утаат ч гэнэ үү, шингэн ч гэнэ үү тэр хэрэглэдэг төхөөрөмж байх шиг байгаа юм. Тэр дагалдах төхөөрөмж гэдэг юм уу хуучин энгийнээр ярих юм бол гаанс л юм шиг байгаа юм л даа. Тэрийг хилээр оруулж ирэхдээ тамхиар биш электрон бараагаар оруулж ирдэг гэдэг Улсын Их Хурлын дарга тухайн үедээ байсан хүн ярьж байсан. Үүнээс улбаатайгаар хэрвээ онцгой албан татварыгаа авч чадаагүй юм бол яах вэ эрх зүйн зохицуулалт байхгүй л байсан байх л даа. Хэдий хэмжээний боломж бид нар алдав гэдэг хоёр дахь асуулт байна. Хэн нь хариулах вэ?

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Индрийн микрофон дээр хариулъя.

Ч.Чимидсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгээд Евроазийн худалдааны хэлэлцээртэй холбоотойгоор бол бас Улсын Их Хурлын 117 дугаар тогтоол гарсан байгаа. Тэгэхээр тэр хэлэлцээрт хамаарч байгаа 5 орны гаалийн татварыг бол ингээд тэглэсэн. Түүнтэй холбоотой бас энэ ялгавартай байдал үүсэж байгаатай холбоотой асуудлыг Засгийн газар зохицуул гэдэг ийм тогтоол гараад өнөөдөр бид нар Засгийн газрын хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг бол, хуулийн төслийг бол ингээд өргөн барьсан байгаа. Өнөөдөртөө бас Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн байгаа. Энэ дээр бол гол агуулга нь юу вэ гэхээр гаалийн татваруудаа тэглээд тэгэхээр бүх улс оронд бол гаалийн татваргүй тамхи бол орж ирнэ гэсэн үг. Харин гаалийн татварын тэр 30 хувиа онцгой албан татвараараа нөхөөд тооцох гэсэн ийм Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт орж зохицуулж байгаа.

Н.Наранбаатар: Индрийн микрофон нэмж хариулъя.

Ч.Чимгэрэл: Гаалийн ерөнхий газар Чимгэрэл. Электрон барааны хувьд электрон бараагаар орж ирээд татвар авахгүй байна гэдэг асуудлыг бас хөндөж байна. Шинэ төрлийн энэ тамхи чинь өөрөө device-тайгаа хамт нийлүүлэгдэж орж ирдэг. Эсвэл дангаараа орж ирдэг. Тэгэхээр цахилгаан барааны ангилалд ангилаад байгаа учир шалтгаан нь гэвэл өөрөө цахилгаанаас цэнэг авч ажилладаг учраас төхөөрөмж нь цахилгаан тоног төхөөрөмждөө ангилагдаж байгаа.

Шингэн бүтээгдэхүүн нь болохоороо тамхины төрлийн бүтээгдэхүүнтэй ангилж байгаа. Тийм учраас энэ дээр бол гаалийн байгууллага дээр 5-н, цахилгаан тэр төхөөрөмжийн цахилгаан гэдэг ангилалд ангилахаас өөр арга байхгүй. Энэ өөрөө Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан ийм ангилал байгаа. Цаашдаа ч энэ төхөөрөмжийг бид нар цахилгаан барааны ангилалд бол ангилаад явна. Тийм, электрон тамхи гэдгээр ангилаад явна. Цахилгаан бараан дотроо электрон тамхи гээд.

Н.Наранбаатар: Дараагийнх дээр нэмээд хариулна шүү энэ дутуу үлдээсэн. Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би Ганбаатар гишүүнтэй бас төстэй асуулт асуух гэж байсан юм. Евразийн хэлэлцээртэй холбоотойгоор онцгой албан татварын зохицуулалтууд тэнд татварын зөрүүнүүд гарч байгаа учраас энэ нь яг зохицуулалтыг яаж хийх гэж байгаа талаар асуулт асуух гэж байсан. Асуулт давхардчихлаа. Энэтэй холбогдуулаад одоо тэгэхээр яаралтай горимоор Засгийн газраас өргөн барихаар энэ 2 хуулийн төслийг нэгтгэж хэлэлцэнэ гэсэн үг үү? Тэгэхээр нэгтгэж хэлэлцэхээр дахиад энэ хэлэлцэж байгаа асуудлуудаа, энэ бид нарын хэлэлцэж байгаа асуудал маань дахиад дахиж хэлэлцэгдэнэ гэсэн үг үү? Ер нь тэр талаар асуулт байна.

Н.Наранбаатар: Хууль санаачлагч Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ Евроазийн асуудал дээр яг шүгэл үлээсэн хүн нь би. Жилийн өмнө энэ асуудлыг гаргаж тавиад хэлэлцээр батлагдах үед нь ч гэсэн заавал Засгийн газар энэ асуудлаа засаж орж ир 04 сарын 15-нд гэсэн. Орж ирээгүй. Эс үйлдэхүй гаргасан. Тэгээд бүр ингээд ичиж үхмээр шүү гэж бараг

агсам тавьж байж энэ асуудал ингээд өнөөдөр орж ирж байгаа байхгүй юу. Үнэхээр эс үйлдэхүйнүүд энэ тэндээс газраас гарсан.

Тэгэхээр энэ хуулиас болоод бол энэ Тамхины хяналтын тухай хууль цаашаа явах асуудал бол гацаж болохгүй. Тийм ч учраас ажлын хэсэг дээр татвар дээр ажиллаж байгаа ажлын хэсгийн гишүүддээ засаг нэгэнт өргөн барихаар болсон бол энийгээ тусгаад явах нь зүйтэй гэдэг ийм саналыг бас бас хэлж байгаа юм.

Яагаад гэвэл Тамхины хяналтын тухай хуулийг дагаж орж ирсэн Гаалийн хууль, Онцгой албан татварын хууль бүгдээрээ энд хөндөгдөж байгаа учраас яг энэ засгийнхаа саналыг тусгаад шуурхай хэлэлцээд явах нь зүйтэй гэж харж байгаа юм. Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд бас засгаар орсон хуулийг нь харахаар учир дутагдалтай юм байна лээ. Одоо бол гаалийн янжуур тамхи дээр чинь 30 хувь, дээр нь онцгой албан татвар чинь 20 ширхэгт бол 836 төгрөг байгаа шүү дээ. Тэгтэл энэ хүмүүс яаж оруулж ирж байна гэхээр гаалийн 30 хувиа байхгүй болгоод онцгой дээрээ зөвхөн 30 гэхэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чигээрээ явах юм бол нөгөө хуучин байсан онцгойгийнх нь 800 хэдэн төгрөг нь байхгүй болчихоод байгаа юм, багасчхаад байгаа юм. Тэгэхээр энэ мэтчилэн ийм асуудлууд байгаа учраас энэ хуулийн төсөлтэйгөө нэгтгээд саналууд нь бүрэн боломжтой техникийн хувьд болон Дэгийн тухай хуульд болон тэгээд цаг алдалгүй энийгээ нэгтгээд явах ёстой.

Тэгэхгүй бол ийм жижиг сажиг юмнаас болоод, аар саар зүйлээс болоод энэ хуулийг гацаах гэсэн, удаашруулах гэсэн ийм сэдэл бол их олон хүнд байх шиг байна лээ. Тэгээд ийм юм байж болохгүй шүү гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүддээ бас хэлмээр байгаа юм. Тэгээд энэ бүрэн дүүрэн мэдээллээ бас манай ажлын хэсгийн гишүүд бас бас өгөх ёстой. Тэр Ганбаатар гишүүний асуусан асуултад одоо хүртэл тэр 1 удаагийн цэнэглэдэг, 1 удаагийн хэрэглээтэй электрон тамхи чинь электрон бараагаар л орж ирж байгаа шүү дээ. Тэгээд ямар ч онцгой албан татвар байхгүй электрон барааны л хэмжээтэй байгаа. Тэгээд яах вэ тэр олон улсынхаа код дээрээ бол нарийвчилсан бол код байгаад байгаа юм байна лээ. Гэхдээ электрон бараа. Тэрэнд нь тамхины шингэн байгаа. Тусдаа орж ирвэл тэр тамхины шингэн гэдгээрээ 1 удаагийн хэрэглээтэй хамтдаа орж ирвэл электрон бараа л гэдгээр орж ирж байгаа шүү дээ. Тэгээд энэ болгоныг чинь бид нар бүгдийг нь кодыг нь энэ хууль дээрээ, дагасан хууль дээрээ кодуудыг нь нарийвчилж ороод яг хаанаас нь юугаа татвараа авах юм гэдгийг бол нэлээн нарийвчилж орж өгч байгаа гэдгийг бас нэмэлтээр хэлмээр байна.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Тэгэхээр нэгтгээд юу энэ бид нарын хэлэлцэж байгаа хуулийн санаачлагчийн зүгээс Засгийн газрын өргөн барьсан хуулийг нийлүүлж хэлэлцэж байж илүү цогц болно. Энэ хуулийн хэрэгжилтийг бас илүү зөв болгоно гээд. Тэгэхээр бид хэд ингээд хэлэлцэх шаардлага байна уу? Нийлүүлээд нэгмөсөн хэлэлцэх нь зөв биш үү гэдэг бас асуулт байна. Тэгэхээр хэлэлцчихээд дахиад дахиад нийлэхээр нь бас дахиад хэлэлцэнэ гэсэн үг болох уу?

Н.Наранбаатар: Засгийн газраас Онцгой албан татварын тухай хуулийг өргөн бариагүй нөхцөлд хамтатгаж хэлэлцэнэ гэсэн ойлголт байхгүй шүү дээ. Тийм. Манайх бол санал, дүгнэлтээ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд л хүргүүлэх юм.

Дараагийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Энэ харилцааг зохицуулалттай болгохыг бол дэмжиж байгаа. Гэхдээ хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт энэ Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг энд ер нь ажиллаж байгаа юм болов уу? Энэ ажлын хэсгээс энд ахлах ч юм уу, гишүүд нь байна уу? Энд мэдээж энэ дэд ажлын хэсэг байх шиг байна л даа төрийн байгууллагуудаас. Тэгээд тэр ямар явцтай байгаа юм бол?

Хоёрт нь энэ ер нь тоо ширхгээс гадна энэ ийм онцгой албан татвар ноогдуулдаг согтууруулах ундаа, тамхи зэрэг зүйл дээр, архи дээр бол савлагааны хэмжээ, энэ тамхи дээр бол мөн тэр хэрэглэж байгаа тамхины савлагааны хэмжээнээс ноогдуулж ийм шатлалтай татвар ноогдуулбал илүү зөв гэж би бол хувьдаа боддог. Энэ талаар тооцсон зүйл байгаа юу? Яагаад гэхээр аль болох хатуулгийг бууруулахаас гадна, никотины хэмжээг бууруулахаас гадна 1 удаад хэрэглэх хэмжээг бага болгох энэ эдийн засгийн хөшүүргийг бид нар татварын бодлогод тавьж өгөх ёстой.

Тэгэхээр эндээ зүгээр нөгөө яг согтууруулах ундаан дээр бол нэг л юм яваад байдаг. 1 литр тутмаас тэд гээд. Одоо мэдэхгүй бид нарыг бага байхад чинь энэ согтууруулах ундаа чинь пиво гэхэд 0.33, архи гэхэд 0.5 литр бол байсан. Одоо тэгээд хэдэн литр ч болчихоод байгаа юм мэдэхгүй. 2 литр, 5 литр. Тэгээд энийг заавал дуусгаж байж энэ хорт зуршил гэж хэлж болох хэрэглэхгүй байсан ч хүн амьдарч болохоор энэ зүйл дээр л онцгой албан татвар ноогдуулдаг. Тэгэхээр энэ талаар ер нь харсан юм болов уу хууль санаачлагчийн зүгээс? Энэ бол яг л архитай адилхан ингээд л миллилитрийн хэмжээгээр нь, эсвэл ширхгийн хэмжээгээр нь авах гээд байгаа байхгүй юу.

Яагаад ийм уламжлалт ингээд өөрчилж болохгүй, хуучин арга барил дээрээ хэдий болтол явах юм бэ? Нэг. Хоёрт нь.

Гуравд нь энэ лаборатори ер нь цаашдаа чадавх сайжруулах шаардлага байгаа юу? Ингээд одоо болоод байдаг цаашдаа ингээд үр дагаврууд гарна шүү дээ. Энэ асуудал хэрэгжээд эхлэхээр.

Гуравд нь болохоор энэ цаашид ер нь энэ үр дагавар гарах зүйлүүдийг ер нь яаж тооцож байгаа вэ? Яг хэрэгжиж эхэлснээр энэ хууль батлагдвал?

Хамгийн сүүлийнх нь болохоор энэ төхөөрөмж болон тамхийг импортолж байгаа аж ахуйн нэгжүүд, худалдааны байгууллагууд хэрэглэгч иргэдийн зүгээс хэлэлцүүлэг хийсэн, авсан судалгаа, энэ дээр гарсан. гол саналууд нь ер нь юу байдаг юм бол оо? Яагаад гэвэл энэ хуулийг батлахаас энэ хэлэлцүүлгийн шатад энэ талаар Их Хурлын гишүүд бол маш сайн мэдэх хэрэгтэй байх. Тэгэхээр энэ зүйл дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Одоогийн ажлын хэсэгтэй холбоотой бол ажлын хэсгийн гишүүд хариулна биз. Миний хувьд хууль санаачлагчийн хувьд Бадамсүрэн гишүүний асуусан асуултад хариулъя.

Тэгээд таны хэлж байгаа зөв. Яг энэ хэрэглээг багасгахын тулд савлагаа өөрөө стандарттай байх ёстой. Тэгээд энэний дагуу ч гэсэн бид нар яг энэ савлагааны стандартыг энэ хуульдаа 6.7.2-т оруулж өгсөн юм. Бид нарын энэ нөгөө янжуур тамхи дээр бол угаасаа 20 ширхгээс ихгүй байна гэдэг олон улсын стандарт явчихдаг. 100 ширхгээр нь байдаг юм уу, 200 ширхгээр нь савлаж хайрцаглаж болохгүй шүү. Тэгэх юм бол таны хэлдэг шиг тэрийгээ дуусгах гээд, нэг авсан бол тэрийгээ дуусгах гээд явдаг ийм зан үйлийн юм явдаг учраас янжуур тамхи дээр 20 ширхгээс цөөн тоогоор.

Дүнсэн тамхи дээр ч гэсэн бид нар савлагааны стандартыг оруулж өгсөн шинээр 200 граммаас багаар савлана. Дүнсэн тамхины хувьд ч гэсэн яг энэ хэрэглээний асуудал байгаа.

Шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн буюу тэр электрон тамхины хувьд бол яг бид нар энэ дээр нөгөө манай сая ажлын дэд хэсгээс хариуллаа. Одоо чинь манайд бол Хятадын хэдхэн үйлдвэрээс зах замбараагүй, ямар ч стандартгүй бүтээгдэхүүнүүд орж ирж байгаа. Хятадын ер нь 5 бүтээгдэхүүнээс манай зах зээлд 98 хувь нь орж ирж байгаа байхгүй юу. Хятад дотроо хорьчихсон зөвхөн экспортын шинж чанартай гадаад улсад гаргадаг.

Тэр нь ёстой нөгөө никотины хэмжээ нь 20 ширхгээр янжуурынхаас хэд дахин өндөр ч юм байна. Тэгээд тэнцүү ч байна. Бага ч байна. Ерөөсөө энэ дээр нөгөө ямар нэгэн стандарт байхгүй болохоор соск шиг угжаад байх юм бол нөгөө янжуурын юу гэдэг юм 1 хайрцаг биш бараг 4 хайрцгийг татсантай хэмжээтэй никотиныг бас авах ийм боломжтой савлагаануудтай байгаа. Тэгээд энийг шийдэх гээд угаасаа Европын холбооноос савлагааны стандартыг гаргасан байдаг (EU) director-оор.

Тэгээд энийг бид нар бас Монгол улсдаа авъя. Электрон тамхины шингэний хэмжээ энэ 2 миллилитрээс илүүгүй, цэнэглэгч шингэнийх нь савлагаа нь 10 миллилитрээс илүүгүй. Тэгээд шингэн дэх никотины агууламж нь 1 миллилитрт 20 миллиграммаас илүүгүй байна гэдэг никотиных нь бүүр стандарт дээд хэмжээг нь оруулаад өгч байгаа юм. Ингэж байж бид нар нөгөө ямар ч нөгөө мэдрэмжгүй зан үйлийнхээ зүгээр соск шиг татаад ингээд их хордоод байх асуудлыг нь хязгаарлах савлагаа болон никотины хэмжээний энэ стандартыг бол энэ хуулиараа оруулж өгч байгаа юм. Ингэж байж бид нар татварынхаа бодлого, эрүүл мэндийнхээ бодлого хамгаалах энэ бодлого руугаа явна гэж харж байгаа.

Тэгээд хяналтын энэ хууль батлагдсаны дараа гол асуудал бид нар бас оруулж өгсөн юм нь архи дээр хэрэгжиж байгаа энэ акцын асуудал байгаа. Одоо бол нөгөө хуурамч архи байхгүйн тулд үйлдвэрлэгчтэй нь яриад импортын хувьд ч гэсэн татварын газраас онцгой ийм бар кодтой акц хийдэг. Энийг ч гэсэн энэ тамхин бүтээгдэхүүнүүд дээр оруулж өгч байгаа.

Тэгэхээр гаалийн байгууллагаас татварынхан маань тухайн үйлдвэрлэгчдээ манай Монгол Улсад бол үйлдвэрлэгч ганц, хоёрхон байгаа шүү дээ. Үйлдвэрлэлийн хэмжээ нь бага. Ихэнх нь дандаа импорт юм байхгүй юу. Тэгэхээр эд нар үйлдвэрлэгчдээ тэр акцаа нийлүүлж, хуурамч тамхи орохоос сэргийлнэ. Яг стандартын дагуу тэр электрон тамхи нь хийгдэж байна уу гэдэг дээр стандартаа тавиад өөрөө акцаа өгөх энэ нөгөө төрийн байгууллага хоорондын үйлдвэрлэгчтэй

холбогдох тэрүүгээрээ хянах ийм механизм нь бас бий болж өгөх юм. Ингэж бид нар бас хяналтаа хийнэ гэдгийг хэлмээр байна.

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Стандарт тогтоож байгааг бол 100 хувь дэмжиж байна. Гэхдээ миний асуугаад байгаа асуулт нь өөрөө яг энэ савлагаа бага болон агууламж бага тохиолдолд яаж бага татвараар энийг эдийн засгийн аргаар энийг хор хөнөөлийг нь бууруулах бодлого барих юм бэ гэж асуугаад байгаа байхгүй юу энд татварын хууль дээр? Зүгээр ингээд энд чинь байна шүү дээ хар аа бүх төрлийн тамхи, тамхины шингэн 1мм-т ногдох татвар, онцгой татвар. Төхөөрөмж, дагалдах хэрэгсэл 1 ширхэгт ногдох тэгээд энэ уламжлалт юмаа өөрчлөхгүй юм уу л гээд байгаа байхгүй юу. Тэгээд том ийм татдаг төхөөрөмж болон 1 тамхи нь их хэмжээнд агууламжтай ийм байвал энэ бага байсантайгаа адилхан татвар ноогдох юм бол энэ ямар ч эдийн засгийн хөшүүрэг, эдийн засгийн аргаар энэ дээр татвар ноогдуулж байгаа бодлого биш болох байхгүй юу. Тэгээд би энийг л асуугаад байгаа юм. Яг энэ дээр тодорхой.

Дээр нь би зөндөө асуулт асуусан. Байнгын хорооны даргад хэлэхэд энэ дээрээ хариулт авмаар байна. Яг гол тодорхой хариулт. Янз бүрийн тайлбаргүйгээр энэ хэрэгжээд эхлэхээр гарах үр дагаврыг тооцсон уу? Мөн импортолж байгаа аж ахуйн нэгжүүд, хэрэглэгч, худалдааны байгууллагууд ямар саналтай байгаа юм? Мөн лабораторийн хүчин чадал чинь цаашдаа юу сайжруулах юм тэгээд энийгээ ингээд хамтад нь авч явахгүй болохоор тэгээд хууль батлагдаад гардаг тэгээд л дараа нь дахиад л ийм хууль хэрэгжих болохоор үр дагавар гараад л. Тэгээд л энийгээ ингээд хамтад нь эхнээс нь системээр нь цуг тооцоод нэг мөр шийдвэрлэх нь зөв үү? Ингэж бид нар гарах үр дагавартай нь хамт харах ёстой гэдэг л ийм байдлаар би асуугаад байгаа юм. Энд хангалттай хариулт авмаар байна.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр тийм Бадамсүрэн гишүүний хэлж байгаа та тэгэхээр бид нар чинь савлагаа никотины хамгийн дээд хэмжээг заагаад өгчхөж байгаа шүү дээ. Тэгэхээр никотин нь бага байх юм бол арай бага татвар авъя гэдэг логик явж байна гэж ойлголоо. Зөв үү? Тэгэхээр, тэгэх юм бол янжуур тамхи дээр ч гэсэн бид нар хамгийн дээд талдаа никотин 5 билүү, 8 билүү таар нь тэд байна гэдэг стандарттай дээд талыг нь. Тэгэхээр тэрнээс бага байх юм бол янжуур тамхи дээр ч гэсэн онцгой албан татвар дээр өөр болон шатлалтай гэдэг юм орж ирэх гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ ийм юм байна лээ л дээ эрүүл мэндийн бодлого талаасаа бол тамхин бүтээгдэхүүн. Тэр чинь бол нөгөө дадал үүсгэж байгаа, донтолт үүсгэж байгаа арга хэлбэр эд нараасаа хамаараад тэр шатлалтай байх биш. Ер нь бол дэлхийн улс орнууд бол дээд стандартаа гаргаад өгчихдөг. Энэ дотроо тэр татварынхаа нэгдсэн бодлогоороо хэрэглээг багасгах гэдэг ийм л бодлого байдаг. Тэгээд эдийн засгийн арга гэдэг бол энэ донтолттой тэмцэх, донтох бүтээгдэхүүнтэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга гэдэг нь дэлхий дахинаа батлагдчихсан. Тамхины үнэ өсөх тусам ялангуяа хүүхэд, залуучуудын хувьд, байнгын орлогогүй хүүхдүүдийн хувьд бол энэ бүтээгдэхүүн рүү татагдах, орох хүртээмж нь багасах явдал бол маш сайн үр нөлөөтэй байдаг гэдгийг бол бид нар

судалгаагаар дэлхий дахинд ч гэсэн харсан. Монгол Улсад ч гэсэн энэ pattern бол ажиглагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ бол тийм бодлого бол дэлхий дахинд байхгүй ингэсэн. Хэлэлцүүлгийн явцад би хууль санаачлагчийн хувьд бас энэ асуудлыг хэлж байхад олон газраас санал ирсэн. Яах вэ тамхи импортлогч нараас, үйлдвэрлэгч нараас гээд. Тэгэхээр мэдээж эд нар бол бизнесийн эрх ашгаа хамгаалахын тулд саналуудаа өгдөг. Гэхдээ бид нарын Тамхины хяналтын тухай хуульд, бид нарын нэгдэн орсон энэ конвенцод олон улсын конвенцод дэлхий дахинаа тамхи үйлдвэрлэгч, импортлогч нар маш хүчтэй лобби явуулдаг учраас төрийн бодлого гаргахад Тамхины хяналтын тухай хууль боловсруулж явж байхад яг энэ импортлогч үйлдвэр, үйлдвэрлэгч нараас ашиг сонирхлын зөрчилтэй санал ирэх юм бол авахаас татгалзах үүрэгтэй гээд бид нарт үүрэг байдаг байхгүй юу. Тэгэхээр бид нар бол ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд бид нар авч бүгдийг нь уулзаж саналыг нь сонссон. Энэ дээрээс бол.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гааль. Дэгээрээ л явна. 2 удаа асууж 2 удаа хариулт өгөх ёстой. Индрийн микрофон өгье.

С.Цэрэнчимэд: Би болохоор энэ гаалийн лабораторийг чадавхжуулах шаардлагатай гэдэг тал дээр хэлмээр байна. Мэдээжийн хэрэг энэ тамхины ялангуяа энэ шинээр орж ирж байгаа энэ бүтээгдэхүүн дотор, вэйп дотор маань ганцхан никотин биш өшөө дээрээс нь глицерин, пропилен гликол, тэгээд амт, үнэр оруулагч гээд олон химийн бодистой нэгдлүүд байгаа. Тэгэхээр энийг бид нар нарийн шинжилдэг болохын тулд чадавхжуулах шаардлагатай. Олон лабораторийг бас чадавхжуулж байж өнөөдөр энийгээ хийж, хяналтаа тавих ёстой.

Дээрээс нь бас тамхины бүтээгдэхүүн, тамхин бүтээгдэхүүн дотор байгаа ялангуяа янжуур тамхи дотор байгаа бид нар пестицитийн үлдэгдлийг илүү нарийн тодорхойлдог болох ёстой юм байгаа юм. Тэгж байж өнөөдөр нөгөө түрүүний яриад байсан түүхий эд чинь, тамхин бүтээгдэхүүний чинь түүхий эд чинь пестицитийнхээ үлдэгдлээр хэр зэрэг сайн чанартай тамхин бүтээгдэхүүн байгаа вэ гэдгийг тодорхойлох боломжтой учраас энэ лабораторийн чадавхыг бол бас сайжруулах шаардлагатай гэдэг дээр гэж хэлмээр байна.

Түрүүн би бас дараачийн хоёрдугаар асуудал нь болохоор Номинчимэг гишүүний хэлсэн дээр хэлмээр байна. Юу гэж хэлж байгаа вэ гэхээр ер нь вэйп тамхиууд маань никотины агууламж нь 2 процент анх орж ирж байсан 3 процент, 5 процент болсон. Тэгэхээр бид нар бол никотиныхаа агууламжийг энд 20 миллиграмм гэж бууруулж хамгийн эцсийнх нь 2 процентээс ихгүй байна гэж хамгийн доод талынхыг нь тавьж өгсөн.

Тэрнээс биш 3 процент, 5 процентыг аль болохоор хязгаарлаад аль болохоор тэр өндөр никотинтой тамхийг оруулж ирэхгүй байх талаас нь оруулж ирсэн байгаа.

Н.Наранбаатар: Үлдсэн хариултуудыг нь бичгээр гүйцээнэ. Дэгээрээ 2 болчихсон шүү дээ. Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Минут явчхаад байна би 5 секунд алдчихлаа шүү. Би бас Номинчимэг гишүүн ахалсан энэ ажлын хэсэгт байсан. Эхэндээ 6, 7 гишүүн байсан. Тэр гишүүдийн нэг гэсэн үг.

Олон удаагийн уулзалт болсон. Номинчимэг гишүүн ахлаад дэд ажлын хэсэгтэйгээ энэ олон байгууллагуудын төлөөлөл орсон дэд ажлын хэсэгтэй нэлээн сайн суусан гэж ойлгож байгаа. Яагаад энэ электрон тамхины асуудал үүссэн бэ гэхээр хамгийн энгийн. Бид нар бүгд томчууд буюу аав, ээжүүд байхгүй юу. Тэгээд гол зорилго нь ерөөсөө ялангуяа өсвөр насны хүүхдүүдийг энэ хорт бодисоос хамгаалах ийм зорилготой нэг.

Хоёрдугаарт өсвөр нас байтугай 7, 8, 9, 10 настай хүүхдүүд хэрэглээд байна. Зөндөө статистик явсан та нар анзаарсан байх. Хөвгүүдийн 4 хүүхэд билүү 3 хүүхэд тутмын 1 нь охидууд арай 1 тоогоор бага ийм байна. Ийм асуудал хөндөнгүүт нөгөө талдаа энэ чинь янжуур тамхийг бодвол хоргүй ч гэж байх шиг. Сүүлийн үед бүүр их тоо явж байна лээ. Хортой. Хортойг зөндөө яриад эхэлсэн байна лээ жил гарангын дараа. Бид нар энийг жилийн өмнө хөндсөн асуудал.

Ингээд why, яагаад гэдгийг ингээд товчхон дурдчихъя. Хоёрдугаарт угаасаа энэ чинь толгой эргүүлсэн юм байна лээ. Ялангуяа тамхи татдаггүй бид нарт яг юу юм, янжуураас ялгаатай нь юу юм, ямар хэлбэрээр орж ирдэг юм, орж ирэхдээ ямар шингэнийг яаж оруулж ирдэг юм, шингэнгүй орж ирдэг юм уу, шингэнтэй орж ирдэг юм уу 9-н жор. Зөндөө ярьсан. Ярьсны эцэст янжуур тамхитайгаа дүйцүүлээд янжуур тамхинд ногдсон тэр татварын төрлүүдтэйгээ дүйцүүлээд харин ч аажуу жигд замаар 2030 он хүртэл нэмж байгаа. Хоёр. Тэгэхээр мушгих асар боломжтой гэсэн үг. Манипуляц хийх.

Тэгэхээр зүгээр наад захын энэ зохицуулалтыг хийж байгаа гээд л ойлгочих. Зөвшөөрөлтэй болгоё, тодорхой хэмжээний татваруудтай болгоё, өсвөр үе, хүүхдүүдээ хамгаалъя.

Гурав. Бадамсүрэн гишүүн тэргүүтэй бусад гишүүд асууж байна. Хэлэлцүүлэг хийсэн юм уу? Хийсэн. Маш олон янзын хэлэлцүүлэг хийсэн. Олон улсын хурал 2 удаа хийсэн. 01 сарын 27, 28 миний санаж байгаагаар энэ оны эхэнд. Тэгээд энэ чинь зөвхөн Монголын асуудал биш дэлхий дахины асуудал бөгөөд маш олон улсад энийг чинь бүүр манайхаас олон дэвшилтэт алхмуудыг хийчихсэн байгаад байгаа юм. Манайх хойноос нь ингэж гүйцэх гэж явж байна.

Түрүүн бас зарим гишүүд асууж байсан. Камбужи ч гэдэг юм уу өөрсдөө тамхи үйлдвэрлэхдээ энэ төрлийн өөрсдөө хэрэглэхгүй хориглохгоод манайх мэтийн улсууд руу хяналтгүй, зохицуулалтгүй газар руу гаргаад байна шүү дээ. Тэгэхээр бүгдээрээ хамгаалъя гэдэг л ийм утгатай.

Тэр хэлэлцүүлэг дээр би санаж байна Номинчимэг гишүүн өрөөндөө тэр тамхи үйлдвэрлэгчдийг аваад уулзсан, бид нар мэтгэлцсэн, ярилцсан юмнууд байгаа шүү. Зөндөө юм хийсэн. Тэр болгоныг тоогоор дурдах юм уу яах юм.

Тэгээд би өнөөдөрхөн даанч энэ болох гэж байсан юм байна анзаарсангүй тэр гаднын тамхины компани энэ тэр дээр яваад л байна шүү. Ингэж болохгүй арай хэтэрч байна гэж би хэлс.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хурлын ажлын хэсэг Баасанжаргал гишүүн хариулна.

Х.Баасанжаргал: Бүгдээрээ сайн байцгаана уу? Манай ажлын хэсэг ажиллаж байгаа. Дотроо дахиад 3 дэд ажлын хэсэг хуваагдаад Баярбаатар

гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг яг энэ лаборатори, чанар дээр нь ажиллаад өнгөрсөн долоо хоногт лаборатори дээр очоод ингээд энэ бүх стандартуудтай танилцаад, нөхцөл байдалтай танилцсан байгаа.

Жаргалан гишүүнээр ахлуулж байгаа яг эдийн засаг, татварынх нь ажлын хэсэг ахлаад ажиллаж байгаа. Жаргалан гишүүн ахлаад ажиллаж байгаа. Энэний өмнөх шөнө тэд нар бараг 12, 1 хүртэл тэдний ажлын хэсэг хуралдаад бүх санал, зарчмуудаа нэгтгэсэн байгаа.

Ингээд өчигдөр орой манай ажлын хэсэгт шөнийн 12 цаг өнгөрч байхад 11 цагийн үед хамгийн сүүлийн байдлаар зарчмын зөрүүтэй 22 санал ирсэн. Ингээд энэ бүхнийгээ нэгтгээд яг өнөөдөр ингээд 11 цаг ажлын хэсэг хуралдана гэж байсан чинь энэ байн Төсвийн байнгын хороо руу бас давхар орох гэж байна гээд би наашаагаа ороод ирлээ. Бид нар бол энэ манай ажлын хэсгийн хувьд бол энэ хавартаа багтаагаад энэ чуулган хаахаас өмнө энэ хуулийг батлуулъя гэж хичээж, чармайж ажиллаж байгаа.

Тэгээд энд бол ерөөсөө маргаад байх ямар ч шаардлагагүй асуудалгүй. Тэртээ тэргүй хортой асуудал. Дээрээс нь хүүхдийн хөгжлийг дэмжих тухай олон асуудал, олон хуулийг бид нар хэлэлцдэг хэр нь хөгжилд нь хамгийн саад болж байгаа донтолтын асуудал дээр бид нар ингээд тээглээд хэвтээд байж бол яагаад ч боломгүй зарчмын хувьд. Бүүр яагаад ч энэ чинь зөвтгөх ямар ч үндэслэл байхгүй шүү дээ. Маргах ямар ч үндэслэл байхгүй шүү дээ. Тэгээд татварыг нэмэхгүй хямдхан байж байг л дээ тамхи гэж тамхийг өмөөрөх яг ямар үндэслэл байгаа юм? Яг ямар зөвтгөх шалтгаан байгаа юм? Ямар хамгаалах шалтгаан байгаа юм? Би бүүр ерөөсөө ямар ч логик эндээс харахгүй байгаа байхгүй юу. Тийм тэгээд хүмүүс тэр хорыг илүү үнэтэй худалдаж авдаг бол оо. Энэ хорноос бид нар ангижруулъя. Хүүхдүүдээ хамгаалъя. Өсвөр үеийг ийм ялангуяа амт, үнэртэй ийм тамхи, тамхин бүтээгдэхүүнээр дамжуулаад энэ донтолт эрт үеэс эхлээд байгааг зогсоохгүй бол энэний араас хар тамхи орж ирнэ шүү. Дээрээс нь энэ тамхитай цахилгаан тамхитай хамт хар тамхины янз бүрийн зүйлүүд орж ирж байгаа. Тэгээд энийг бид нар ингээд зогсоохгүй юм бол энэ бол асар том эс үйлдэл болно шүү манай Их Хурлын хувьд. Энийгээ бас гишүүд бас бүгдээрээ ойлгож байгаа байх гэж найдаж байна.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл харин анхны хэлэлцүүлэгт орж ирэх гэж багагүй хугацаа өнгөрлөө. Бид энэ хуулийг аль болох хурдан батлах ёстой. Өнөөдөр өөрсдийгөө хянах чадвартай нас биед хүрсэн хүмүүсийн хэрэглээний асуудал бол дараагийн асуудал. Яг энэ тамхины, энэ электрон тамхины өнгө, үнэр, амтанд, дээр нь хямдхан байгаад нь хууртаж хэмжээ хязгааргүй, үр дагаврыг нь мэдэхгүй хэрэглэж байгаа энэ хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал хамгийн ноцтой асуудал болоод байна шүү дээ.

Энэ эрүүл мэндийн салбарын уушгины мэргэжлийн эмч нар бол яг үнэндээ үгээ хэлж байна. Аргаа барж энэ асуудалд анхаарч өгөөч гэдгээ эмэгтэй гишүүдэд уламжилж, дамжуулж байна. Тэгэхээр энэ Тамхины хяналтын хуулийг дагаж орж ирж байгаа бусад хуультай ч холбоотой гэдэг юм уу зарим зүйл, заалт өөрчлөх асуудлууд мэдээж Улсын Их Хурлын гишүүний гишүүдийн бүрэн эрхийн асуудал.

Зарчмын зөрүүтэй саналаа гаргаад л, саналаа хураалгаад л шийдээд явах хэрэгтэй.

Яг энэ хуулийн хэрэгжилтийг хангах хугацааг 1 сарын өмнө ч гэсэн бид нар гаргаж байж. Хэдэн мянган хүүхдийн амь, амьдрал эрүүл мэнд, цаашдаа Монгол Улсын иргэд, ирээдүйн иргэд энэ улс орныг авч явах үр хүүхэд эрүүл саруул байх уу үгүй юү гэдгийг л бид нар өнөөдөр ярьж байгаа гэж бодож байгаа шүү дээ. Бид яах вэ энэ хуулиар бүгдийг нь шийдэж чадахгүй л дээ. Нэг хэсэг нь худалдаж авах л байх үнэтэйгээр нь. Гэхдээ л хавтгайрсан хэрэглээг бууруулах хамгийн эхний алхам бол энэ л байна шүү дээ.

Үүнийг дагаад цаашдаа энэ төр захиргааны байгууллагын зүгээс тавьдаг хяналт, стандарт, норм дүрмийн мөрдөлт энэ зүйлүүдээ бол сайжруулах зайлшгүй шаардлагатай. Тэгээд би гаалийн байгууллагаас надад бас асуулт байгаад байна. Номинчимэг гишүүн сая тодорхой хэллээ одоо орж ирж байгаа энэ электрон тамхи, тэр төхөөрөмж дотор байгаа шингэнтэйгээ хамт орж ирэхдээ цахилгаан бараагаар орж ирээд байгаа юм уу, 1 удаагийн тамхи ч гэсэн? Яагаад тийм байхад цаашдаа ч бид нар цахилгаан барааны ангилалд байна гэж хариулаад суугаад байгааг би сайн ойлгохгүй байна. Энийг надад тодорхой болгож өгөөч өө. Цаашдаа бид нар энэ ангиллыг нь яаж өөрчлөх юм? Дагалдах төхөөрөмж буюу таны хэлээд байгаагаар тэр цэнэглэдэг төхөөрөмж чинь, тогонд залгадаг төхөөрөмж чинь дотроо ямар нэгэн шингэнгүй дангаараа орж ирэхээрээ цахилгаан бараа байж болно. Дотор нь тэр шингэн нь орж ирээд тамхи болчихоод байхад яахаараа цахилгаан бараагаар яваад байгаа юм? Тэгээд яагаад цаашдаа ийм байна гэж хэлж байгаа юм? Энийг би сайн ойлгохгүй байгаад байна. Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Н.Наранбаатар: Индрийн микрофон дээрээс хариулъя.

Ч.Чимгэрэл: Гаалийн ерөнхий газар Чимгэрэл. Яагаад цахилгаан бараагаар ангилаад байгаа вэ гэхээр энэ дэлхий дахиндаа Дэлхийн гаалийн байгууллагаас цахилгаанаас цэнэг авдаг электрон янжуур гэдэг тусдаа ангиллын кодыг нь гаргаж өгсөн юм. Энэ бол ганцхан Монгол улс хэрэглэж байгаа биш бусад улс оронд ч гэсэн хэрвээ цахилгаанаасаа цэнэг аваад нөгөө цэнэглэх шингэнээ дахин дахин хийж цэнэглээд байдаг төхөөрөмжтэйгөө электрон тамхи бол цахилгаан барааны ангилал дотроо электрон тамхи гэж орж ирж байгаа.

Хэрвээ шингэн нь тусдаа, дангаараа худалдаанд орж арилжаалагдаж байвал энэ бол тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан тамхин бүтээгдэхүүн буюу тамхин бүтээгдэхүүний ангилалд хамт орж ирж байгаа. Тийм учраас бид нар энэ дэлхий дахинд гарсан энэ ангиллыг Монгол Улсын үндэсний хэмжээнд бол өөрчлөх боломжгүй л гэсэн ийм хариултыг хэлсэн юм.

Н.Наранбаатар: Тэгвэл Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Яах вэ бид нар чинь Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар энэ тэр аягүй олон ангилал, дүрэм, журам гаргаад л мөрддөг шүү дээ. Яагаад энийг ангилчхаж болохгүй байгаа юм? Хэрвээ дотроо шингэнгүй орж ирж байгаа бол цахилгаан бараагаараа аваад, дотроо шингэнтэй байгаа бол энийг тамхи гэдгээрээ тэр та нар нэмэгдсэн, нэмүү өртгийн татвар тооцдог энд, онцгой албан татварт тооцдог энэ ангилал руугаа оруулчих юмыг байгууллагынхаа та хэд чинь баахан журамладаг журмаараа хийчхэж болохгүй байгаа юм уу? Хэрвээ

шаардлагатай бол энийг өөрчлөх эрх зүйн актыг нь санаачилж болохгүй байгаа юм уу? Яагаад заавал ийм байх ёстой учраас бид нар ингээд явна гээд байгаа юм бэ? Би энийг ерөөсөө ойлгохгүй байгаа юм.

Дотроо шингэнтэй байгаа тамхийг электрон, цахилгаан бараа юм. Энэ цахилгаан залгадаг учраас гээд. Яагаад бид нар энийг ийм хайрцаг дотроосоо гарч чадахгүй гаднын улс орны юмыг шууд заавал бид нар мөрдөх ёстой, ийм байх ёстой гээд суугаад байгаа юм? Би энийг ойлгохгүй байна. Энэ дээр тийм боломж байхгүй юм уу? Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх боломж байхгүй юм уу? Цаашдаа ийм байна гэдэг чинь энэ хуулиар орж ирж байгаа зүйл, заалтыг гаалийн байгууллага мөрдөх боломжгүй гэж хэлээд байна уу гэж би хараад байна шүү дээ. Энэ дээр тодорхой тайлбар өгөөч. Би цаашдаа ч энэ ангиллаараа бүртгэгдэнэ гэдгийг чинь л би асуугаад байгаа юм л даа.

Н.Наранбаатар: Индрийн микрофон хариулах уу? Тэгэх үү хэн хариулах вэ? Тэгье индрийн микрофоныг өгье. Хууль санаачлагч Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Энэ хуультай дагалдаж орж ирээд Улсын Их Хурлын тогтоол байгаа. Импортын барааны гаалийн албан татвар хэмжээ өөрчилж байгаа. Энэ дээр ингээд харах юм бол энэ БТКУС, үндэсний код, БТКУС код гээд энэ олон улсдаа гаалийн байгууллагын хэрэглэдэг код байдаг юм байна. Тэрүүгээрээ цаанаасаа 24 болон 85 гэдэг энэ кодууд дээр яг энэ электрон тамхины ямар төрөлтэй байгаагаас хамаараад хуваагаад ингээд ангилчихдаг юм байна. Тэгээд 240412 код дээр бол никотин агуулсан 1 удаагийн электрон тамхи, цэнэглэдэг шингэн нь орчихдог. Тэгтэл 85-ын код буюу 854340 дээрээ электрон тамхины хэрэгсэл шингэний хамт тамхины цахилгаан халаагч эд нар нь гээд бас юман дээр орчихдог.

Гэхдээ код нь цаанаасаа тийм боловч бид нар энийг тамхи гэж үзэж байгаа. Тамхи гэж үзэж байгаа болохлоор албан гаалийн албан татвар нь бүгдээрээ адилхан 30 хувь болж тавигдаж байгаа. Тамхи гэж үзэж байгаа болохоор яг энэ кодоор орж ирж байгаа бүтээгдэхүүнүүдэд бүгдэд нь онцгой албан татвараа өгч байгаа. Монгол улсын хувьд энэ бол тамхин бүтээгдэхүүн.

Гэхдээ кодын ангиллын хувьд олон улсын БТКУС кодоороо 2 ингэж өөр ангилалд орж ирж байгаа. Энэ нь хянах боломжтой. Үүгээрээ яваад бид нар яг тамхин бүтээгдэхүүн бүгдэд нь адилхан гаалийн албан татвар, онцгой албан татвар нь тавигдаад явна гэсэн үг.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Би яах вэ ингэж хэлээд байгаа байхгүй юу. Би наадхыг бол энэ заалтыг мэдэж байна Номинчимэг даргаа. Яг энэ заалтыг хуулийн төсөл батлагдаад орлоо гэхэд энэ орох ёстой шүү дээ. Гэтэл гаалийн байгууллагаас болохоороо бид өнөөдөр тогонд залгадаг учраас цахилгаан гэдэг ангилалд авч явж байгаа. Цаашдаа ч бид нар энэ ангиллаараа авч явна гээд түрүүн хариулчихна лээ л дээ. Тэгээд би тэр дээр л асуугаад байгаа байхгүй юу. Хууль батлагдаад гардаг гэтэл гаалийн байгууллага чинь бид ол олон улсынхаа энэ худалдааны энэ БТКУС код энэ юмаа барих ёстой гээд ингээд яваад байх юм биш биз дээ? Энэ дээр зөрчил үүсэх гээд байгаа юм биш биз дээ гэдэг юмыг л асуугаад байгаа юм.

Н.Наранбаатар: Индрийн микрофон хариулья.

Ч.Чимгэрэл: Энэ өөрөө барааг тодорхойлох кодлох уялдуулах системийн тухай олон улсын конвенцоор энэ барааны ангиллын код бол зохицуулагдаж явж байгаа. Тэгэхээр Монгол Улс 1991 онд энэ конвенцод нэгдэж орсон. Гэхдээ бид нар үндэсний кодынхоо түвшинд бол задаргаагаа хийгээд энэ хууль хэрвээ өргөн баригдаад батлагдах юм бол Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаараа үндэснийхээ зохицуулалтыг хийгээд явна.

Харин яг нөгөө хамтдаа орж ирж байгаа цахилгаанаасаа цэнэг авч ажилладаг тэр бүтээгдэхүүн маань олон улсынхаа ангиллын кодоор яваад үндэсний хууль тогтоомж дээр онцгой албан татвартай юман дээр бид нар үндэсний кодын 2 задаргаа хийж өгч байгаа.

Тэгэхээр гаалийн байгууллагын хувьд бол улсын хилээр орж ирж байгаа тохиолдолд ямар нэгэн асуудал гарахгүй. Энэ өөрөө цаашаа конвенц учраас бид нар конвенцынхоо зүйл, заалтын дагуу нийцүүлж явж байгаа л гэж ойлгох хэрэгтэй. Аль аль нь ерөөсөө бүгд конвенцын зүйл, заалтаар зохицуулагдаж явж байгаа учраас бид нар цаашдаа ч бас ингэж явна гэж хэлсэн байгаа.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг нэмээд хариулчих. Ингээд нэмэлт асуулт дууссан шүү дэгээрээ. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Үүрийнтуяа гишүүний асуулт ингэж асуугаад байх шиг байна. Цахилгаан барааны ангиллаар бүртгэдэг юм бол бид нар эндээс чинь энийгээ та нар шууд тамхиныхаа ангилал руу орчхож болохгүй юм уу, энэ ангилал чинь өөрчлөгдөхгүй юм уу гэж асуугаад байна шүү дээ. Зөв үү тээ? Тэгэхээр энэ ангилал өөрөө олон улсынхаа конвенцоороо энэ ангилал ерөөсөө өөрчлөгдөхгүй. Still цахилгаан, бараа, цахилгааны тэр ангилал олон энэ кодоороо бүртгэгдээрээ бүртгэгдэнэ. Гол нь бид нар дотоодынхоо хууль тогтоомжоор энэ ангилалд бүртгэгдсэн энэ энэ бүтээгдэхүүнийг бид нар тамхины ангилалд оруулна гэж нэгдүгээрт хуульчилж өгөөд.

Хоёрдугаарт зөвхөн хууль тогтоомжоороо бид нар татвараа тогтоох учраас эд нар дураараа тэрийг өөрчилж чадахгүй байхгүй юу. Хуульд гарч байж энэ нь өөрөө тамхины ангилалд, цахилгаан бараа хэр нь тамхины ангилалд ороод нэмээд онцгой албан татвараа тавих эрх нь нээгдээд эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр нөгөө цахилгаан бараан дээр нэмэх нь бид нар онцгой албан татвар авна л гэсэн ийм төрөл болж байгаа гэсэн үг.

Н.Наранбаатар: Дараа дараагийн зүйлүүд дээр асуулт асууж болно. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санаачлагчийн нэг нь би мөн. Гэхдээ бид хэд их зөв ойлгох ёстой. Хэн нэгэн энэ өнөөдөр энд бас ойлголтын зөрүү юмнуудаа нэгтгэх гээд асуултууд асуугаад байна шүү дээ. Тэрүүнд бид зөв л хариулах ёстой. Ойлголтоо нэгтгээд энийг гаргах ёстой. Үнэхээрийн хорт зуршилтай, бас хүний биед сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн учраас үүн дээр бид онцгойлон анхаарал хандуулж онцгой татвар ноогдуулах гээд байна шүү дээ. Энэ юмнуудаа зөв болгож.

Тэгэхээр архи, тамхи хоёр хоёулаа ижил. Гэхдээ архи гэдгийг бид нар согтууруулах ундаа гэж ярьдаг. Хатуулаг, зөөлөнтэй дээр нь татварын бодлого арай өөр. Хатуулаг өндөртэй дээр нь татварын бодлого арай өөр. Тэгэхээр тамхи дээр ирээд буухаараа никотины хэмжээнээс хамаараад байгаа байхгүй юу. Адилхан 2 миллилитрээр савлагдсан ч байлаа гэсэн 0.1-ээс доош никотинтой бол нэг өөр татвартай. 0.1-ээс дээш бол татвар ахиу байх тухай ойлголт байгаад байгаа байхгүй юу.

Хэрэглэж болно хүн. Гэхдээ аль болохоор тэр хүний биед очих хор хөнөөлийг нь бууруулах гээд байгаа байхгүй юу. Энэ үүднээсээ бодож энэ асуудлыг бид ер нь анхаарах ёстой байхыг үгүйсгэхгүй. Одоо байж байгаа нь миллилитрээр яваад байгаа ухаантай юм бол тэр дотроо давхар энэ үзүүлэлтээ авч үзэхийг үгүйсгэхгүй. Инээх юм биш ээ энэ угаасаа тийм зүйл байхгүй юу. Бид тэр талаас нь л асуудалд ярьж байгаа гэдгийг ойлгох ёстой.

Хоёрдугаарт, задгай тамхиныхаа бид килограммтай байсан юмыг 200гр-тай болгоод өөрчилчихлөө мөн үү? Тэгээд өөрчилж байна. Энэний хэрэглээ нэлээн хумигдсан. Гэхдээ нэгж бүтээгдэхүүн дээр ноогдох татварын хэмжээ эрс өндөр болж байгаа байхгүй юу. Үндсэндээ 35 мянга болчхож байгаа юм. 200 граммаар тооцолт хийгээд явахаар зэрэг 35 мянга болчихоод, килограммтай байсан юман дээрээ ногдож байгаа татвараараа тооцохоор зэрэг өөр юм болчихоод байгаа юм. Үүнийгээ нэг анзаарах ёстой биш байгаа даа гэдэг нэг ийм зүйл байгаа.

Энэ дүнс татдаг. Орос дүнс дүнс татдаг хүн эрс багассан. Өнөө гаанс татдаг улсуудын чинь тоо эрс багасчихсан байхгүй юу өвгөчүүл маань ихэнх нь буцаад явчихлаа шүү дээ энэ чинь. Одоо бол харин тэр Скандинавын орнуудын гэдэг юм уу өнөө боловсон шинэ чийгшил бүх юмаа хадгалдаг тамхи руугаа байгаад байгаа байхгүй юу? Трупин татдаг тамхи руугаа. Тэгэхээр үүнийгээ зөв харах ёстой юу гэдэг ийм зүйл байгаад байгаа.

Хоёр дахь зүйл. Миллилитр дээр тавигдаж байгаа зүйлээ бид нар 2 өөрөөр тайлбарлаад болж өгөхгүй байна л даа. 20 ширхэг янжууртай.

Н.Наранбаатар: Батжаргал даргад нэмж 1 минут өгье.

Ж.Батжаргал: Хоёр дахь нь болохоор зэрэг 20 ширхэг янжууртай 2 миллиграмм нь тэнцэх юм гэж яриад. Энийгээ яг болгомоор байна хэдүүлээ. Тэгээд нүүнийгээ зөв тогтоомоор байна. Тэгж байж энэ өөрөө зөв болох юм. Дараагийн нэг хэлчихмээр байгаа зүйл бид энд яаж ч маргасан хамаагүй. Ямарваа нэгэн үйлдвэрлэгчийн эрх ашгаас хандаагүй бодитой дүгнэлтийг би Дэлхийн эрүүл мэндийн байгууллага гаргадаг л гэж ойлгоод байгаа яг үнэндээ бол.

Тэр байгууллагаас гаргасан яг дүгнэлтээр утаатай янжуур энэ халаагаад татчихаад байгаа тамхи эд нарыг чинь аль нь хүний эрүүл мэндэд хортой гээд хэлчихсэн юм бэ? Аль нь бага гээд хэлчихсэн юм бэ? Тэрийгээ барьж уул нь татварын бодлого нь явах ёстой. Аль болохоор хор багатай юмаа хэрэглээ рүүгээ зөв очиход нь бид нар татварын бодлогоороо зөв зохистой болгож өгөх л ёстой зүйл байхгүй юу. Тэрнээс биш энэ адилхан тамхиа.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мик унтарчихсан байна. Хэн хариулах вэ? Үг хэлчихлээ. Саналаа хэлчихлээ. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Нэгдүгээр асуудал энэ тамхины хяналтын.

Ж.Батжаргал: Хариултаа авъя хөөе энэ чинь асуулт. Санал биш шүү хөөе.

Х.Ганхуяг: Минутаа шинээр авъя.

Н.Наранбаатар: Тэгье асуулт асуулт. Санаачлагч хариулах уу, ажлын хэсэг хариулах уу? Эрүүл мэндийн. Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Бид нар энэ хуулийг санаачлаад бичээд Нийгмийн эрүүл мэндийнхэн, Эрүүл мэндийн яамныхантайгаа хамтраад сууж байхад энэ тамхины татварыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ч гэсэн тэгж зөвлөдөг. Зөвхөн никотины хэмжээгээр татвар оногдуулах маш буруу. Яагаад гэвэл тамхи, тамхин бүтээгдэхүүнд хүний биед хэрэгтэй 1 ч бүтээгдэхүүн байдаггүй. Никотин бол тэр донтолтыг үүсгэдэг зөвхөн 1 бүтээгдэхүүн. Түүнээс гадна таар байдаг юм уу тэр хавдар үүсгэгч янз бүрийн шаталтаас үүсэх бүтээгдэхүүн байна. Электрон тамхинд нь хар тугалга гэх мэт хүнд металлууд байна. Химийн бодис байна.

Тэгэхээр энэ олон ийм элементүүд байдаг учраас зөвхөн никотиноор нөгөө хэмжиж татвар тогтоох бол маш буруу. Энийг бол ерөөсөө хэзээ ч хэрэглэдэггүй гэдэг асуудлыг бас хөндөж байсан учраас бид энэ нөгөө хэмжээгээр нь бас энэ татварыг тооцоолох аргачлал дээр ажилласан байгаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас байвал хэлээд өгөөрэй. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хэлж байгаа зүйл бол ерөөсөө адилхан ерөөсөө энэ бүгдээрээ хортой бүтээгдэхүүн. Тэгэхээр өөрсдийнх нь зөвлөмжөөр бол энэ халаадаг тамхи янжуур тамхитай ер нь адилтгаж үзэх ёстой.

Электрон тамхины хувьд бол арай өөр төрлийн бүтээгдэхүүн. Гэхдээ энийг янжуур тамхинаас илүү бага хортой гэсэн бол дүгнэлт бол ерөөсөө гараагүй. Яагаад гэвэл зөвхөн хүний, нэг хүний биед нөлөөлөх хороос гадна нийгэмд үзүүлэх хор хөнөөл, шинэ төрлийн байдаг юм уу энүүгээрээ дагаж ер нь дэлхий дахинд электрон тамхи гарснаас хойш залуучууд, хүүхдүүд рүү электрон тамхиар дамжиж ер нь бол дараагийн тамхины хэрэглэгчийг бэлдэх ийм технологи явчихлаа. Тэгэхээр энийг хүн ам зүйн хувьд, нийгмийн хувьд харах ёстой гэдэг ийм л зөвлөмжийг хэлээд байдаг.

Тэгэхээр энэнийх нь дагуу бид нар аль аль төрлийнх нь бүтээгдэхүүний хэрэглээ Монгол Улсад буурах ёстой. Аль аль нь хортой. Хүний биед хэрэгтэй 1 ч зүйл байхгүй гэдэг энэ бодлогын хүрээнд энэ энд татварын бодлогыг хийсэн.

Энэ дээр үнэхээр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болохоор татвар нь хэр байх вэ, үгүй байх вэ гэдгээр улс орон болгон янз бүр байна. Тэгээд бид нарын хувьд бол эхний шатад электрон тамхийг хуулийн зохицуулалтад оруулж байгаа. Энэ чинь бол хүүхдүүдийн дунд маш их маркетинг хийж хүүхдүүдэд их тарлаа шүү дээ. Тэрийг бол бид нар хязгаарлах ёстой. Дотор орчинд татахгүй байх ёстой.

Дээр нь юу гэдэг юм тэр Англи гээд зарим, Англи улс бол ерөөсөө онцгой жишээ. Бусад бид нар Сингапур улсын ч гэдэг юм уу, Энэтхэг улсын жишээг авах юм бол эд нар бол дараа дараагийн донтох механизм руу орох эрсдэл маш өндөр байгаа учраас гээд бүрэн хорьж байгаа. Тэгээд Монгол Улсын хувьд бол эхний шатад бол энийг хуулийн зохицуулалтад оруулаад хүүхэд, өсвөр үеийнхнийгээ хамгаалах энэ зохицуулалтыг хийе л гэсэн энэ зорилгын доор бол бид бол энэ хуулиа өргөн барьж, татварынхаа тооцооллыг хийж өгсөн байгаа. Тэгээд энэ дээр бол бас манай Засгийн газрын санал байгаа. Анхны оруулж өгсөн юман дээр та нар шингэн тамхины хэрэглээг дэмжих юм байна. Энийгээ адилтгаж оруул аа, дүйцүүл ээ гэдэг саналыг өгөөд ийм бас санал орж ирсэн гэдгийг бас хэлье.

Н.Наранбаатар: Хэн хариулах бэ? Индэрийн микрофон дээрээс нэр, албан тушаалаа хэлээд хариулна шүү.

Н.Ганбат: Судлаач Ганбат байна. Энэ дээр хуулийн төсөл дээр ч гэсэн, сүүлд хэлэлцэгдсэн хэлэлцүүлгүүд дээр ч гэсэн грамм хэмжээг тодорхой болгосон байгаа. 2 миллилитр 0.3 процентын шингэн уусмал нь 20 ширхэг 1.2 миллиграмм никотин агуулсан 6 хүртэлх хувийн миллиграмм таар агуулсан бодистой тэнцэнэ гэсэн ийм л гаргалгаа гаргасан.

Мөн шинээр орж ирж байгаатай холбоотойгоор энэ пауч/pouch/ буюу уусгах хэлбэрийн тамхи нь, тамхин бүтээгдэхүүн нь 1.4 миллиграмм ширхэг нь 1 ширхэг янжууртай тэнцэх юм гэсэн ийм гаргалгаа тооцоог гаргасан байгаа. Энэ бол эцсийн тооцоо гэж тооцож байгаа.

Н.Наранбаатар: Нэмж хариулах юм уу? Нэмээд хариулаарай индрийн микрофон өгье.

Д.Ганзориг: Эрүүл мэндийн яам. Батжаргал гишүүний.

Н.Наранбаатар: Нэр, албан тушаал.

Д.Ганзориг: Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн яамны шинжээч Ганзориг. Батжаргал гишүүний эхний асуулт нэмэлт хариулт өгөхгүй бол болохгүй байна. Энэ нь бол энэ тамхин бүтээгдэхүүний эрсдэлд суурилсан татварын ялгаа байж болох эсэх тухай асуулт байсан.

Тэгэхээр зэрэг өчигдөр Эрүүл мэндийн сайдад ажлын хэсэгт оруулж байгаа тийм саналын мэдээллээ өчигдөр танилцуулсан байгаа. Тэгээд энэ дээр бол ийм байгаад байгаа юм. Тамхин бүтээгдэхүүнд өгч байгаа онцгой албан татвар бол никотин гэж бүтээгдэхүүн агуулсан тэр бүтээгдэхүүн дээр л байх ёстой. Агуулаагүй бүтээгдэхүүн дээр бол байж болохгүй. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал нь дан никотин агуулсан байхаас гадна энэ бүтээгдэхүүнүүд маань эрүүл мэндийн эрсдэл дагуулдаг, хүргэдэг маш олон тийм найрлага байдаг. Тухайлбал, нүүрсхүчлийн дутуу ислийн хий шатаадаг тамхинд,

утаат тамхинд. Мөн түүнийг дагалдаж химийн янз бүрийн канцероген буюу хавдар үүсгэгч бодисууд байдаг. Бохь гэдэг зүйлүүд байдаг. Энд тэр шинэ төрлийн бүтээгдэхүүн болох халаадаг тамхи, тэр электрон тамхи зэрэг нь бол яг энэ найрлагаараа бол энэ бүтээгдэхүүнүүд бол байхгүй байгаа даа ер нь бол.

Тухайлбал, тэр нүүрсхүчлийн хий бол халаадаг тамхинд бол огт байхгүй байгаа. Давирхайны хэмжээтэй буюу бохины хэмжээ бол 50 хувьд тийм бага байгаа. Канцероген бодисуудын хэмжээ бол бүүр 95-98 хувь бага байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ дээр эрүүл мэндийн эрсдэл дээр нь суурилад зарим олон улсын туршлага бол эхний шатандаа бол татвар нь бол бага авдаг тийм тогтолцоо байдаг. 50 хувь ч юм уу, эсвэл юу гэдэг юм 30 хувь ч юм уу тийм утаат тамхиныхтайгаа харьцуулахад тийм авдаг тийм тооцоо.../минут дуусав./

Н.Наранбаатар: Эрүүл мэндийн яам. Батжаргал гишүүн тодруулна.

Ж.Батжаргал: Үгүй энд хэдүүлээ зөрөөд бариад байгаа юм байхгүй. Яг бодитой тийм мэдээлэл дээр нь тулгуурлаад шийдлээ зөв гаргах тухай л ойлголт байгаад байгаа юм. Тэр үүднээсээ асуудал юмандаа хандах ёстой гэж би бол бодоод байгаа.

Тийм учраас үнэхээрийн тийм нөлөөлөл юм нь, сөрөг нөлөөлнө гэдэг юм уу тэр хүний биед очих юм нь бага юм бол тэрүүнийг нь бид эдийн засгийн аргаар нь зөв зохицуулах тухай л ойлголт байгаа юм. Энэ талаасаа асуудал юмнуудаа нэлээн сайн, нарийн харах ёстой гэж.

Одоо түрүүн бид нарын энэ Онцгой албан татварын хуулийн 1 дүгээр зүйлийн тэр хүснэгтэлсэн зүйл дотор ярихаар зэрэг тэрний 4-д байж байгаа электрон тамхи төхөөрөмжийн хамт гэж хэлчхээд 1 миллилитр нь 5 мянган төгрөг. Төхөөрөмж нь 25 мянган төгрөг гээд ингэж хэлчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь би бол ойлгохдоо өнөө 1 хэрэглээний гэж та нарын яриад байгаа зүйл мөн юм байна гэж ойлгоод байна шүү дээ. Мөн биз дээ? Тэгж ойлгоод байгаа. Үүний татварыг хэдүүлээ 30 мянгаар тооцож байгаа мөн үү? Хоёуланг нь нийлэхээр 30 болно биз дээ энэ чинь? Төхөөрөмжтэйгөө, шингэнтэйгээ нийлэхээр 30 болдог юм байгаа биз дээ? Яаж ч бодсон.

Гэтэл шингэнийг нь 1 миллилитр гэж хэлэхгүй байгаа шүү дээ. Та хэд ярихдаа нэг тийм төхөөрөмжийг цэнэглэхэд 22 гэсэн үү, 20 миллилитр ордог юм гэж хэллээ шүү дээ. Тэгэхээр 20-оор гэж бодох юм бол 100 мянган төгрөг ойлгож байна уу? Тэгэхээр тэр төхөөрөмж тамхитайгаа 125 мянган төгрөгийн татвар төлж авах болж байгаа байхгүй юу. Энэ бол хэрэглээнээс бүтэн хасагдах юм байна. Энийг дандаа манай хүүхдүүд өнөө амт, үнэртэй юм болохоор нь татдаг юм байна. Зөв байж магадгүй үүнийг дэмжье гээд ингээд би бол ойлгож байна жишээ нь.

Хоёр дахь нь болохоор зэрэг миллилитртэй 5 мянга гээд.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мик хаагдчихсан байна. Хэн хариулах уу? Ажлын хэсэг үү, хууль санаачлагч уу, хэн хариулах вэ? Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд төхөөрөмжийн хувьд яах вэ 1 удаагийн ч бай, олон удаагийн хэрэглээний төхөөрөмжийн хувьд ч бай ингээд оруулсан байгаа. Гэхдээ энэ мэдээж энэ бол хууль санаачлагчийн хувьд л оруулж ирсэн, боловсруулсан төсөл. Ажлын хэсэг

дээр мэдээж санал, дүгнэлт, гишүүдийн маань санал тусаад явах байх гэж бодож байна. Ер нь бол бид нар нөгөө стандартыг оруулж өгснөөр 1 удаагийн хэрэглээтэй байдаг юм уу, цэнэглэгчтэй байх юм бол 2 миллилитртэй шингэнтэй л ийм электрон тамхи орж ирж болно гэсэн үг. Тэгэхээр энэнийхээ дагуу л ер нь тооцогдоод явна.

Энэ нь бас ямар ач холбогдолтой гэж харж байна гэхээр ингээд тооцох юм бол нөгөө 1 удаагийн буюу батарейтай 1 удаа хэрэглэхэд л хаячихдаг зүйл бол бас байгаль орчинд ээлгүй хог болдог гээд. Европын холбооны улсад ч гэсэн энийг бол бас хэрэглэхгүй байх талаар ийм зөвлөмж гарч байгаа. Тэгэхээр ийм татварын систем рүү орсноор илүү олон удаа цэнэглээд хэрэглэх төхөөрөмжийг нь оруулж ирэх нь эдийн засгийн хувьд ч гэсэн ашигтай байх болохоор.

Нөгөө талаараа байгаль орчинд тэр олон батарейтай янз бүрийн юм 1 удаа хэрэглээд л хуванцар юмнууд хаягдаад байхгүй нөхцөл байдал руу бас чиглүүлэх байх гэдэг ийм бодлогын хүрээнд оруулж ирсэн байгаа юм.

Хоёрдугаарт бол энэ дээр бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагынхан маань байхгүй байна. Эрүүл мэндийн ажлын хэсэгт бол байгаа. Тэгэхээр бид нарыг ажлын хэсэгт дээр ажиллаж байхад Дэлхийн эрүүл мэндийн байгууллага аль хэдийн 2022, 2023 онд, хамгийн сүүлд 25 онд яг энэ электрон тамхи, халаадаг тамхитай холбоотой өөрийн бодлогын байр суурийг маш тодорхой илэрхийлсэн. Тэгээд ажлын хэсгийн гишүүдийн хувьд ч гэсэн бид нар Монгол дээр орчуулсан тэр юмнуудыг нь өгсөн байгаа. Тэгэхээр энэ дээр бол нөгөө аль нэгнийг нь хортой гэж үзэхээс илүү ямар зорилтод зохицуулалтуудыг хийх вэ гэдэг нь маш чухал шүү гэдэг асуудлыг бол тавьдаг.

Тэгээд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын байр суурь бол зөвхөн никотиноос хамаарсан татвар биш энийг бүхэлд нь бүтээгдэхүүний хувьд авч үзэх ёстой гэдэг энэ байр суурийг хатуу хэлдэг. Бид нар хууль боловсруулах явцад ч гэсэн энэ саналыг тусгаж явсан байгаа гэдгээ хэлье.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн хуулиас та бүхэнд хэлбэл салбар хуулиар зөвшөөрлийг задлах, нэмэх хориотой. Та энийг 72.3 гэдгээр тамхи татах төхөөрөмж дагалдах хэрэгсэл гэдэг шинэ зөвшөөрөл нэмсэн байгаад байгаа юм. Тэгээд энийгээ ажлын хэсэг дээрээ анхаарна биз дээ. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал энэ стандарт гэж яриад байгаа юуг чинь харлаа л даа. Тэгээд таны ярьж байгаагаас эсрэгээр бичигдсэн байгаад байгаа. Та өөрөө анзаарвал шингэн дэх никотины агууламж 20 миллиграммаас их байх гээд тавьчихсан байна. Тэгвэл хориглож байгаа юм бол малгай чинь хаана байгаа юм бэ дээ? Тэгээд ингээд энэ таны өргөн барьсан энэ хуулийнхан энэ татварынхан юуг ингээд бодоод үзэхээр цахилгаан тамхи хэмжээ нь бол 2 миллилитрээс ихгүй байна гэхихсэн байна шүү дээ тэгээд адилтгаад ингээд бодоод үзье гэж бодохоор янжуур нь 10 мянган төгрөг байх юм байна. Нөгөөдөх нь ингээд бүх юм нь нийлэхээрээ 125, 150 мянга орчим болох гээд байна л даа. Тэгээд энэ оногдуулж байгаа татварыг нь ингээд харах юм бол та цахилгаан тамхи битгий тат, янжуур тат гэж гэсэн л агуулгатай надад л уншигдаад байна л даа. Тэгэхээр яагаад ингэж янжуур нь арай бага, энэ нь арай өндөр гэдэг байдлаар татварын юуг нь оногдуулсан юм? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт, Зөвшөөрлийн хуулиар та дагалдах хэрэгсэл дээр зөвшөөрөлтэй болгосноороо ингээд тэр чинь оруулж ирэхэд ч 1 зөвшөөрөл шаарддаг зарахад ч бас дахиад зөвшөөрөл хэрэгтэй болдог. Ингээд хөшүүрэг хэрэглэх байдлаар, хүнд суртлыг хэрэглэх байдлаар цахилгаан тамхины хэрэглээг жоохон багасгая л гэж бодсон юм шиг байна л даа. Тэгэхдээ энэ чинь хор хөнөөлөө бодвол бид нар аль алиныг нь л багасгах ёстой юм биш үү? Тэгээд яг ингээд бол уншихаар тийм янжуураа тат, цахилгаан тамхиа битгий тат л гэж надад уншигдаад байна л даа. Зөвшөөрлийн тоог нэмэгдүүлсэн байна, татварыг нэмэгдүүлсэн байна.

Тэгээд энэ наалт, арьсан дээр нааж хэрэглэх зориулалттай никотин дээр 30 хувийн гаалийн татвар нь оногдуулж байгаа юм л даа. Энэ чинь нөгөө эмчилгээний зорилгоор уг нь тамхинаас гарах зорилгоор ингэж нааж маадаг биш билүү? Би ингээд буруу ойлгоод байна уу эсвэл? Тийм.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Ганхуяг гишүүн хуулиудаа бүхлээр нь бас харчхаарай гэж хэлмээр байна.

Нэгдүгээрт, Зөвшөөрлийн тухай хууль дээр бид нар шив шинэ төрлийн ямар ч зөвшөөрөл үүсгээгүй байгаа. Дагаж орж ирж байгаа хууль дээр Зөвшөөрлийн тухай хууль байхгүй. Шинэ төрлийн зөвшөөрөл ерөөсөө байхгүй байхгүй юу.

Тэгэхээр чинь ингээд электрон тамхи байдаг юм уу, халаадаг тамхи чинь төхөөрөмжтэйгөө орж ирдэг. Энэ чинь өөрөө тамхи, тамхин бүтээгдэхүүн гэдэг. Тамхи, тамхин бүтээгдэхүүний зөвшөөрөл одоогийн хууль дээр байгаа. Шинэ төрлийн ямар нэгэн нэмэлт зөвшөөрлийг бид энэ хуулиар ерөөсөө үүсгээгүй. Та дагаж орж ирсэн хуулиудаа хар л даа. Тамхи, тамхин бүтээгдэхүүн гэдгээрээ энэ бүтээгдэхүүнүүд орчхож байгаа юм. Зөвхөн төхөөрөмж оруулж ирэх гэж байгаа бол өөр төрлийн тусгай зөвшөөрөл байна гэдэг юм ерөөсөө байхгүй. Хуулиа бас үзээрэй.

Хоёрдугаарт бол бид нар тэр стандарт бол ихгүй байна гэдэг дээшээ малгай дээрээ хориглох заалт байгаа. Та шигтгэсэн хувилбарыг нь харах юм бол энэ бол дээд стандартаа тэгэхээр буруу харсан байна гэдгээ хэлмээр байна.

Гуравдугаарт, наадаг маадаг гээд ингээд бусад төрлийн аягүй энэ тамхины бүтээгдэхүүнүүд чинь их шинэ олон төрлийн хэлбэртэй болоод байгаа юм байна лээ шүү дээ. Зажилдаг л гэнэ, яадаг л гэнэ, бүүр бид нарын нөгөө энэ хуулиа хойноос нь гаргах гэсээр байтал дараа дараагийн юм гараад ирдэг. Тэгээд тэр болгоныг бид нар тамхин бүтээгдэхүүн гэж одоогоос үзээд зохицуулалтад оруулахгүй бол дахиад жилийн дараа өө ийм шинэ төрлийн юм гараад иржээ гэдгийг дахиад л хойноос нь явах нь.

Тэгэхээр бусад төрлийн тэр тодорхойлолт дээр, Д дээр бол ийм бүтээгдэхүүнүүдийг оруулсан байгаа юм. Тэгээд та тэр нөгөө тамхин бүтээгдэхүүн гэдгийн тодорхойлолтыг харах юм бол тамхинаас гарах зориулалттай, тэр чинь зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл. Тэр бүтээгдэхүүн бол өөрөө цаанаасаа тийм зориулалттай гэдэг нь зөвшөөрөгдсөн эд байдаг. Тэрнээс бусад тэр зажилдаг байна уу, өөр нааж энд мэндээсээ никотин авдаг байна уу ийм төрлийн

бүтээгдэхүүнийг бид нар тамхин бүтээгдэхүүн гэж үзнэ. Ийм болохоороо бид нар гаалийн албан татвараа авна л гэдэг юм байгаад байгаа юм. Тэгэхээр тамхинаас гарах эмчилгээнд зориулдаг цаанаасаа certified юу гэдэг юм энэ бүтээгдэхүүн бол тамхины тодорхойлолтод бол ороогүй байгаа. Тэгээд энийг бол холих бол ямар ч хэрэгцээ, шаардлага байхгүй. Ийм байгаад байгаа гэдгийг нэмэлтээр тайлбарлая.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Яах вэ энэ зөвшөөрлийн юуг бол та салбар хуулиар л нэмчихсэн байгаад байна шүү дээ 72.3 гээд зүйл, заалт нэмэгдчихсэн байна. Би эсвэл буруу хараад байна уу нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал би харин нэг юмаа ингээд логиктой цөмөөрөө байя л даа цөмөөрөө. Тамхийг татварыг нь аль болох цөмөөрөө өндөр байлгая цахилгаан байна уу, тэр янжуур байна уу. Гэхдээ жишээлбэл архи дээр, рункан дээр онцгой татвартай болгоод рункан дээр тусгай зөвшөөрөлтэй болгоно гэж юу гэсэн үг юм? Яг л тэрэнтэй адилхан зүйл шүү дээ. Рункийг би рункээр би цай уудаггүй. Хүн ер нь рункээр цай уудаг юм уу? Архи л уудаг биз дээ. Тэгээд л тэр дээр онцгой татвартай болгоод тусгай зөвшөөрөлтэй болгохтой л адилхан зүйл байхгүй юу даа. Цөмөөрөө жоохон логиктой баймаар байх юм.

Мэдээж хэрэг тэр шингэн орсон бол тэр цахилгаан хэрэгслээс бол тэр онцгой татвар авах нь зөв. Гэхдээ тэр дагалдаг энэ дотор чинь жишээлбэл никотин байхгүй шүү дээ жишээлбэл. Энэ дотор никотин юм байгаа юм. Эндээс бол онцгой татвар авах ёстой юм. Тэгээд энийг онцгой татвартай болгоод тусгай зөвшөөрөлтэй болгоно гэж яг юу гэсэн үг юм? Би ерөөсөө энийг чинь ойлгохгүй байгаад байхгүй юу даа.

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Ганхуяг гишүүн ээ би ч гэсэн тодорхой тайлбарлая. Та архитай, рунктэй тодор яг дүйцүүлээд байх шиг байна. Гэхдээ архийг уудаг дээрээ тулгуурлах юм бол рунк байна уу, үгүй юү хамаагүй, шилээр нь ууна, ийм аяганд хийж ууна, бөглөөнд хийж ууна тэрийг олон янзаар хэрэглэх боломжтой.

Тэгтэл тамхийг байна шүү дээ. Энэ шингэн тамхийг, халаадаг тамхийг тэр төхөөрөмжгүйгээр хэрэглэх ямар ч боломжгүй. Тэр төхөөрөмжийг зөвхөн тамхийг дотор нь хийгээд хэрэглэдэг. Тэгэхээр архины рункийг өөрөөр хэрэглэж болно. Архийг өөр саванд хийгээд ууж болно. Тэгээд тэр чигээр нь ч уучхаж болно. Тэгтэл тамхийг тэр төхөөрөмжөөс салгаж хэрэглэх боломжгүй учраас дагалдах хэрэгсэл буюу салшгүй хэсэг гэж үздэг юм. Олон улсын стандартаараа тэгж үзэж явж байна. Тийм бодлого байна. Бид нар энийг чинь би зохиож байгаагүй шүү дээ. Олон улсын асуудлуудыг бид нар судлаад ингээд харж байгаа.

Тэгэхээр энийг нөгөө өө хайх гэсэн юу гэдэг юм, би чинь бүтэн 1 жил энэ янз бүрийн гүтгэлэгт дайруулж байгаа шүү дээ. Гэхдээ би үр хүүхдүүдийнхээ төлөө хийх ёстой. 10 хэдэн жил хийж чадахгүй байгаа юмны төлөө бид нар яах гэж энд орж ирсэн юм. Ард түмнийхээ төлөө энэ нийтийн ашиг сонирхлынхоо төлөө л ажиллах гэж орж ирсэн шүү дээ. Хийх ёстой гээд л зүтгэж байгаа. Энэ гүтгэлэг үнэхээр хувь хүний хувьд бол тийм таатай бол биш. Хаанаас ирж байгаа нь ч гэсэн би мэдэж байгаа. Хэдхэн тамхи импортлогч, вэйп импортлогч, монопол компаниуд байдаг. Улс төрд бас нөлөө бүхий хүмүүс байдаг. Улс төрчидтэй холбоотой

байдаг. Тэрүүгээрээ янз бүрийн хов жив тараадаг. Сошиалаар баахан мөнгө төгрөг нүддэг. Тэгээд өөлөх юм ингээд хийх юмыг ингэж бол хийхгүй та нар жоохон том зургаар нь харчхаач дээ. Засах юм байвал мэдээж энэ чинь 126-гийн асуудал. Засаад орж ирж болно. Гэхдээ том зургаараа бид нар энэ үр хүүхдээ хамгаалах юмаа бид нар хийх ёстой.

Зөвшөөрлийн хууль дээр би 72 гэдэг зүйл манай хууль дээр байхгүй. Та хаанаас юу хараад хараад байгааг би. Ямар салбар дээр хууль дээр байгаа юм?

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Үгүй ээ яах вэ энэ архи дээр рунк гээд ярьчихсан л ингэж л ойлгоод л тэрийг ингэж яриад байх шиг байна л даа. Архийг янз янзаар ууж болно гээд. Жишээлбэл машин нь онцгой татвартай. Тэгвэл тэрнээс салгаж аваад дугуйг нь онцгой татвартай болгоод тэгээд тусгай зөвшөөрөлтэй болговол энэ логик үгүй ээ би энэ логик үндэслэлийг чинь л яриад байна шүү дээ. Түүнээс биш би энийг чинь эсэргүүцэж байгаа юм алга. Би зүгээр ажлын хэсэг дээр энийг анхаараарай гэж байгаа юм. Анхаараарай гэж байгаа юм. Хаашаа юм тэгээд дугуйг нь салгаад дээр нь юу билээ юу билээ унадаг дугуйнд хийх юм уу? Үгүй тэрэнтэй л ялгаа байхгүй л логик яриад байна шүү дээ. Үгүй хортой байж болно. Тэгээд яагаад янжуураас тэгвэл их байгаа юм? Яагаад энийгээ адилтгаад ингээд бүгдийг нь өсгөчихгүй яасан юм бэ? 10 дахин их байна шүү дээ.

Тэгэхээр чинь ерөөсөө л манай хүүхдүүдийг янжуур тамхи тат аа л гэдэгтэй логик яг адилхан байна шүү дээ. Би хоёрхон логикийн л юм асуулаа. Тэгэхээр та уурлаад байх юм. Би ерөөсөө уурлуулах юм хэлсэнгүй. Энийгээ та нар ажлын хэсэгтэйгээ ярилцаарай ийм зүйл анзаарагдаж байна л гэж би хэлж байна шүү дээ. Тэр тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр та нар анхаараарай. Би өөрөө Зөвшөөрлийн хуулийг боловсруулж бичсэн хүн. Батлуулсан хүн. Зөвшөөрлийн салбар хуулиар зөвшөөрлийн тоог нэмэхийг хориглосон байдаг юм. Нэмэхийн тулд хяналтын сонсгол хийдэг юм. Тэр юмнуудаа процессуудыг хийгээгүй. Одоо тэгээд энэ тусгай зөвшөөрөл болон энэ тэр онцгой татвар дээр таныг энэ асуудлууд дээр анхаараарай гэхээр бухимдаад байх юм. Яагаад вэ гэхээр энийг чинь нийлбэр дүнгээрээ тооцохоор цахилгаан тамхи хамаагүй өндөр болоод янжуур нь хамаагүй бага байгаад байна шүү дээ. Адилхан тэгвэл бүгдийг нь өсгө л дөө. 100 хэдэн мянга болго л доо адилхан.

Н.Наранбаатар: Төсөл санаачлагч Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Уурласан ч юм алга л даа. Таныг жишээ авахаар нь л би ч гэсэн бас ингээд л жишээ аваад л танд ойлгуулчих гээд л уг нь зүтгээд байхгүй юу. Тэгээд дугуйны жишээ хар даа та эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн онцгой албан татвар архи, тамхи, бензин дээр тавигддаг байхгүй юу. Машины онцгой албан татвар чинь өөр зорилготой юм. Тэгэхээр тийм, тийм болохоор та машиныг тамхитай харьцуулах чинь аягүй утгагүй байхгүй юу даа. Тийм.

Н.Наранбаатар: Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна. Индрийн микрофон өгье.

Н.Ганбат: Судлаач Ганбат байна. Нэгдүгээрт энэ зарчмын зөрүүтэй энэ маргаан бол өрнөх нь угаасаа зайлшгүй асуудал байсан. Энэ дээр товчхон тайлбар хэлээдэхье. Нэгдүгээрт нь энэ хуулийн яг үндсэн гол зорилго нь тамхийг

хориод, эс үгүй бол тамхийг аль нэгэн байдлаар ялгавартайгаар татвар оногдуулаад ард иргэдийн нуруун дээр дарамт өгөх гэж байгаа асуудал бол биш. Судалгаа нь судалгаагаар авч үзэхэд тамхины үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор 21 наснаас дээш буюу худалдан авах чадвартай хүмүүсийн тамхи гарах асуудалд бол тодорхой нөлөө бараг л байхгүй.

Харин шинээр тамхины хэрэглэгч болох хүмүүст дарамт учруулж өөрөөр хэлэх юм бол шинээр тамхичин үүсгэхгүй байгаад энэ татварын зорилго оршиж байгаа шүү гэдгийг нэгдүгээрт тайлбарлая.

Хоёрдугаарт нөгөө зөрүүтэй гараад байгаа гэж байгаа шүү дээ тээ. Зөрүүтэй гараад байгааг нь хэмжээгээр нь зохицуулж өгье. Тухайлах юм бол өнөөдөр байгаа 5000 төгрөгийн тамхийг би 5 өдөрт 1, 1 ширхгээр нь худалдаж аваад 30 мянган төгрөг төлөх үү, эс үгүй бол энд зааж өгсөн нөгөө 10 миллилитр гэж яриад байгаа энийгээ би 30 мянган төгрөгөөр аваад 5 өдөр татах уу гэдэг нь алтернатив сонголтын асуудал үүсгэж байгаа шүү гэдгийг та бүхэн анхаараарай.

Н.Наранбаатар: Нарантуяа-Нараа гишүүн асуулт асууна. Дэгээрээ явна.

М.Нарантуяа-Нара: Нэгдүгээрт саяын энэ судлаачийн хэлсэн энэ янжуур тамхи татаж байгаа хүн вэйпийг татаад тамхинаас гарсан гэсэн судалгаа байхгүй гэсэн судалгааг нь үзье.

Хоёрдугаарт үнэхээр хүүхдээ хамгаалъя гэх нь бол үнэхээр зөв, маш зөв. Хүүхдээ одоо бид нар хамгаалъя гээд сүүлийн үед олон талбарт ярьж байгаа нь зөв. Гэхдээ Монгол хүүхдийн эрүүл мэнд, амь насны өмнө өнөөдөр тулгамдаж байгаа хамгийн ноцтой асуудал нь вэйпний үнэр, амт мөн үү? Өнөөдөр маш олон төрлийн хүчирхийлэлд хүүхдүүд эрүүл мэнд амь насаараа хохирч байна. Тамхи, хар тамхи, мансууруулах бодист өчнөөн олон хүүхэд залуус амь насаа алдаж байгаа. Тэр бид нар нууцын зэрэглэлтэй мэдээллийг ч бид нар авдаг.

Тэгээд газ, газ үнэрлэх, химийн хорт бодис үнэрлэх ийм замаар амь насаа алдаж байгаа хүүхдүүдийг бид нар урьдчилан сэргийлж хамгаалж чадахгүй байгаа. Өдөр бүр хүүхдүүд хаа нэгтээ архи, мансууруулах бодис хэрэглэж согтуу байгаа, мансуурсан үедээ хоорондоо зодолдсон ямар нэгэн зүйл хийсэн гэх мэдээг бид нар тасралтгүй авч байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудал дээр бид нар яаж хүүхдүүдээ хамгаалж байгаа юм? Би зүгээр хардаад байгаа юм Номинчимэг гишүүнээ би бас тэгэхдээ таныг бас ойлгож байна. Та яагаад вэйпийн үнэр, амт л Монголын хүүхдүүдийн хамгийн ноцтой аюул юм шиг ингээд яг вэйп дээр ингээд яг үнэхээр Ганхуяг гишүүний хэлж байгаа бас үнэн байхгүй юу. Хэтэрхий вэйп дээр маш том том ийм татварын бодлогоор нэмэлтүүд тавьчихаар хүүхдийг гэж хэлээд хүүхдийг гэж байгаа боловчиг нөгөө талд нь энэ чинь эсрэгээрээ бараг хууль бус худалдааг дэмжих хууль болчих вий дээ. Одоо бид нар ер нь энэ олон улсад энэ амт, үнэрийг хориглоод хүүхэд болон тамхи хэрэглэгчид нь тамхинаас гараад эерэг сайн үзүүлэлт өгөөд байгаа дэлхийн ямар улсын жишиг байна тэр судалгаа нь байгаа юм уу?

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаа гээд яриад байсан чинь нөгөө судалгаануудыг нь аваад үзсэн чинь ямар ч янжуур тамхи болон вэйп тамхины хор хөнөөлийн үзүүлэлтийг судалсан судалгаа байхгүй. Эрүүл мэнд, амь насны үзүүлэлтийг судалсан судалгаа байхгүй. Эсрэгээрээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр Монгол Улсад зарагдаж байгаа вэйпийн зах зээлийн

судалгааг хийчихсэн байгаа шүү дээ. Энэ яг ямар учир вэ? Яагаад янжуур тамхины зах зээлийн судалгааг хамтад нь хийгээд өгөөгүй юм тэгвэл?

Нөгөө талаар бас би үнэхээр бас энд бид нар бүх бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалсан байр суурьтай тэнцвэртэйгээр байх ёстой. Илт давуу вэйпийн бизнес эрхлэгчид чинь та нар түрүүн хэлээд байна л даа хэчнээн яасан ийсэн ингээд л яриад байна. Үгүй энэ хэдэн залуучууд л байдаг юм байна лээ шүү дээ.

Харин эсрэгээрээ янжуур тамхины бизнес бол он.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж цаг өгье.

М.Нарантуяа-Нара: Янжуур тамхины бизнес бол бүүр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага байтугайг баддаг ийм байгууллага ийм том монополууд байдаг шүү дээ ер нь бол. Тэгээд энэ хүүхдийг үнэхээр хамгаалах гээд байгаа юм бол, насанд хүрэгчдэд зөвхөн худалдаалдаг, нас шалгах системийг нь бий болгодог, хяналтын камерыг бий болгодог, сургуулийн орчны хязгаарлалтыг бий болгодог, тэр онлайн худалдааг хязгаарладаг тийм юмнуудаар хийж болох байтал одоо би яг үнэндээ вэйпийг ингээд хориглочихоор хүүхэд томчууд ч гэсэн худалдаж авахгүй болонгуут бүгд буцаад янжуур руугаа орно. Янжуур руугаа орохгүй мансууруулах бодис өөр бусад юм руу орохыг хэн ч мэдэхгүй. Баталгаагүй байгаа байхгүй юу. Байж байгаарай би дахиад юмаа ярина.

Эндээс үүдээд юу харагдаж байна гэхээр зэрэг энэ яг үнэндээ Ганхуяг гишүүний хэлдэг шиг вэйпийг хэтэрхий үнэтэй болгоод тавьчихаар нөгөө талд хүмүүс ямар ч сонголтгүй буюу ардчилал өөрөө, ардчиллын зарчмаар ухарч байгаа байхгүй юу. Ардчилал.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Номинчимэг гишүүн төсөл санаачлагч хариулъя.

О.Номинчимэг: Манай Монгол Улсад байна шүү дээ энэ янжуур нь байна уу? вэйп нь байна уу үнэхээр лобби өндөртэй юм байна лээ. Тэгээд би энэ Евроази дээр ч гэсэн янжуур тамхины энэ 2 том компаниудыг нөлөөлөөд л гаалийн албан татвар байхгүй болгочихсон дээр үнэхээр дуугай хэлж явж байгаа шүү дээ. Бүгдийг нь л энэ асуудлуудыг цэгцэлчихье гээд явж байгаа. Тэгээд бид нар энэ асуудлыг шийдэхгүй тэгвэл та мансууруулах руугаа оръё гэж юм хэлж байх шиг байна. Бид нар орж байгаа. Мансууруулахын хууль ороод ирсэн ажлын хэсэгт ажиллаж байгаа.

Гэхдээ энийгээ эхлээд шийдэж байгаад энийгээ эхлээд дараа нь шийднэ гэсэн юм бол байхгүй. Бид нар давхар л энэ бодлогоо авч явж байх ёстой. Ялт ч үгүй Монгол Улс бол дэлхийд электрон тамхи, шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн ямар ч зохицуулалт байхгүй хэдхэн улсын нэг болсон. Африкийн хэдэн улс Монгол Улс.

Дэлхий дахинд ч гэсэн энэ бүтээгдэхүүнүүд ямар үр нөлөө гарч байна гэдгийг нь хараад улсууд бодлогоо хийгээд явж байгаа. Энэ ярьж байгаа үнэр, амтны асуудал бол бид нар бас судалгаа хийж үзсэн. Фокус судалгаа хийж үзсэн хүүхдүүддээ орсон. Ерөөсөө энэ хөгжөөгүй тархин дээр гүзээлзгэнийн амттай ийм тамхи өрчихөөр муухай гэдэг, хортой гэдэг мэдрэмж төрөхгүй. Гүзээлзгэнэ

болохоороо цаанаасаа гоё юм байна гэдэг мэдрэмж өгчихдөг юм байна. Цаагуураа никотин байна уу янз бүрийн бодисоор хордуулаад донтоод донтуулаад байдаг.

Тэгэхээр энэ нөгөө бүтээгдэхүүнд орох хамгийн татах нэг асуудал нь ерөөсөө үнэр, амт. Энийг би ганцаараа хэлээгүй. Энийг олон улс хэлж байна. Тийм ч учраас олон улсад 20 улс. 20 улс тэгээд Англи гээд вэйпийг чинь дэмждэг улс хүртэл хүүхдүүд ороод байна үнэр, амтны хязгаарлалт хийе гэдэг юм орчихсон байна хууль дээр нь.

Тэгэхээр энэ улсууд чинь хүүхдүүдээ бид нар дараа дараагийн донтолтын хэлбэр рүү бэлдэх ийм зам нь болоод байна. Тэгэхээр энийг татаад байгаа зүйлүүдийг нь хориглож хязгаарлая гэдэг бодлого гаргаад ирчихсэн байгаа юм.

Ингэхгүй бол та хэлж байна энэнээс гарах юм бол өөр юм руу гээд. Харин ч олон улсын судалгаагаар та ажлын хэсгийн гишүүн тэр судалгаанууд байгаа вэйп татдаг хүүхэд цаашаага янжуур тамхи татах магадлал нь 3-5 дахин ихэсдэг. Нэгэнт орчих юм бол, донтолчих юм бол.

Вэйп татдаг хүүхэд янжуур татдаг хүүхдээс илүүтэйгээр хар тамхи руу орох эрсдэл нь өндөр байна гэдэг ийм судалгаанууд байгаад байхгүй. Яагаад гэвэл энэ чинь зан үйлээр дамжаад дандаа ийм сордог ийм зан үйлээр дамжаад цаашид тэр нөгөө донтолтын никотин байдаг өөр хүнд хэлбэрийн юм руу орохоороо тийшээгээ орох зан үйл, биеийг нь цаанаасаа бэлдээд байна шүү дээ. Тэгэхээр энийг бол бид нар зохицуулах ёстой. Ялт ч үгүй бид нар энийг бол хийх ёстой. Хажуугаар нь мэдээж хүүхдүүдээ хамгаалах зүйлсээ хийх ёстой.

Татварын хувьд бол бид нар хэлсэн анх бол бид нар электрон тамхи дээр бага татвар оногдуулахаар тооцоолоод оруулсан чинь Засгийн газар ийм санал өгсөн. Та бүхэн маань ажлын хэсгийн гишүүд бүгдээрээ байгаа Засгийн газрын саналыг саналыг уншаарай. Тэгээд бид ялт ч үгүй дүйцүүлэхээр ингэж орж ирж байгаа.

Хэрвээ ажлын хэсгийн гишүүд зөв, зүйтэй гэж үзэх юм бол тэрийгээ саналаа гаргаад багасгах юмаа оруулж ирж болно. Би чуулган дээр ч гэсэн хэлж байсан. Бидний анхны тооцоолол бол бага байсан. Засгийн газар Зөвшөөрлийн хууль болон энэ хууль дээр л 2 санал өгөөд энийг нь бид нар тусгаж орж ирж байгаа нь энэ юм шүү гэдгийг бас хэлсэн байгаа шүү.

Н.Наранбаатар: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Хүүхдүүдтэй уулзаад судалгаа хийсэн гэдэг байдлаар судалгааг үндэслэнэ гэдэг бол үнэхээр учир дутагдалтай. Би Номинчимэг гишүүнийг ийм мэргэжлийн хуульч хүн гэхэд ийм юмыг судалгаа үндэслээд ярьж байгаад бол үнэхээр харамсалтай байна.

Үгүй тэгээд үнэхээр хүүхдүүдийн тамхидалтын үндсэн асуудал нь яг юу байсан юм амт, үнэр байсан юм уу? Үнэхээр гүзээлзгэнийн амттай болохоор гүзээлзгэнэд дуртай гээд ингээд байгаа бол гүзээлзгэнийн амттай модон чихэр идэх нь яадаг юм. Тэгэхгүй байгаа биз дээ. Энэ хар аа энэ байж бай би юмаа яриадахъя. Энэ хар аа ингэж байгаа байхгүй юу. Нийгэмд асар их стресс байна. Нийгэмд асар их стресс байгаа энэ стресс эцэг эхийн ажлын, нийгэм орчны, эдийн засгийн энэ олон дарамтуудаас болж хүмүүст стрессээ тайлах хэрэгцээ шаардлага

байна. Энэ стрессээ тайлах хэрэгцээ шаардлага нь тамхи байгаа байхгүй юу. Хамгийн анхдагч зүйл.

Уг нь бол стрессийг нь бид нар сайн орчин, сайнхан амьдрах энэ боломжоор хангаад төр засаг хангаад бүрэн, зөв эрүүл мэнддээ зөв сонголтоо хийхээр энэ орчноор хангах ёстой байтал чадахгүй байгаа учраас хүмүүс өнөөдөр тамхи татаж байгаа. Үүгээрээ стрессээ тайлж байгаа юм.

Тэгэхээс биш энийг ингээд амсангуут гоё үнэр, амттай гээд дурлаад байгаа юм бол байхгүй. Энэ бол стресс тайлах хэрэгсэл. Тэгвэл энэ стресс тайлах хэрэгслийг өнөөдөр амт, үнэр гэдэг нэрийдлээр нэгийг нь байхгүй болгоод янжуур тамхийг нь тавиад өгч байна. Одоо энэ Евроазийн хэлэлцээр гээд байгаа энэ янжуур тамхины чинь бараг 90 гаруй хувь нь Казахстанас орж ирдэг юм байна. Евроазийн хэлэлцээрт энэ янжуур тамхи нь ороод ирчихсэн. Ингээд янжуур тамхиа татваргүй болгоод вэйпийн нөгөө талд бүүр өсгөөд ирчихээр хүмүүс юу татах вэ? Өөрсдийнх нь карматай, өөрсдийнх нь халаастай шууд холбогдож байгаа энэ асуудал сонголтоо мэдээж арай хямдхан стресс тайлах юм руугаа явна биз дээ.

Тэгэхээр ийм худлаа ийм ямар ч судалгаагүй хүүхдүүдтэй уулзсан ч гэх шиг. Хүүхдүүд танаас бид нарыг вэйп татуулахгүй болгоод өг гэхгүй шүү дээ. Харин хүүхдүүд юу хүсэх вэ гэхээр бид нарыг сайн сайхан орчинд амьдруулаач, сургаач, хоцрогдолгүй болгооч, орчны аюулгүй байдлыг анхаараач, замын хөдөлгөөнийг ингээч.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хууль санаачлагч Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Битгий гуйвуулаарай Нара гишүүн. Бүгдээрээ судалгаа, тооцоотой байгаа. Хүүхдүүдийн хувьд ч гэсэн юунаас болж дутгагдаж байна гэдэг судалгаа нь байгаа. Тэгээд бид нар энэ хууль дээр хортой бүтээгдэхүүн дээр бид нар зохицуулалтгүй явна гэж байхгүй шүү дээ. Тэгээд энэ соён гэгээрлийн ажлыг нь хийе, эрүүл мэндийн боловсролыг нь олгоё, энэ бүтээгдэхүүнүүдээс авсан татвараа донтолтоос сэргийлэх энэ юмнууд руугаа заръя гээд энэ хууль чинь өөрөө том бүтэн концепц байгаа шүү дээ. Та зөвхөн үнэр, амтыг аваад яриад байх шиг байна. Та хуулиа бас уншаарай ажлын хэсгийн гишүүний хувьд. Бүтэн folder ба судалгаанууд өгчихсөн байгаа. Эрүүл мэндийн талаас нь энийг цаашид соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх бүхэл бүтэн ийм концепцууд наад хуульд чинь тусчихсан байгаа. Та тэрийг бас хараарай.

Тэгээд та ингээд вэйпийг хориглоод янжуурыг дэмжээд байгаа юм шиг ярьж байна. Дэлхий дахинд байна шүү дээ ийм юм байна лээ янжуур тамхины хэрэглээ угаасаа хөгжсөн би үгээ хэлээдэхье. Хөгжсөн улсуудад хэрэглээ багасаж байгаа. Яагаад гэвэл хорт хавдар үүсгэдэг, муу гэдэг нь ойлгомжтой. Тэгтэл энэ тамхины компаниуд зах зээлээ алдахгүйн тулд шинэ технологи гэдэг нэрийдлээр шинэ бүтээгдэхүүн гаргаж ирж байгаа юм. Та дэлхийд хамгийн том вэйпийн брэндүүд болон үйлдвэрүүд болон янжуурын үйлдвэрүүд хараад байгаарай. Бүгдээрээ нэг эзэн байхгүй юу. Нөгөө янжуур үйлдвэрлэдэг байсан 1800, 1900 оны том компаниуд чинь бүгдээрээ дэлхий дахинаа вэйп үйлдвэрлэгч болчихсон.

Яагаад гэвэл янжуур нь явахаа больчихлоо. Вэйпээр залуу үе рүү орж бэлдье, донтолтоо бэлдье, энэнийхээ хэрэглэгчээ бэлдье л гэдэг ийм технологи улсад чинь тэр дэлхий дахинд яваад байна. Манай Монгол Улсад бол 2, 3-хан л

компани байгаа шүү дээ. Тэгээд хоорондоо зодолдож байгаа юм шиг мөртөө цаагуураа үгсэн хуйвалддаг. Яаж нийлж байгаад энэ хуулийг зогсоочих уу, гацаачих уу, харлуулчих уу гэдэг л ийм юм явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр хүүхдүүдээ хамгаалах эхний шатны алхмыг хамтдаа хийх ёстой байх ёстой. Та хүүхдэд их анхаардаг хүн. Тэгээд стрессийг нь хар наад тамхи чинь биш энэ чинь хэрэглээ шүү дээ гэж ярьж байгаа би бас гайхаж байна. Хүүхдүүдийн хувьд бол энэ хэрэглээ байх ёсгүй байхгүй юу анхнаасаа бодлогоороо.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Асуултад маань яг тодорхой ажил хэрэгчээр хариулаад өгөхийг бодоорой. Ганхуяг гишүүний асуулт аягүй чухал асуулт байсан байхгүй юу даа. Энэ цахилгаан тамхи шингэнтэй, шингэнгүй цахилгаан тамхины татварыг нэмэхээр логик утгаараа янжуур тамхи тат аа гэдэг логиктой болоод байна уу гэдэг энэ асуултад хариулаад өгөөрэй. Битгий өмнөөс даян дэлхийн ардчилал мандтугай гэж хариулт өгөөрэй. Яг энийг авъя.

Дээрээс нь сая Эрүүл мэндийн яамнаас ингэлээ шүү дээ наад цахилгаан тамхи чинь хор багатай. Янжуур тамхинаасаа хор багатай юу? Донтуулах нь бага уу их үү? Яг ийм асуулт нь юу? Янжуур тамхинаасаа хор багатай юу, ихтэй юу? Янжуур тамхи ч донтуулдаг, вэйп ч донтуулж байгаа тийм үү? Аль нь илүү юм? Хэрвээ тийм бол аль багатай дээр нь татвар нь бага байх ёстой зарчим нь. Ажил хэрэгч л хариулаад өгөөрэй. Илүү дутуу энх тайван мандтугай, хүүхэд мандтугай ямар ч хэрэггүй шүү. Тэгээд дараа нь тодруулъя.

Н.Наранбаатар: Хариулт. Нэр, албан тушаалаа хэлээд индрийн микрофоноос хариулна.

Д.Ганзориг: Эрүүл мэндийн яамны Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан шинжээч Д.Ганзориг. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Эхлээд Эрүүл мэндийн яаманд хандаж хэлсэн асуултаас нь асууя. Янжуур тамхи хортой юу, донтуулдаг уу? Нөгөөдүүл нь донтуулдаг уу, хортой юу гэсэн асуулт байсан тийм үү? Цөмөөрөө донтуулна. Яагаад гэвэл никотин агуулчихсан байгаа юм. Тэгэхдээ никотин агуулчихсан тэр бүх бүтээгдэхүүнүүд маань хүний тэр донтчихсон байгаа никотины хэрэгцээг цөмөөрөө ямар нэгэн байдлаар нөхөөд байгаа юм. Янжуур тамхийг яагаад илүү эрсдэлтэй, эрүүл мэндийн эрсдэлтэй байна вэ гэж үзэж байгаа вэ гэвэл та бид мэдэж байгаа. Энэ бол бүрэн шаталт явагдаж байгаа 950 градуст халдаг. Нүүрсхүчлийн дутуу эс юу исэл хий ялгардаг. Тэр СО2 гэж бид ярьдаг. Тэрэнд ингээд үнэртэхээр зэрэг хүн ухаан алдаад юм уу үхэх ёстой шүү дээ. Тэрийг чинь бие рүүгээ оруулж байгаа. Тэрэнтэй цуг хэдэн бараг 7 мянган ширхэг химийн хорт бодис ордог. Дийлэнх нь канцероген буюу хорт хавдар үүсгэгч шинж чанартай.

Дээр нь нэмээд таар буюу бид бохь ч гэж нэрлэж байгаа, давирхай ч гэж орчуулаад байгаа тэр бүтээгдэхүүн ордог. Тэр маань уушгинд очоод бөглөрчихдөг. Уушгины тэр нарийхан нарийхан тэр судлуудыг маань бөглөх юм уу эсвэл тэнд очоод үрэвсэл үүсгэх, дахиад уушгины өөр өвчин үүсгэх тийм эрсдэлийг бий болгодог.

Тэгэхээр зэрэг яагаад энэ шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд маань, энэ янжуур тамхи утаат тамхинаасаа яагаад эрсдэл багатай гэж хэлж байгаа вэ гэвэл никотиныг нь яриагүй юм. Эрүүл мэндийн эрсдэл нь тэр нүүрс хүчлийн хий, тэр канцероген бодисууд, нитрозаминууд, мөн тэр таар энэ тэр эфирийн харьцаа нь нэгэн заримд нь бүр байхгүй. Тэр вэйп бол байхгүй байгаа шүү дээ. Тэр чинь зүгээр л синтетик никотин юм уу, эсвэл тамхины навчнаас ялгаж авсан никотиныг шингэнтэй холиод оруулж байгаа.

Тэгэхдээ тэр шингэний найрлагад тодорхой юм байхыг үгүйсгэхгүй. Тэр нь сайн судлагдаагүй. Халаагч тамхины хувьд бол судалчихсан судалгаа байгаа. Тэр нь юу вэ гэвэл Япон судалсан. Би танд өгсөн материал дунд байж байгаа. Япон судлаад яасан бэ гэвэл 3 тамхийг 3-ууланг нь задлаад ямар хортой бодисууд байна вэ гээд үзэхэд халаадаг тамхи маань нүүрсхүчлийн хий байхгүй ерөөсөө 350 градус халаагаад тэгээд татдаг байхгүй юу. Тэрнээс биш шатаахгүйгээр татдаг учраас.

Хоёрдугаарт юу байхгүй тэр таар буюу давирхай бол 50 хувь бага байгаа. Тэр нитрозамин тэр нөгөө хавдар үүсгэгч бодисууд бол бүр 98 хувь бага байгаа байхгүй юу. Яагаад гэвэл бүрэн шаталт байхгүй учраас. Тэгэхээр зэрэг энэ зүйл маань эрүүл мэндийн шинэ технологи, инновац шингээд тэгэхдээ би энэ компанийн талаас нь ярьж байгаа биш шүү. Би өөрөө эрдэм шинжилгээ, судалгаа хариуцдаг болохоор. Тэгээд энэ бүх мэдээллүүдийг сүүлийн 2, 3 жилд гарсан эрдэм шинжилгээ, судалгааны буюу тэр импакт фактор өндөртэй гэж гарсан сэтгүүлүүдийн юун дээрээс нотолгоонуудыг авч оруулсан байгаа. Яагаад би энийг хийх болсон бэ гэвэл тамхины хяналт, тамхин бүтээгдэхүүний энэ хяналтыг яах энэ хуулийн өргөн мэдүүлсэн тэр 2 судалгаа, 3 судалгаа байгаа байхгүй юу. 2 үнэлгээ тэгээд 1 зах зээлийн судалгаа. Энэ дотор энэ бүтээгдэхүүнүүдийн ялгааг оруулаагүй байгаа байхгүй юу. Шууд ижилхэн энэ дотор тавьчихсан байж байгаа байхгүй.../минут дуусав./

Н.Наранбаатар: Байж байгаарай. Микрофонд ярина дандаа. Бүх юм протоколд үлдэх ёстой. Тодруулгаа авчих. 1 минут гүйцээгээрэй.

Д.Ганзориг: Өчигдөр Эрүүл мэндийн сайдад танилцуулсан санал байгаа энэ дээр. Энэ дээр бол ямар санал тавьж байгаа вэ гэвэл юугаа хамгийн өндрөөрөө байж байгаа тэр татвар бол тэр янжуур буюу утаат тамхи дээрээ бол байдгаараа байг ээ. Татварыг бол бүгдээс нь авна. Яагаад вэ гэвэл энэ бол эрүүл мэндийн эрсдэл өгч байгаа байхгүй юу никотин агуулчихсан бүтээгдэхүүн учраас.

Гэхдээ никотин агуулаагүй бүтээгдэхүүнээс авах шаардлага байхгүй юм байгаа юм. Угаасаа эрүүл мэндийн эрсдэлийг маань мөнгөөр үнэлээд тэгээд тэр мөнгийг нь татвар байдлаар аваад буцаагаад эрүүл мэндийн үйл ажиллагаанд зарцуулах гээд байгаа юм. Тэгэхэд бид нар юуг эрүүл мэндэд хортой вэ гэхээр зэрэг тэр никотин агуулсан бүтээгдэхүүнүүд маань байгаа.

Тэгэхээр хамгийн эрсдэлтэй дээр нь тэр нөгөө нүүрсхүчлийнхээ саяын эрсдэлтэй зүйлүүд маань хамгийн өндрөөрөө байна. Тэгээд эрсдэлд нь суурилад дараа нь тэрнийхээ 50 хувь болгох юм уу, хэдэн хувь болгох юм тэр бусад бүтээгдэхүүндээ хэр эрсдэл багатай вэ гэдгээрээ тооцё гэсэн тийм саналыг манай Эрүүл мэндийн яам бол сайдад танилцуулсан байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд ээ дэгээ сахина шүү гишүүд ээ. Дэгээрээ явна. Одоо Мөнхбаясгалан гишүүн дахиж тодруулж байж хариултаа авах ёстой. Дэгээрээ л явахгүй бол. Дэг танилцуулахгүй бол энэ ингээд бүр сунжраад хойшоогоо ингээд дураараа дураараа юм байж болохгүй. Бид нар чинь хууль тогтоож байгаа бас хууль хэрэгжүүлэх улсууд шүү.

Дэгийн тухай хуулийн 9.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа дараах зарчмыг баримтална.

9.5.1.Гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуух асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах.

Нэмэлт асуулт асуух нь байна шүү. Мөнхбаясгалан гишүүн нэмэлт асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Саяын хариултаас үзэхэд янжуур тамхи нь илүү хортой болж таарлаа донтуулдаг. Вэйп нь ч гэсэн хортой, донтуулдаг. Гэхдээ янжуур тамхиа гүйцэхгүй юм байна тийм үү? Тэглээ шүү дээ.

Тэгэхээр вэйп нь янжуур тамхинаасаа илүү татвартай болчих гээд байна. Энийг хариулаад өгөөч. Яагаад ийм байгаа юм бэ?

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ ерөөсөө илүү татвартай болох гээд байгаа зүйл байхгүй байгаад байгаа юм. Бид нар дүйцүүлэх буюу хамгийн зөөлөн хэлбэрийн дүйцүүлэлтийг хийсэн юм. Хамгийн хатуу хэлбэр гэх юм бол энэ чинь одоогийнхоосоо 2 дахин өндөр байгаад байгаа юм бусад улсуудын жишгийг харахаар. Хамгийн зөөлөн дүйцүүлэлтийг бид нар хийж өгч байгаа юм.

Бидний анхны санал бол электрон тамхины биет үнийн дүн өндөр байгаа учраас татварынх нь хэмжээ нь бол үр нөлөө үзүүлэх нь бага. Тэгээд үе шаттайгаар нэмье. Гэхдээ энэнээс багаар бол тооцоолчихсон байсан гэсэн үг. Тэгээд яах вэ энэ удаагийн тэр Засгийн газраас тэр санал өгөөд та нар шингэн тамхи вэйпийг дэмжээд байна шүү дээ гэдэг санал дээр үндэслээд хамгийн зөөлөн хэлбэрийн байх дүйцүүлэлтийг аваад бид нар хийсэн.

Тэгээд одоо хамгийн хямдхан ерөнхийдөө ийм электрон тамхи гаалиар бол 9 мянган төгрөгөөр орж ирж байгаа юм байна лээ. Тэгээд энэ бүтээгдэхүүн онцгой албан татвар төлдөггүй. Гаалийн албан татвар 5 хувиар л нөгөө бараатай адилхан төлдөг. НӨАТ бол хэрэглэгч төлж байгаа. Тэгээд зах зээл дээр яг энэ бүтээгдэхүүн 9 мянгаар орж ирээд 18 мянгаар зарагддаг гэсэн үг. Тэгэхээр татвар юугаа гарсан бол ер нь бол 2 дахин margin-тай гэсэн үг.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут.

О.Номинчимэг: Тэгээд энэ бүтээгдэхүүн гаалийн албан татвараа 2 миллилитрээр орж ирээд ингээд нөгөө бүх татвараа ингээд тооцох юм бол орж

ирэх үнийн дүн нь бол татвараа нэмэхээр 19 мянга болж байгаа байхгүй юу. Одоо 18 мянгаар зарагдаж байгаа бүтээгдэхүүн 19 мянга. Тэгэхээр энэ үйлдвэрлэгч оруулж ирж байгаа хүмүүс ямар хэмжээний margin буюу ашиг олох вэ гэдгээс бүтээгдэхүүн хамаарна. Өмнө нь бол эд нар чинь 100 хувийн ашигтай ажиллаад байна шүү дээ. Тэгээд бид нар татвараа өгөөд өгөхөөр 100 хувийн ашигтай байх юм бол 30 хэдэн мянга. Ингээд зарагдахгүй юм байна гэх юм бол арай бага ч гэдэг юм уу. Энэ үнэ тогтоох асуудал бол үнэхээр энэ үйлдвэрлэгч орж ирж байгаа нөхдүүд яаж энэ зах зээл дээр манипуляц хийхээс л хамаарна. Тэгэхээр бүүр аймаар үнэтэй болох гээд байгаа зүйл бол байхгүй. Энэ бол нөгөө мэдээллийн төөрөгдөл гэж.

Миний, бид нарын хамгийн их анхаарсан зүйл бол хүүхдүүд юунд ороод байна гэхээр янжуур тамхи маш хямдхан байна. Ялт ч үгүй Монгол Улс янжуур тамхины хувьд Монгол улсад хамгийн хямдхан болчихсон байна. Энийгээ татварын бодлогоороо бид нар ихэсгэх ёстой. Тэр анхааруулга бүх юмыг нь сайжруулах ёстой.

Хоёрдугаарт электрон тамхи үнэхээр ямар ч хуулийн зохицуулалтгүй байгаа болохоор.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Евразийн хэлэлцээрээс болоод янжуур тамхи бараг үнэгүй шахуу болчихсон тийм үү? Та өөрөө энэ талаар мэдэгдэл хийж байсан Евроазийн хэлэлцээрээс болоод. Жилдээ хорт хавдраар нас барж байгаа хүмүүсийн тоо 3400 гаруй болсон. Тэгэнгүүт энэ янжуур тамхинаасаа хор багатай энэ тамхи дээр илүү үнийг нь нэмчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр таныг байна шүү дээ ингээд харахаар янжуур тамхины лоббинд өртөж байгаа мэт. Намайг ингээд ярингуут нөгөө вэйпийн талын юунд өртөж байгаа мэт, лоббинд өртөж байгаа мэт.

Гэхдээ бодит байдал дээрээ яг ийм л харагдаад байна л даа. Янжуур тамхинд их боломж олгоод, хор багатай, донтолт багатай энэ цахилгаан тамхинд татварын ачаалал буюу угаасаа ч үнэтэй бүтээгдэхүүн тийм үү илүү тийм боломжгүй болгож байгаа яг бодит байдал нь энэ байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг мушгин гуйвуулахгүйгээр та нар дахиад наадхаа.../минут дуусав./

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Янжуур тамхины энэ татварыг тэглэж болохгүй. Би ч гэсэн ингээд хэдэн сайд нартайгаа, ах нартайгаа тэрийг оруулж ирж байгаа Засгийн газар өнөөдөр оруулж ирж байна. Энэ хууль дээрээ ч гэсэн бид нар ажиллаад оруулах боломжтой. Энэний бол үнэхээр эсрэг байгаа.

Тэгээд бид нарын хамгийн чухал харсан асуудал бол янжуур тамхины татвар байхгүй юу. Бид нар үе шаттайгаар үнэтэй болох гээд байна шүү дээ. Тэгж байж энэнээс гарна.

Электрон тамхины хүүхдүүд рүү их ороод байгаа учраас ямар зохицуулалт руу хийх вэ гэдгээ л харж байгаа юм. Энэ дээр ерөөсөө илүү татвар оногдож байгаа юм байхгүй. Та тооцооллыг нь хараарай. Харин ч зөөлөн хэлбэр яригдаж байгаа. Энэ дээр тэгээд ажлын хэсэг хэрвээ үнэхээр саналаа гаргах юм бол

саналаа гаргаж болно. Энийг дэмжээд гэхээсээ илүүтэйгээр энэ чинь ерөөсөө бүгдээрээ хортой бүтээгдэхүүн хэрэглээг нь багасгая гэж байгаа юм.

Электрон тамхи нь яг янжуур тамхинаас нийгмийн хүрээнд, хүн ам зүйн хүрээнд хор багатай юу гэдгийг үнэхээр тийм судалгаа гарсан юм уу үгүй юу гэдгийг Эрүүл мэндийн яам хариулах хэрэгтэй. Дэлхий нэг дээр ч тийм судалгаа байхгүй. Фокус судалгаа хийгээд дэлхийн улс орнууд одоогоор бол илүү хор багатай юм гэдэг тийм нарийвчилсан.../минут дуусав./

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Би тодорхой асуултыг Ганзориг шинжээчээс, Эрүүл мэндийн яамны Ганзориг шинжээчээс тодорхой асуулт асууя. Та 2 ч гишүүний асуулт дээр яг нэг судалгааг хэллээ.

Өөрөөр хэлбэл, янжуур тамхи электрон тамхинаас илүү хор хөнөөлтэй юм гэдэг зүйлийг хэллээ. Энэ судалгааны эх үүсвэр яг хаанаас хийсэн ямар судалгаа вэ гэдгийг хариулж өгөөч. Нэг.

Хоёрдугаарт таны 2 удаагийн асуултад хариулж байгаа 2 хариулт чинь хоорондоо зөрөөд явчихлаа. Эхний асуулт дээр та никотин гэдэг бол никотины асуудлыг яриагүй юм бусад эрүүл мэндэд хортой асуудлыг нь яриад байгаа юм гээд бусад зүйлсийг нь баахан агуулга ярилаа. Тэгвэл никотин эрүүл мэндэд хоргүй юм уу гэж.

Гэтэл хоёр дахь асуултад хариулахдаа никотин агуулаагүй бүтээгдэхүүнээс татвар авах шаардлагагүй гэж байна лээ. Тэгэхээр энэ электрон тамхи чинь никотин агуулаагүй юм уу, яг юу гэсэн үг вэ? Энэ нь ойлгомжгүй байна. Уучлаарай Нарантуяа-Нара гишүүн ээ би өөрийнхөө цагт асуултаа асуучихъя. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөөч нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Эрүүл мэндийн яамны хийсэн судалгаа гэдэг хариулт хэрвээ гарвал надад судалгааны арга, аргачлалаа тодорхой, хамрах хүрээгээ тодорхой хэлж өгөөч. Дээр нь Төсвийн байнгын хорооны даргад тавих хүсэлт байна яг энэ чиглэлээр хийсэн судалгааг саяын Ганзориг шинжээчийн ярьж байгаа судалгааг албан ёсоор авч өгөөч. Байнгын хорооны гишүүдэд энэ мэдээллийг авч өгөөч. Тэгээд энэ судалгааг бас аваад харчих нь зүйтэй байх гэж бодож байна.

Дараагийн асуулт би Гаалийн ерөнхий газраас бас тодруулмаар байна. Мэдээж энэ тамхины агуулга, агуулж байгаа никотины хэмжээнээс хамаараад одоо утаат тамхи дээр бол ялгаатай байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ дээр электрон тамхи дээр гаргачихсан харьцуулчихсан судалгаа гаалийн байгууллагын хэмжээнд ямар судалгаа үндэслэдэг юм, судалгаа байна уу, үгүй юү?

Эрүүл мэндийн яамны шинжээчдийн хэлж байгаа байр суурь дээр мэргэжлийн гаалийн байгууллага ямар байр суурьтай байгаа юм? Энийг сонсчихоод тодруулъя.

Н.Наранбаатар: Хариулт гааль индрийн микрофон нээе .

С.Цэрэнчимэд: Гаалийн төв лабораторийн дарга Цэрэнчимэд. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Түрүүн хэлсэн янжуур тамхи, электрон тамхинаас юугаараа ялгаатай вэ? Хортой асуудлыг ярьсан.

Хэдүүлээ ганцхан жишээн дээр авч үзье. “Change Esse” гэдэг тамхи, тамхин бүтээгдэхүүн, янжуур тамхи дээр никотин 0.3 миллиграмм, 1 ширхэг тамхи нь 0.3 миллиграмм байдаг шүү. Тэгвэл 3 проценттой 3 процентын никотин агуулсан вэйп тамхи дээр 22 миллилитр. Энэ вэйп тамхи дээр 3 процент. Процентыг бид нар миллиграмм, килограммыг процент руу шилжүүлэх юм бол нөгөө 3 процент чинь 3 мянган миллиграмм болно шүү гэж хэлмээр байна. 3 мянга.

Тэгээд бид нар өнөөдөр 30 мянган соролттой вэйп тамхи 22 миллилитр 3 процентын никотин агуулсан гэдгийг Чинбүрэн гишүүн манай лаборатори дээр очиж байгаад бид нар энийг шилжүүлж үзсэн. Тэгэхээр 1 ширхэг соролтод 560-600 миллиграмм никотин очихоор байгаа. Тэгэхээр хэд дахин их вэ гэдэг нь эндээсээ харагдана.

Хоёрдугаарт нь янжуур тамхи дээр байгаа никотин бол ургамал гэдэг юман дотор нь өөрт нь байдаг. Никотин, бохь гэдэг юм өөрт нь байдаг юм байгаа. Харин электрон тамхи дээр орж байгаа вэйп тамхи дээр орж байгаа никотин бол нийлэг аргаар гаргаж авсан төв мэдрэлийн системд нөлөөлдөг ийм химийн бодис. Химийн бодис. Шингэн юмыг өнөөдөр яаж байгаа вэ гэхээр ууршуулаад ууршсан тэр хий нь гарахаараа утаа гараад тамхи татаж байгаа юм шиг мэдрэмж төрөөд байгаа юм. Тэрнээс энэ бол юу гэдэг юм тамхи шатаад ч юм уу, тамхины ургамал шатаад гарч байгаа утаа биш шүү. Энэ 2 өөр юм яриад байгаа юм шүү гээд. Энийг би яг химийн шинжилгээ хийдэг шинжээчийн хувьд тайлбарламаар байна. Тэгэхээр бид. Би хими технологич мэргэжилтэй. Монгол Улсын химийн зөвлөх инженер ийм хүн байгаа. Гаалийн байгууллагад би 28 жил гаалийн лабораторид ажиллаж байгаа ийм.

Дээрээс нь вэйп тамхи дээр түрүүн хэлсэн янжуур тамхи дээр мэдээж хэрэг бохь, никотин гэсэн ийм үзүүлэлт байгаа. Дээрээс нь мэдээж хэрэг нүүрсхүчлийн хий байгаа утаа татахаар.

Тэгвэл бид нарын шинжилгээ хийгээд тогтоочихсон найрлага, бүрэлдэхүүн дээр байгаад байгаа юман дээр вэйп тамхи дээр болохоор глицерин, пропилен глик, дээрээс нь амт, үнэр оруулагч химийн бодис нэмчихсэн байгаа. Тэгэхээр никотиноос гадна өөр бусад химийн бодисууд нэмчихсэн байгаа. Тэр дотор маань халаад ирэхээрээ өндөр градууд гараад ирэхээр олон химийн бодис болж сална. Тэгэхээр тэр гарч байгаа, салж байгаа, тэр химийн бодисууд үүсэж байгаа хорт нэгдлүүд чинь эргээд хавдар үүсгэх ийм магадлал бай.../минут дуусав./

Н.Наранбаатар: Микрофон хаая. Цаг дууссан, хариулт дууссан. Үүрийнтуяа гишүүн тодруулах уу? Индрийн микрофон өгье.

Д.Ганзориг: Эрүүл мэндийн яамны Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан шинжээч Ганзориг байна. Үүрийнтуяа гишүүний 3 асуултад хариулъя. Эхний асуулт нь бол судалгааны тийм нотолгоонуудыг асуусан. Тэгэхээр зэрэг нэлээд олон би энд. Эх үүсвэр нь үү? Бүүр хамгийн томоос нь эхэлье. Солонгос улсын когхорт судалгаа байгаа байхгүй юу. Тэр когхорт судалгаа нь болохоор зэрэг 2025 онд хэвлэгдсэн судалгаа байгаа. Тэгэхээр зэрэг энэ судалгаа маань ямар судалгаа байгаа вэ гэвэл тэрийг хэлэхгүй эсвэл би нэгэнт өнөөх нь бол Японы Нийгмийн

эрүүл мэндийн хүрээлэнгээс тийм эх үүсвэрүүд нь үү? Бүгдээрээ байгаа. Би энд ингээд танд файлаар өгсөн ч болно. Тийм байгаа тийм. Мөн Америкийн хамгийн бас том судалгаа бол бас байгаад байгаа юм. Америкийн Нэгдсэн Улсын Хүнс, эмийн агентлаг гэж ярьдаг. Эф Ди Эй гэж ярьдаг. Энэ бол нөгөө яриад байгаа нь халаадаг тамхи буюу heat tobacco гээд байгаа. Тэр дээр сая 2026 оны энэ 4 сард том зөвшөөрөл өгсөн байна. Тэр зөвшөөрөл дээрээ.../минут дуусав./

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Би эхний тодруулгаа Ганзориг шинжээчээс асууя. Тэгэхээр нэгдүгээрт энэ судалгаа бол Эрүүл мэндийн яамнаас биш гаднын байгууллагуудын хийсэн олон улсын судалгаануудын дүн байгаа юм байна. Материалуудыг нь авч нэгдүгээрт үзье.

Хоёрдугаарт халаадаг тамхи, электрон тамхи 2 ижилхэн үү? Та бол халаадаг тамхи дээр жишээ аваад байна шүү дээ. Гэтэл бид бол электрон тамхины асуудлыг яг ярьж байна. Энэ 2 ижилхэн үү ялгаатай юу?

Н.Наранбаатар: Индрийн микрофон.

Д.Ганзориг: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Халаадаг тамхи, электрон тамхи 2 бол ялгаатай. Халаадаг тамхи гэдэг маань болохлоор зэрэг ийм тусгай гаанс ашиглаж тэгээд яг тамхины навчнаас навч, үндсэн найрлага нь бол тамхины навч тэгээд яг нөгөө cigarettes буюу янжууртай төстэй. Тэгэхдээ бүрэн шаталт хийдэггүй 950 ч юм уу, 1000 градус хүртэл халдаггүй зүгээр 350 градус халаад зүгээр тэр юуг нь никотиноо ууршуулаад сороод авдаг тийм тамхи байгаа юм.

Электрон тамхи гэдэг маань болохлоор нөгөө шингэн дотор байгаа никотин. Нөгөө шингэнтэй тийм картридж шошготой шингэнүүд байгаа. Тэрийгээ хэлээд байгаа юм. Тийм аэрзолиуд тийм юм байгаа юм.

Харин тийм би яагаад энэ дээр халаадаг тамхины жишээ ярьсан бэ гэвэл энэ ийм байгаад байгаа юм. Японы хийсэн судалгаагаар нөгөө 3 төрлийн тамхиа судалсан судалгаа байгаа байхгүй юу. Нөгөө үгүй үгүй ээ харин тийм тэгэхээр зэрэг тэр дээр энэ ямар юу ярих гээд байна. Ийм байгаа юм халаадаг тамхинд ийм ийм ийм эрсдэлтэй тийм бүтээгдэхүүнүүд байна. Тэгвэл янжуурт ийм ийм эрсдэлтэй.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хугацаа дууссан. Та судалгаагаа бичгээр дараа нь өгөөрэй. Нэг байгаа билүү? Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Би сүүлийн тодруулгаа Цэрэнчимэд химич, хими технологич танаас асуух гэсэн юм. Энэ сүүлийн тодруулга болохоороо таны би асуултын түрүүн хариултыг гүйцээх гээд байна л даа. Тэгэхээр би бол ингэж ойлголоо таны хэлж байгаагаар электрон тамхинд байгаа үзүүлэлт бол утаат тамхи дээр нэмэх нь гээд ийм химийн элементүүд байна. Тэгэхээр энэ бол 2 мэргэжлийн хүний үг зөрөөд байна л гэж би хараад байна л даа. Тэгэхээр электрон тамхи бол таныхаар, Цэрэнчимэд инженер таныхаар бол илүү хор хохиролтой байх гээд байна. Илүү хор хөнөөлтэй байх гээд байна.

Ганзориг эрдэмтний, судлаачийн хэлж байгаагаар бол эсрэгээрээ тайлбар яриад байдаг. Тэгээд энэ дээр та ямар байдлаар хариултаа өгөх вэ? Би таны

хариултыг гүйцээчхээсэй гэж бодож байна. Түрүүний ярьж байсан асуудлыг. Би асуултаа асууж байна Нарантуяа-Нара гишүүн ээ, миний цаг.

Н.Наранбаатар: Гишүүд дэгээ барина. Индрийн микрофон.

С.Цэрэнчимэд: Асуултад хариулья ер нь бол нөгөө янжуур тамхи гэдэг маань түрүүн би хэлсэн тамхины ургамлаас бэлдээд гаргаж ирсэн тамхи юм. Тэгэхээр энэ дотор болохоор никотин, бохь гэдэг юм байх ёстой. Тийм никотин, бохь гэдэг нь. Электрон биш биш янжуур тамхи дээр.

Электрон тамхи буюу вэйпдээ энэ тамхи дээр болохоор энэ нь болохоор нийлэг аргаар гаргаад авсан никотин гэдэг бодис дээр дээрээс нь пропилен гликол гэдэг химийн уусгагчийг уусгаад, дээрээс нь глицерин нэмээд дахиад амт, оруулагч бодис нэмчихсэн ийм химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн юм шүү л гэж хэлэх гээд байгаа юм. Энэ хоёр ийм л өөр. Тэгэнгүүтээ янжуур тамхи дээр болохоор 0.3 миллиграмм, килограмм гэххээд ширхэг гэдэг бол вэйп дээр болохоор 3 процент гэдэг байгаа. 2 процент, 3 процент никотин агуулсан гэдэг үг байгаа. Энийг л би ялгах гэсэн юм. Нэг нь 0.3 миллиграмм ширхэг шүү. Нөгөөдөх нь 2-оос 3.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Нара гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Манайх бол яах аргагүй төсөв, татварынхаа асуудлыг барьсан мэргэжлийн Байнгын хороо. Тийм учраас мэдээж энэ татвар ноогдуулахдаа бас үндэслэл юмаа харъя. Эргээд тэр аль нь ч хортой нь үнэн. Гэхдээ арай бага хортойг нь дэмжвэл дэмжих татварын бодлого нь байвал хэрэглээ тэр зохистой юм руугаа явах юм гэдэг үүднээс асуудалд хандаж ярьсан.

Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах хууль орж ирсэн нь бол цагаа олсон, бас нэлээн эр зориг шаардсан хууль байсан. Үнэн. Зохицуулаагүй үлдчихсэн шинэ тутам бүтээгдэхүүнүүд дээр зохицуулалт хийж орж ирсэн. Юм төгс гэж байдаггүй. Үүнийг бид цаг алдалгүй шийдэх ёстой. Тийм учраас би Тамхины хяналтын тухай хуулийг бол өөрөө санаачлагчдынхаа ч нэг. Дэмжинэ. Тэгээд мэдээж цаг хугацааны эрхэд сайжирна биз ээ.

Энэ харин дагасан татварын хуулиудыг бол манай Байнгын хороо мэргэжлийн байнгын хорооныхоо хувьд дүгнэлт юмаа их зөв өгөх ёстой юм тэр Нийгмийн бодлого, хүний хөгжлийн байнгын хороо билүү Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо билүү тэр рүү зөв өгөх ёстой юм гэж.

Тэгээд би бол юу гэж байна гэхээр судлаачид нь орж ирээд 2 бүүр тэс өөр юм ярьцгаагаад л, бид хэд эндээ хоорондоо маргалдаад нь нэгэндээ энэнийх нь лобби юу, энэнийх нь лобби юу энэ тэр гэж яриад энэ тэр бол хэрэггүй. Хэдүүлээ энэ олон алтернатив санал бодлууд дотроос шингээлтээ хийгээд бас энэ хүн гэдэг

амьтанд бага ч болтугай нэмэр болчихоор юм гаргачихвал зөв юм. Би энэ талаас нь л хараад энэ асуудлыг яриад байгаа юм.

Тийм учраас би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг уламжлалт утаат тамхи энэ тамхины шинэ нэр төрлийн боловсруулалт хийчихсэн бүтээгдэхүүн хоёрынхоо энэ асуудлыг зөв харж, зохистой тэмцлийн тухай ойлголт байх ёстой шүү. Би бол аль болохоор хүний биед бага юм очдог нь багавтар татвартай байгаасай даа тэгвэл зөв болох юм гэдэг үүднээс асуудалд хандаж байна. Яг энийгээ би энэ Байнгын хорооны, тэр Байнгын хороо руу явах дүгнэлт, санал руу ороосой гэдэг үүднээс зориуд саяын энэ 3 дугаар зүйл дээр асуулт асуух гэж авсан юм. Тэрнээс цаг хугацаан дээр юу гэж асуулт асуугаад сууж байх вэ ойлгомж тэгээд энэ талаасаа асуудалдаа хандъя.

Тэгээд ер нь бол хэдүүлээ энэ үе гаргаснаараа бас энэ залуу үе, хүүхэд багачуудаа хорт зуршлаас хамгаалчих, дээр нь бас зохицуулагдаагүй харилцаануудыг зохицуулчих, тэгээд эцсийн дүн нь бол бас зөв. Тэр зохистой юм руу нь чиглэсэн байдлаараа явах магад ч үгүй эндээс. Дан ганц ширхгээр заадаг татварын ойлголтыг.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Үг хэлчхэв үү? Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ Номинчимэг нарын 76 гишүүнээс өргөн барьсан Тамхины хяналтын тухай хууль мөн биз дээ тээ? Тийм энэ дээр 5.7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг дээр тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, тамхи татах төхөөрөмжийн эд анги үйлдвэрлэх, худалдах, импортлоход энэ хуулийн 7, 7.1, 7.2 дугаар зүйл нэгэн адил үйлчилнэ гээд зөвшөөрлийг 3 задалчихсан байгаа байхгүй юу. Та ингээд юм ярихаар үгүй тийм юм байхгүй л гээд байх юм. Би цагаан дээр хараар бичсэн юмыг л ярьж байгаа юм. Зөвшөөрлийн хууль та зөрччихсөн байна гэдэг асуудлыг ярьж байна гэсэн үг. Тэгээд энийгээ ажлын хэсэг дээрээ та бүхэн энийгээ янзлаарай.

Хоёрдугаар асуудал тэр нүдний шилтэй хими технологич гэсэн үү? Хими юу гэс юу гэлээ ямар мэргэжилтэй хүн гэлээ гаалийнх гэсэн үү тэгээд би сая ингээд жоохон гайхаад байгаа юм нь юу вэ гэхээр аль алиных нь татвар нь өндөр байх ёстой. Аль аль нь энэ чинь хор хөнөөлтэй. Тэгээд шингэн тэр татдаг цахилгаан тамхийг хорт хавдар үүсгэгч гээд сая ярьчихлаа л даа. Тэгээд би Эрүүл мэндийн яамнаас юу асуух гээд байна гэхээр энэ тамхи татсантай холбоотойгоор энэ хорт хавдар хэчнээн хүнд тусдаг юм, зүрх судасны өвчнөөр хэчнээн хүн үхдэг юм, хорт хавдар хэчнээн хүн үхдэг юм яг бодит судалгаа байна уу? Эсвэл янжуур тамхи татахаар хорт хавдар тусдаггүй юм уу? Одоо энэ чинь ингээд сүүлдээ хараад байсан чинь нөгөө шингэнийг нь татахаар хорт хавдар тусдаг, энийг нь татахаар хорт хавдар тусдаггүй гэдэг ийм ойлголт өгөхөөр тэр эрхэм ярьчихлаа л даа. Би тэгээд мэдэхгүй ямар мэргэжилтэй хүн бол гайхаад мэдэхгүй асууж байгаа юм шүү. Нэгдүгээр асуулт тийм. Үгүй ээ үгүй ээ тэр сая эмэгтэй тийм нүдний шилтэй эмэгтэй.

Тэгээд хоёрдугаар асуудал татвар ногдуулахдаа никотин, хорт агууламжийн хэмжээгээр нь буюу никотины миллиграммаар нь, тэр таарыг миллиграммаар нь үнэхээрийн тэр шингэн тамхинд нь биед хортой тэр хар тугалга гээд сая яриад байгаа энэ асуудлууд байдаг бол тэрийг хорьж болно шүү дээ. Тэр шингэн тамхинд нь ийм бодис агуулж болохгүй гээд хорьж болно шүү дээ. Яагаад хортойг

нь мэдсээр байж та нар бол зөвшөөрөх гээд байгаа юм. Тэгснээ энэ болохоор ингээд илүү хортой юм гээд байх юм. Тэгсэн мөртөө Эрүүл мэндийн яам үгүй юм аа гээд байгаа байхгүй юу. Үгүй та нар бид нар тархиар наадахаа больчих л доо. Хортой юм бол яг тэр хорууд дээр нь татварыг нь ноогдуулдаг, бүүр ингээд илүү хортой юм байвал тэрийг нь хориглодог байх ёстой шүү дээ энэ хууль чинь. Бид нар ингээд хүүхэд энэ тамхийг татчих вий гэдэг санаа зовниж байгаа бол янжуурыг яагаад татахыг зөвшөөрөх гээд байгаа юм? Адилхан л үнэтэй байх хэрэгтэй шүү дээ. Зарчмын асуудал ярихад илт ингэж худлаа ярьж энд бид нарын тархиар наадаж болохгүй шүү дээ тэр эмэгтэй би ямар албан тушаалтай гэхихсэн билээ?

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Ганхуяг гишүүнээ би энэ бичсэн хуулиа мэдэж байгаа. Энэ дээр ямар ч нэмэлт шинэ төрлийн тусгай зөвшөөрөл үүсгээгүй байхгүй юу даа зөвшөөрлийн тухайд. Үгүй ээ 7.2.3-аар угаасаа энэ төхөөрөмж нь тамхин бүтээгдэхүүнтэй байгаа болохоор 7.1 дээр тамхи импортлох тусгай зөвшөөрлийн хүрээнд орж ирнэ л гэдэг ийм заалт байхгүй юу. Ерөөсөө л энийг хэлж байгаа юм. Тэрнээс Зөвшөөрлийн тухай хууль ерөөсөө зөрчөөгүй, шинээр гаргаагүй ийм байгаа. Засгийн газраас ч гэсэн ийм санал ирсэн.

Харин жинхэнээсээ Зөвшөөрлийн тухай хууль зөрчөөд ороод ирчихсэн асуудал чинь тэр скүүтерийн хууль байсан. Шинээр зөвшөөрөл өгөхгүй. Тэгэхдээ тэрийг бол бид нар санаачлагчийн хувьд ажлын хэсэг дээр ажиллахгүй. Тамхины хууль дээр бол шинэ төрлийн тусгай зөвшөөрөл ерөөсөө бий болох гээгүй. Тамхи, тамхин бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл нэг л бүтээгдэхүүн нэг л тусгай зөвшөөрөл байгаа. Энэнийхээ л дагуу л орж ирнэ гэдэг л юм байхгүй юу даа. Тусгай зөвшөөрөл чинь ерөөсөө шинээр үүсгээгүй. Энийг чинь би ч гэсэн Зөвшөөрлийн хууль дээр ажиллаж байсан мэднэ шүү дээ. Та энэ дээр яачхаарай. Үнэхээр тэр буруу ойлгогдохоор юм байгаа бол ажлын хэсэг харчихна биз. Тэрнээс Зөвшөөрлийн хууль зөрчиж шинээр үүсгэж байгаа юм ерөөсөө байхгүй гэдгийг би бас давтаж хэлье.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Сайнзориг гишүүн энд ороод ирсэн. Би Сайнзориг гишүүнийг энэ тийм 5.7 дугаар зүйлийг хараадхаарай гэж байгаа. Энэ хар аа Зөвшөөрлийн хууль дээр таслал болгоноор шинэ зөвшөөрөл нэмэгддэг байхгүй юу даа. Таслал болгоноор. Тэгээд энэ хар аа Зөвшөөрлийн хууль дээрээ эрх аваагүй мөртөө алив Номио түр байж байгаарай. Зөвшөөрлийн хуульдаа хөндөлт хийгээгүй зүгээр салбарын хуулиараа 3 зөвшөөрөл нэмчхэж байгаа байхгүй юу. Салбарын хуулиар. Энэ чинь гаалийнх нь байна уу? Хэн Чимидсүрэн энэ дээр надад тайлбар өг одоо. Гаалийнх нь болохоор салбар хуулийг нь барьдаг ч юм байдаг, Зөвшөөрлийн хуулиа бариад явдаг. Одоо энэ хар аа ингээд дараа нь Зөвшөөрлийн хууль ингээд явангуут мэдэхэд нөгөө 300 зөвшөөрөл чинь 1000 зөвшөөрөл болдог шалтгаан чинь энэ байхгүй юу. 3 зөвшөөрөл салбар хуулиар нэмчихсэн асуудлаа нэмээгүй гэж ярьж байгаа юм.

Сайн аа чи 5.7 дугаар зүйлийн 7-гийн штрих 2.3-ыг хараадхаач. 7-гийн штрих 2.3-ыг хараадхаач. Би энэ хуулийг чинь бичилцсэн, боловсруулчихсан, баталсан хүн байхгүй юу. Битгий ингэж худлаа ярь л даа. Би зүгээр энийгээ.../минут дуусав./

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн асуулт асууя. Бадамсүрэн гишүүн. Цагийг нь эхнээс нь өгчих. Асуулт уу?

М.Бадамсүрэн: Түрүүн би нөгөө яг лаборатори чинь яг шинжилгээгээ хийж чадаж байгаа юм уу, цаашид яах юм бэ гэж асуугаад байсан. Тэгээд олигтой хариулт авч чадаагүй. Наадах чинь яг ингээд яг хортой бодис нь яг юу юу байгаа юм? Энэнээс нь хамаарч ямар татвар ноогдуулах юм гэдэг харилцааг зохицуулах гэж байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь хангалтгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас энд Эрүүл мэндийн сайдын буюу хариуцлагатай албан тушаалтны, Засгийн газрын гишүүний санал, дүгнэлтийг Байнгын хороон дээр сонсох ёстой гэж би үзэж байна. Тэгэхгүй бол энэ ингээд ажлын хэсэгт орсон нэг судлаач, нэг лабораторийн эрхлэгч хоёр хоёр өөр юм яриад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар алинд нь итгэх юм? Тийм учраас Эрүүл мэндийн сайд энийгээ сонсох ёстой. Би Байнгын хорооны даргад ийм санал тавьж байна.

Хоёрт нь энэ Батжаргал гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Татвараар зохицуулах гээд байгаа байхгүй юу. Архи хортой. Тэр дотор спирт, бусад хүний биед хортой элементүүд байгаа. Тийм учраас онцгой албан татварын хуулиар шимийн архи, пиво 2 бага татвартай. Коньяк, виски, цагаан архи нь өндөр татвартай. Тэгээд тэр шиг энэ тамхи чинь өөрөө тэр утаат тамхи, дүнсэн тамхи, энэ шингэн тамхи вэйп гээд байгаа энэ тамхинуудыг чинь энэ хортой бодисынх нь хэмжээнээс хамаараад татварыг ноогдуулах асуудлыг л би түрүүнээс хойш хөндөөд байгаа байхгүй юу. Тэгэнгүүт зарим хуулийн ажлын хэсгийн гишүүд ингээд хүүхдийн хөгжлийг дэмжинэ гэххээд одоо ийм юм яриад байгаа гээд ингээд ерөөсөө ингээд тийм аягүй тийм сонин байдалтай ингээд хандаад байх юм субьектив. Ерөөсөө тийм юм байхгүй. Би хэлсэн шүү дээ энэ зохицуулалтыг нь дэмжиж байгаа.

Гэхдээ манай Төсвийн байнгын хороо татварын асуудал дээрээ л гол нь саналаа өгч байгаа юм байгаа биз дээ. Тийм учраас энэнтэй холбоотой зүйл дээрээ анхааръя гэдэг зүйлийг л хэлээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нөгөө ийм сав, хэмжээнээс нь хамаарсан, дээр нь тэр хортой бодисынх нь агууламжаас хамаарсан байдлаар татвараа тогтоох асуудал байгаа биз дээ? Тэгэхээр ерөөсөө энэ нэг л тийм магадгүй би нөгөө хуульч биш болохоор бас ойлгохгүй байж магадгүй. Гэхдээ бас практик энэ дээр чинь бас ойлголт байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйл чинь ерөөсөө тийм яг байгаа онохгүй байгаад байна. Энэ хэлэлцүүлэг их үр дүнтэй болох ёстой гэж үзэж байна. Тийм учраас би түрүүн бас асуусан Номинчимэг гишүүнээ та бол хууль санаачлагч. Их Хурлын даргын захирамжаар хуулийн ажлын хэсэг байгуулсан хэлэлцүүлэг бэлтгэх. Тэр ажлын хэсэг чинь энэ дээр хариулах ёстой байхгүй юу тийм биз дээ айн? Зөвхөн хууль санаачлагч хариулж байна. Нөгөө талд нь 2 судлаач хариулж байна. Тэгээд нөгөө хуулийн төслийг хэлэлцүүлж бэлдэх үүрэгтэй том ажлын хэсэг маань хариулах ёстой шүү дээ гол нь. Тэгэхээр энэ чинь ингээд бүгд өөр өөр байгаа учраас ингээд бид нар нэгдсэн ойлголт бол авч чадахгүй байгаад байна. Тийм учраас яах вэ? Энэ дээр бүх энэ хууль санаачлагч болон ажлын хэсэг.../минут дуусав./

Н.Наранбаатар: Ажлын алба ажлын хэсэг Баасанжаргал гишүүнийг дуудаарай. Сая байж байгаад гараад явчхаж. Хэн хариулах вэ саяын Бадамсүрэн гишүүний асуултад? Хэн хариулах вэ? Ажлын хэсэг Баасанжаргал гишүүнийг дуудаарай. Номинчимэг гишүүн. Тэр хооронд би заалт уншъя.

Улсын Их Хурлын тухай хууль 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуулт хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэсэн байгаа шүү.

Номинчимэг гишүүн хариулт Ажлын хэсэг хэн хариулах вэ? Цаг хэмнээд Нарантуяа-Нара гишүүн асуултаа асуугаад явж байна. Дараа нь Баасанжаргалыг ороод ирэхээр хариултаа авъя.

М.Нарантуяа-Нара: Монгол Улсын Их Хурал аливаа асуудал, хууль тогтоохдоо олон улсын том том батлагдсан, нотлогдсон судалгаан дээр суурилагдсан судалгааг үндэслэх юм уу? Эс үгүй бол гаалийн шинжээчийн дүгнэлтээр асуудалд хандах юм уу гэдэг энэ асуудлыг мухарлах хэрэгтэй байна. Хэдийгээр 28 жилийн туршид гаальд шинжээчээр ажилласан мэдлэг, мэргэжил, ур чадвартай ч гэсэн энэ хүн үнэхээр тамхины шинжээч, судлаач мөн юм уу? Тамхи болон тамхины дотоод бүтэц болон түүнээс улбаатай эрүүл мэндийн хор хөнөөлийг хэмжих тийм яг тэр мэргэжлийн хүн мөн юм уу гэдэг ийм асуулт байна. Ингээд глицерин юу юу гэнэ вэ энэ энэ юмнууд нийлээд ингээд хорт хавдар үүсгэж байна гэж байна. Тэр нь ямар судалгаагаар нотлогдсон юм? Тэгвэл нөгөө талд олон улсын дэлхийн жишиг дэлхийн томоохон эрүүл мэндийн суурь судалгааг хийдэг ийм судалгааны байгууллагуудын судалгааг хэлээд байхад тэд нарыг ойшоохгүй мөртөө гаалийн шинжээчийнхээ асуудалд ингээд илүү ингээд акцент өгөөд байдаг нь энэ бол үнэхээр учир дутагдалтай хэрэг.

Эсвэл энэ гаалийн хүн энэ гаалийн шинжээч эмэгтэйг би ур чадвар, ажил мэргэжлийг нь хүндэлж байна. Гэхдээ энэ хүн яг тамхины мэргэжилтэн мөн юм уу судлаач юм уу? Ганцхан энэ хүний аман дүгнэлтээр бид нар өнөөдөр шийдвэр гаргаад хууль тогтоогоод явах нь яг ямар утга зүйтэй вэ гэдэг дээр асуулт асууя.

Дээрээс нь хүүхэд хамгаалъя гээд байгаа юм. Сайхан. Гэхдээ эсрэгээрээ харин хүүхдийг хамгаалах биш өшөө вэйпээс ч илүү эрсдэлтэй бүтээгдэхүүн рүү шахаж болох, оруулж болох эрсдэл байна. Дээрээс нь хар зах зээлийн тооцоолол хийсэн юм уу? Хар зах зээлийг яаж хянах юм? Одоо Сингапур улс вэйпийг хориод эсрэгээрээ хууль бус худалдааг хянаж чадахгүй өөрсдөө энэ хуулиа бараг буцааж тавих дээрээ ингээд байж байна шүү дээ. Захын л интернэт рүү ороод л мэдээлэл авч байна шүү дээ. Үгүй тэгж байхад хар аа бид нар ингээд ийм яг хүүхдэд тулгачихсан юм ганцхан вэйпийн үнэр амт юм шиг аашлаад байгаа нь үнэхээрийн бас учир дутагдалтай.

Энэ хуулийг бид нар эцэслэж, тогтоож батлахдаа маш олон талын хүчин зүйлийг судлаад, судалгааны үндэслэлийг нь үндэслээд нийгэм, эдийн засаг, санхүү, иргэдийн халаас, эрүүл мэнд, үнэхээрийн бодит учруулж байгаа энэ хортой, эрсдэлтэй нөхцөл байдлыг үнэлж байж бид нар хууль тогтоох ёстой болохоос биш зүгээр л нэг хүн энэ бол ингээд ийм аюултай байгаа юм гэнгүүт л бид нар айгаад л хууль тогтоогоод л нөгөө талд тэгвэл эрх нь зөрчигдөж байгаа, хөндөгдөж байгаа хүмүүсийн эрх ашгийг хэн хамгаалах юм? Улсын Их Хурал энэ чинь олон талаас нь харж, шинжилж, дүгнэж, хүчин зүйлийг нь харж байж шийдвэр гаргах ёстой биз дээ. Үгүй тэгээд энэ гаалийн шинжээчийн дүгнэлтээр бай явах юм уу? Олон улсын дэлхийн жишигт нийцсэн бүх улс орнууд.../минут дуусав./

Н.Наранбаатар: Одоо хариултаа хэлэхийн өмнө нэг зүйлийг сануулахгүй бол болохгүй нь. Энэ манай Байнгын хороогоор Онцгой албан татварын тухай хуулийг хэлэлцэж байгаа. Тийм учраас хэдүүлээ хадуураад тамхины хор хөнөөл гээд тэр чинь 15 цагаас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр яригдах юм. Тэгэхээр бид нар жоохон сэдвээсээ хазайгаад яваад байна. Энийг сануулчихъя. Тэгээд гишүүд, ажлын хэсгийнхэн энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой л ярина. Одоо өөр зүйл яривал дараагийн хүн рүү шилжүүлэхээс өөр аргагүй болно. Тамхины тухай, хор хөнөөлийн тухай ярих гэж байгаа бол нөгөө Байнгын хороон дээр очих чи тийм чөлөөтэй байгаа шүү. Одоо хэн хариулах вэ? Энэ дээр татвартай холбоотой л та ярина шүү. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ бас Бадамсүрэн гишүүн түрүүн хөндсөн татварын асуудал бид нар ярьж байгаа. Тэгэхээр бид нар бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллага бусад гарч байгаа энэ нөгөө мэдээлэл дээр үндэслээд бодлогоо боловсруулаад ирсэн. Гэхдээ би танд хэлсэн бид нар бол эхний ээлжид бол электрон тамхийг хуулийн зохицуулалтад оруулах нь чухал. Тэгээд энэ зар сурталчилгаа хийлгэхгүй байх нь чухал. Сургуультай ойрхон зарахгүй байх нь чухал. Дотор орчин татахгүй байх нь чухал. Энэ бол дам тамхидалт үүсгэдэг. Ингээд мэдээж эдийн засгийн аргаар тэмцэнэ.

Бидний анхны санал бол энэ татвар дээр бол арай өөр байя гэсэн боловч Засгийн газрын саналын үндсэн дээр ийм болсон байгаа. Тэгэхээр мэдээж энэ хууль Улсын Их Хурлынхаа босгыг давчихсан. Ажлын хэсэг Чинбүрэн гишүүн маань ахалж байгаа. Тэгээд энэ дээр саналуудаа гаргаад та бүхэн мэргэжлийн Байнгын хорооны хувьд саналуудаа гаргаад ажлын хэсэг маань тэрний дагуу өөрчлөх юмаа өөрчлөөд орж ирэх бүрэн боломжтой. Тэгэх гэж л бид нар Байнгын хороогоор санал, дүгнэлтээ ярилцдаг, нэгдсэн шийдэлд хүрэхийн төлөө явдаг ийм байгаа.

Тэгэхээр энэ дээр бол та бүхэн маань бас санал, дүгнэлтээ өгөөд Чинбүрэн гишүүн маань ирчихсэн байна. Татварын асуудал дээр үнэхээр энэнийх нь дагуу явах ёстой гэх юм бол та бүхэн маань энэ дээрээ бол мэдээж ажлын хэсэг ажиллаж байгаа гэж би бол ойлгож байгаа. Би бол нөгөө хууль санаачлагчийн хувьд анх ямар үзэл санаагаар оруулж ирсэн бэ гэдэг байр сууриас энийгээ бол тайлбарлаж байгаа шүү. Өөрчлөх нь угаасаа энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Бид нарын хувьд нэн яаралтай хийх асуудал бол ерөөсөө л энэ ерөөсөө хууль гарч чадахгүй байсан, зохицуулалтад оруулж чадахгүй байсан. Ингээд задгай алдчихсан энэ юмаа хойноос нь ч хамаагүй яагаад тамхи гэж үзээд татвараа авдаг больё, зар сурталчилгаа хамаагүй хийхээ больё, дотор орчин татахаа больё жоохон цэгцэд нь оруулах хэрэгтэй байна үнэхээр.

Тэгээд энэ дээр нь мэдээж эдийн засгийн ялангуяа бид нарын маш сайн хийсэн тооцоолол бол энэ янжуур тамхины тооцоолол байгаа юм. Үнэхээр далд зах зээл энэ дээр бол үүсэхээргүй. Эргэн тойрны улсууд маань манайхаас 3-4 дахин үнэтэй янжуур тамхитай болчихсон байгаа. Манайх үнэхээр бага тамхины үнэтэй байгаа байхгүй юу. Тэн дээр нь бид нар бүгдээрээ өрхийн орлого болон манай улсын эдийн засгийн чадамж, бусад бүх Дэлхийн банк эд нараас хийж байсан судалгаануудыг үндэслээд инфляц гэх мэт энэ чинь гадаад зах зээлтэй холбоотой. Бид нар чинь доллароор л энэ бүтээгдэхүүнүүдийг авч байгаа шүү дээ. Тэр бүх судалгаан дээр үндэслээд бид нар янжуур татвараа ингэж 2030 он хүртэл үе шат дараатай нэмэх юм бол 14 хувиар тамхидалт буурах нь гэдэг судалгааг бол хийсэн байгаа.

Тэгээд энэнийхээ дагуу янжуурын татвар бол маш чухал байхгүй юу. Бид нар үнэхээр энэ бүтээгдэхүүн бол Монголд бол 1-хэн долларын үнэтэй эргээд бараг Монголоос гадаад руу Хятад руу ч юм уу, Орос руу контрбанд хийж байна шүү дээ. Яагаад гэвэл хэтэрхий хямдхан байгаа учраас. Хэтэрхий хямд, муу чанартай ийм байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээрээ үндэслээд л бид нар татварын бодлогуудаа ажлын хэсэг дээр хэлэлцээд Улсын Их Хурлаар хэлэлцээд явцгаая л гэж хэлмээр байна.

Н.Наранбаатар: Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Байнгын хорооны даргаа энэ хор хөнөөлтэй чанараас нь үүдээд татварыг тогтоож байгаа учраас хор хөнөөлтэй чанарыг нь ярихаас өөр аргагүй байхгүй юу. Энэ хор хөнөөлийг бид нар юун дээр үндэслээд тогтоож байгаа юм. Гаалийн шинжээчийн амаар бид нар тогтоох юм уу, эс үгүй бол судалгаа, шинжилгээнд олон улсын байгууллагуудын бодит судалгаан дээр маш олон хүчин зүйл, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн маш олон хүчин зүйл дээр тулгуурласан судалгаанаас бид нар үндэслэж авч явах юм уу гэдэг чинь энэ өөрөө хор хөнөөлийг ярихаас өөр аргагүй байхгүй юу. Хор хөнөөлийн харьцуулсан судалгаа байхгүй байж байж зүгээр гаалийн шинжээчийн үгээр өө тийм аймаар юм байна гээд ингээд суугаад байх юм бол энэ бол Их Хурлын шийдвэр оновчтой болохгүй. Эргээд нөгөө талд нь маш олон хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байгаа. Эрүүл мэндийн асуудал хөндөгдөж байгаа. Эсрэгээрээ бүүр доройтож болохуйц өөр мансууруулах бодис, өөр хэрэглээ, өөр хууль бус худалдааны ийм асуудал хөндөгдөж байгаа учраас хор хөнөөлийг ярих нь зайлшгүй юм.../минут дуусав./

Н.Наранбаатар: Дэгээрээ л явна хэдүүлээ. Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Нара гишүүн би танд бас яаж тайлбарлах вэ гээд бүр ингээд гайхаад л байна л даа. Манай Монгол улс чинь электрон тамхины ямар ч зохицуулалтгүй байгаа Африкийн хэдэн улсын л нэг. Тэд нартай хамт л юм байгаа шүү дээ. Бүх энэ улсууд чинь энэ электрон тамхины зохицуулалт хийгээд хортой бүтээгдэхүүнээ гээд ингэчихсэн байгаа юм. 82 улс ингэчихсэн байгаа. 46 улс хорьчихсон байгаа. Тас хорьчихсон байгаа шүү дээ болохгүй энэ бол гээд. Цаашид донтолт үүсгэх юм байна. Хэцүү юм аа гээд.

Тэгэхээр энэ улс болохоор тооцоо судалгаагүй та хийсэн гэж үзээд байгаа юм уу? Эд нар чинь бүгдээрээ л өөрсдийнхөө улс орныхоо нөхцөл байдлыг харж байгаад зохицуулалтаа хийж байгаа. Тэр дундаа тэр 82 улс зохицуулалтынх нь 20 нь үнэр, амт дээр хязгаарлалт тавьчихсан байгаад байгаа байхгүй юу. Тэнд чинь бид нарын нөгөө нийгмийн эрүүл мэндээрээ манлайлдаг Шинэ зеланд нь, Австрали нь, Канад нь, Дани нь гээд, Эстон нь гээд тэр улсууд үнэр, амттаных хязгаарлалт бас хийчихээд байгаа. Тэгэхээр хуулийн зохицуулалтаа хийх нь ялт ч үгүй зөв. Тэгээд судалгаа бүгдээрээ л эд нар чинь.../минут дуусав./

Н.Наранбаатар: Тодруулах уу? Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Бас түрүүн хууль санаачлагч болон ажлын хэсгийн гишүүн бас ноцтой юм хэллээ шүү дээ энэ вэйпийнхэн ерөөсөө татвар төлдөггүй гэж. Татвар төлдөггүй юм уу? Одоо вэйп гэдэг чинь хэзээнээс нэвтэрч орж ирсэн билээ? Нэг ч татвар төлөгдөөгүй юм уу? Тэгвэл энэ бол ноцтой асуудал мөн. Татвар төлдөггүй бол. Тэгэхээр зөвхөн НӨАТ-ын л татвар л төлөгдөж байна.

Бусдаар оруулж ирж байгаа этгээдүүд гааль, татвар юуг хийхгүй байгаа юм байна шүү дээ тээ?

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Одоогийн манай хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар электрон тамхи чинь тамхин бүтээгдэхүүн гэж үзэгдэхгүй байгаа учраас онцгой албан татвар төлдөггүй. Янжуур тамхи, халаадаг тамхи чинь гаалийн албан татвар нь онцгой бүтээгдэхүүн учраас 30 хувь, 20 хувь байдаг. Электрон тамхи болохоор одоо бид нарын хэрэглэж байгаа гаднаас орж ирж байгаа компьютер, цаас энэ эд нар чинь бүгдээрээ гаалийн албан татвар 5 хувь байдаг байхгүй юу. Яг тэрэнтэй адилхан 5 хувийн гаалийн татвар л төлдөг электрон бараа шиг, бусад бүтээгдэхүүн шиг. Тэгээд онцгой албан татвар төлдөггүй. НӨАТ мэдээж хэрэглэгч дээр очиж байгаа болохоор төлнө. Тэр бол хэрэглэгч яагаад тэр чинь ингээд суутгагдаад явдаг ийм л татварын сан. Тэгэхээр тийм 5 хувийн татвар төлдөг. Гэхдээ тэр нь бид нарын хэрэглэж байгаа утас, бид нарын импортоор оруулж ирж байгаа энэ цайны аяга эд нартай адилхан татвар байхгүй юу. Бүх бүтээгдэхүүнүүд чинь ерөнхийдөө ийм байгаа юм. Электрон тамхи тамхи гэж үзэгдээгүй болохоор ямар ч онцгой албан татвар төлөхгүй байгаа гэдгийг хэлье.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ Номинчимэг гишүүний санаачилсан энэ хуулийг дэмжиж гарын үсэг зурсан нэг гишүүн байгаа юм. Тамхины эсрэг “за” гэж хэлдэг ямар ч ээж хүн байхгүй, эх хүн байхгүй. Ер нь хэн ч байхгүй. Бүгд эсрэг байна шүү дээ. Тамхи, архины эсрэг, мансууруулах бодисын эсрэг явна.

Гэхдээ ийм юм байгаад байгаа юм. Хятад улс Маогийн үед байна шүү дээ энэ болжмор шувуу тариа, будаа идээд байна гээд бүх болжмороо хядчихсан юм. Хорхой шавж нь дийлдэхээ больсон. Түүн лугаа бид өнөөдөр сайхан лоозонгийн доор асуудлыг шийдмээргүй л байгаа юм л даа. Одоо манай зарим гишүүд ингээд наадам боллоо хуулиа хурдан батлуулъя гээд л, Засгийн газар ч наадам боллоо, Их Хурал ч наадам боллоо бид нар наадмын өмнө гоё гоё нэртэй хуулийг баталчихсан байх үүрэггүй гишүүд ээ. Тэгэхээр жоохон нухацтай үзэхгүй юм уу? Онцгой албан татваргүй байгаа, зохицуулалтгүй байгааг зохицуулалттай болохыг би дэмжээд байгаа юм. Үзэл баримтлалынх нь хувьд дэмжээд байгаа юм. Гэтэл хор нөлөөнийх нь хувьд арай багатай байгаа нь бага татвартай байх ёстой энэ шударга зарчим. Энэ манай Байнгын хорооны шийдэх асуудал мөн байхгүй юу.

Гэтэл 2 шинжээч, 2 судлаачийн дүн зөрөөд байгаа байхгүй юу. Гаалийн лабораторийн шинжээч болохоор наад вэйп чинь шууд хорт хавдар үүсгэж байна гэж манай Чинбүрэн гишүүн хэлсэн гээд ингээд яриад байгаа юм. Тэгэнгүүт та очоод шууд хорт хавдар үүсгэдэг байна гэж хэлсэн байна шүү. Тэгэнгүүт энд Эрүүл мэндийн яамны эмч мэргэжилтэй шинжээч болохоор өөр юм ярь яриад байгаа юм. Тэгээд бид нар энийг алинд нь итгэх юм? Ажлын хэсэг яагаад ийм хүмүүс ингээд энэ алийг нь үндэслээд байгаа юм? Аль таалагдсанаа үндэслэдэг юм уу? Чинбүрэн гишүүн бол элэгний маш сайн алдартай мэс засалч, Их Хурлын гишүүн хүн шүү. Яг би, түрүүн ноцтой юм хэлсэн шүү та гаалийн шинжээч. Янжуур тамхи бол байгалийн гаралтай навчин бүтээгдэхүүн учраас бараг хор багатай. Нөгөөдөх нь химийн гаралтай учраас бүүр их илүү хортой гэж хэлсэн. Тэгээд би та хоёрын уучлаарай алинд нь ч итгэхгүй байна.

Гэхдээ бид нар өнөөдөр хор багатай нь татвар багатай байх ёстой. Бид нар Төсвийн байнгын хорооны гишүүд шүү дээ. Мэргэжлийн Байнгын хорооны гишүүд шүү дээ. Тийм учраас наадмын өмнө Тамхины хуулийг баталж супер сенсаци дэгдээ нөхөд өө гэдэг мэдэг юманд битгий яагаарай. Би бол Номинчимэг гишүүнд хэлэхэд таныг үзэл энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Дахиад жоохон нухвал яадаг юм? Хэдүүлээ намрын чуулган руу явуулбал яадаг юм бэ? Энэ үзэл бодлын зөрүүтэй гишүүдээ хүндэтгээд, дахиад тэрийг нь сонсоод, шинжээчдийнхээ дүнг нэгтгээд. Одоо Чинбүрэн гишүүнийг үг хэлүүлбэл хорт хавдар гэж битгий хэлүүлээрэй гэж гуйж байгаа шүү. Таны нэр алдрыг бас ашиглаад байна шүү. Гараа өргөчихлөө.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Мөнхбаясгалан гишүүнээ би л шууд хорт хавдар үүсгэдэг энээ тэрээ гэсэн зүйл ерөөсөө яриагүй. Энд нэг зүйлийг хэдүүлээ их тодорхой болгоё. Мэргэжлийн Байнгын хороо, Төсвийн байнгын хорооноос та бүгдээс миний яг ахалж байгаа энэ ажлын хэсгээс юу хүсэж байгаа вэ гэхлээр татварын бодлого дээр мэргэжлийн Байнгын хороо ямар бодлого бидэнд санал болгож байгаа гэдгийг л бид хүлээгээд байгаа юм.

Тийм ч учраас бүүр ажлын хэсгээ хуралдуулахгүй одоо хүртэл та бүгдийн шийдвэрийг хүлээгээд ингээд сууж байгаа юм. Тэгэхлээр энэ бол байж байгаарай тэгээд хоёр дахь тийм тэгэхлээр нэмэлт шийдвэрүүд, саналууд ирээгүй юм байна шүү дээ. Тийм санал ирээгүй учраас ингэж байна.

Хоёр дахь зүйл бол ер нь байна шүү дээ энэ яг шинжлэх ухаан талаасаа аваад үзэх юм бол ургамлын гаралтай байх нь цэвэр гэсэн санаа ерөөсөө байхгүй шүү. Яагаад вэ гэхлээр жишээлбэл ургамлын бодисыг эм үйлдвэрлэхэд ургамлыг заавал цэвэршүүлж байж дотор нь агуулагдаж байгаа хүнд металлууд, бохир бодисуудыг нь ялгаж байж үйлдвэрлэдэг юм шүү дээ. Тэгээд синтетик эмүүд чинь бас илүү сайн чанартай байдаг чинь хольц багатай байдаг байхгүй юу. Энэ нэг асуудал. Зүгээр Гаалийн ерөнхий газрын лаборатори дээр очоод би Цэрэнчимэд гуай бид хэд ярьсан зүйл бол хэт их өндөр никотин агуулсан савлалт өөрөө аюултай шүү дээ.

Жишээлбэл, Баярбаатар гишүүн бид хоёр ярьж байсан. Энэ сорох рефлекс бол хүнийг тайвшруулдаг рефлекс. Тийм учраас энэ Номинчимэг гишүүний өргөн барьсан хууль дотор савлагаа нь бага байх ёстой гэдэг заалтууд байгаа. Тэгэхгүй бол хүн өөрийгөө хянахгүйгээр 13 мянган удаа сорох ийм рире хийх ийм электрон тавилгыг бид дэмжээд байж болохгүй шүү дээ. Тэгэхлээр энэ савлагаа, дотор нь агуулах агууламжийн талаар бид ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхгүй бол хүн чинь ингээд л нөгөө тайвшрах рефлексээрээ сороод л байдаг сороод л байдаг тэгээд нөгөө 13 мянган удаа сорох эмийг чинь өдөртөө ...бал яах юм. Тэр чинь никотины агуулга хэт их авна шүү дээ. Яагаад Монгол Улсын стандартад 1 ширхэг тамхи нь никотин 1.3-аас их байж болохгүй гэдэг чинь тэр хэмжээнээс концентрац нь их байх юм бол гаж нөлөө өгдөг байхгүй юу.

Жишээлбэл, судас хэт их агшаана, дотор муухай оргино, бөөлжис хүрнэ, хоолой хорсоно, ханиалгана. Тийм учраас Монгол Улсын стандартад янжуур тамхи нь 1 ширхэг тамхи дотор 1.3-аас ихгүй байх ёстой гээд заачихсан байгаад байгаа шүү дээ. Энэ чинь стандарт байхгүй юу. Тийм учраас бид хуулиараа

дамжуулаад аль болохоор 1 савлалт дотор 20, 30мм-ээр байхыг зөвшөөрөхгүй гэдгийг яриад байгаа шүү.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Тэгвэл маний үг хэрэггүй юм биш үү? Шууд ажлаа үргэлжлүүлээд явцгаая гэж байна шүү дээ. Яах билээ? Тэгвэл үг хэрэггүй юм байна шүү дээ. Харин тийм. Үгүй харин бид нар тийм л юм яриад байгаа юм. Тэгээд аягүй буруу ойлголт өгөөд, аягүй буруу яриад байна л даа та. Таны нэрийг бариад мэдэгдэл хийснийг чинь ярьсан юм.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Би асуулт асуухгүй саналаа хэлчихье. Никотин агуулсан электрон тамхи өнөөдөр онцгой албан татваргүй л явж байгаа шүү дээ. Тэгэхээр ажлын хэсэг бол мэдээж энэ Байнгын хороон дээр сонсож байж ажлын хэсэг л явах ёстой байх л даа уучлаарай Чинбүрэн гишүүн, ажлын хэсгийн даргаа саналаа хэлье. Мэдээж таны яриад байгаа энэ Байнгын хорооны, мэргэжлийн Байнгын хороогоор татварын асуудлыг ярихын тулд хор хохирлын асуудал эрүүл мэндэд нөлөөлөөд байгаа хор хохирлын чинь асуудлыг ярьж байж л татвар нь ялгаатай байх юм уу адилхан байх юм уу гэдгийг ярих байх л даа. Уучлаарай, эрхэм гишүүд ээ би үгээ хэлчихье.

Тэгэхээр энэ ялгаатай байх уу үгүй юү гэдгээс чинь хамаарч татвар чинь ялгаатай байх юм уу гэдэг юм яригдах гээд байгаа учраас ажлын хэсэг биднийг хүлээх биш харин бид ажлын хэсгээс бодитой дүгнэлтээ л авмаар байх юм яг үнэнийг хэлэхэд. Яагаад гэхээр өнөөдөр орж ирсэн 2 ажлын хэсэг дотор орж ирээд байгаа Чинбүрэн даргаа та ажлын хэсгийн дарга алга байна. Ажлын хэсэгт орж ирээд байгаа Эрүүл мэндийн яам, Гаалийн төв лабораторийн мэргэжлийн хүмүүсийн санал, дүгнэлтүүд, хэлж байгаа тайлбар зөрөөд байна. Би энэ хоёр, нэг нь хүний их эмч, Эрүүл мэндийн яамны шинжээч байна. Нөгөөх нь Гаалийн ерөнхий газрын лабораторийн дарга, эрхлэгч нь байна. Би энэ хоёрын, хүний үгэнд эргэлзэхгүй байна. Аль аль нь өөр өөрийн мэргэжлийн үүднээс хэлж байгаа байх. Би үгүйсгэхгүй байна.

Гэхдээ нэг зүйлийг хэлэхэд яг энэ асуудлыг ажлын хэсэг дээрээ ярьж байж орж ирэх ёстой байсан юм биш үү? Өнөөдөр ажлын хэсэгт орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн би энд байгаа гэж ойлгож байгаа. Ганзориг шинжээчийн хувьд ч тэр, Цэрэнчимэд лабораторийн даргын хувьд ч тэр. Тэгээд би эндээс нэг зүйлийг хэлэх гэж байгаа нь ямар асуудлыг ярих гэж байна гэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.16, 21.25 дахь 2 заалт бий. Чуулганы хуралдаанд оролцож байгаа албан хаагчид үнэн, зөв мэдээллээр хангах ёстой. 9.16-гийн дагуу 2 мэргэжлийн хүн хэлсэн үгийнхээ түрүүн хэлсэн тайлбарууд дээрээ, миний асуултад хариулсан судалгааныхаа дүгнэлт тайлбарууд дээр 2 эсрэг тэсрэг ярьсан зүйлээ албан ёсоор бичгээр гаргаж өг өө. Байнгын хорооны дарга үүнийг бичгээр авч өг өө. Бид аль нэг талд мэргэжлийн хүний үгэнд, судалгаанд итгэх ёстой. Тэрийг барих ёстой. Тэгж байж шийдвэр гаргах ёстой учраас гишүүд өөрсдөө дур мэдээд шийдвэр гаргаж байгаа юм байхгүй. Судалгаа, дүгнэлтийг харж байж шийдвэр гаргах ёстой. Тийм учраас 2 мэргэжлийн хүний хэлсэн, хариулсан хариултын арын судалгаануудыг, эх үүсвэрүүдийг нь албан ёсоор авч өг өө Байнгын хороо. Энэ дээр би зүгээр ингээд хариулт аваад энэ Байнгын хорооны минутаараа үлдээхгүй судална. Хэн нь үнэн яриад, хэн нь

зөрүүтэй яриад байгаа юм? Ойлголтын зөрөө байгаа юм уу? Энийг гаргаж харъя. Ажлын хэсэг ч гэсэн энэ дээрээ энэ асуудлаа нэг талд нь яг энэ ажлын хэсэгт орж ирж байгаа бүрэлдэхүүн өөр юм яриад суугаад байгаад эцэслэж орж ир.../минут дуусав./

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн. Тэр судалгаануудыг бичгээр өгөөрэй. Сайнзориг гишүүн асуулт.

П.Сайнзориг: Би үг хэлье. энэ Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бол хэлэлцээд батлах нь бол чухал байгаа. Энэний дагаж байгаа Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хуулийн төслүүдийг өнөөдөр ярьж байгаа байхгүй юу. Өнөөдөр энд мянга яриад ч ажлын хэсэг дээр санал өгөх эрхгүй байна. Бид хэд бас энэ дэгийн хуулиудаа сайн бодолцооч гишүүд гэж байгаа юм. Яг үнэндээ хэлэхэд зарчмын зөрүүтэй саналыг 2 хоногийн өмнө гаргачихсан байх ёстой. Энд яриад л байдаг яриад л байдаг Чинбүрэн дарга дээр бид нарын энэ ажиллаж байгаа ажлын хэсэг дээр юу ч очихгүй ээ. Хэлэлцлээ гэдэг л юм очно.

Тэгээд сүүлдээ ингээд мухардалд орж байна. Би зүгээр нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Би бас Хууль зүйн байнгын хороо болон бусад Байнгын хороон дээр ороод ч хэлээд байгаа. Одоо энэ Засгийн газрын хуралдаан дээр хүртэл мэргэжилтнүүд ордоггүй байхгүй юу. Газрын дарга, Төрийн нарийн, сайдтайгаа орж асуудлаа хамгаалаад гардаг. Тэр хүрэлцэнэ үү хүрэлцэхгүй юу би мэдэхгүй байна. Тэгэхдээ энд ингээд Гаалийн ерөнхий газрын дарга, эсвэл Эрүүл мэндийн яамны яг хариуцлагатай хүн суумаар байна. Ингэж байж энэ чинь итгэл үнэмшлээ төр шийдвэрээ гаргана. Энэ Улсын Их Хурал чинь бүр арай ингээд бүр доошоо ороод байна шүү дээ. Ийм байж болох юм уу?

Тэгээд ингээд баахан мэргэжилтэн нь гээд газрын дарга нар нь араас нь нуугдчихсан. Энд Батшугар орж ирээд суух ёстой шүү дээ. Тэгээд мэргэжлийнхээ хүмүүсээсээ ар талаасаа зөвлөгөөгөө аваад яг Засгийн газрын Эрүүл мэндийн сайдын хувьд ингэмээр байна. Татварын юм уу, Гаалийн газрын дарга нь яг ингэмээр байна. Засгийн 2, 3-н институц нь бас зөрөөд байвал энэ саналаа асуудал эрхэлсэн сайдынхаа хүрээн дээр ингээд уулзалт зөвшилцлүүдээ хийгээд явдаг энэ уламжлалт төрийн би арга барил чинь хааччихсан юм? Тэгээд гишүүд нь ингээд тал талд ингээд шийдэлгүй хэрэлдээд, цаг үрээд. Одоо энэ дээр өнөөдөр хэлэлцүүлэг яваад юу ч шийдэхгүй. Энэ дээр юу ч гарахгүй. Тэгээд ийм байна.

Ер нь энэ санал, дүгнэлтийг өгөхдөө Байнгын хороо эсвэл ийм асуудал дээр санал, дүгнэлт авъя, дагасан хуулиуд дээр ирж байна гэх юм бол бид нар 2-3 гишүүнийг маш богино хугацаатай ажиллуулаад Байнгын хороондоо мэдээлэл өгдөг ийм жижиг мини ажлын хэсэг гаргаад явдаг энэ зохион байгуулалтад орохгүй бол гэнэт орж ирээд л гэнэт юм ярьдаг, зарчмын зөрүүтэй санал гаргаж болдоггүй, ярилцаж болдоггүй.

Одоо яг үнэндээ хэлэхэд Чинбүрэн даргаар ахлуулсан ажлын хэсэг хэцүү. Татварын бодлого дээр бид нар мэргэжлийн Байнгын хорооны санал, дүгнэлт дээр юу ч ирээгүй учраас яваад орно. Энэ байдлаараа энэ Тамхины хяналтын хууль чинь гацах юм байна. Бөөн хэрүүл болох юм байна.

Тийм учраас Батжаргал дарга маань өөдөөс хараад сууж байна. Уг нь парламентын бас 3 хууль хэлэлцэгдээд явж байгаа. Энэ дээр ингээд Байнгын

хорооны уялдааг хангах дээрээ бас энэ санал, дүгнэлт гаргах хугацаа, эсвэл тэр өдрөө зарчмын зөрүүтэй гаргах, дагаж байгаа хууль дээр эсвэл мэргэжлийн Байнгын хороонд гаргах эрхийг нь нээж өгмөөр байна. 2 хоног гээд ингээд ийм. Тэгээд ерөөсөө энэ.../минут дуусав./

Н.Наранбаатар: Үг хэллээ. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Тийм сая Үүрийнтуяа гишүүний ярьж байгаа бол туйлын зөв. Бас Сайнзориг бол зөв коммент хэлж байна. Би тэгээд уг нь бол ажлын хэсгийн, ажлын дэд хэсэг гэх юм уу хэсэг гэх юм уу энэ хууль санаачлагчдын Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн хүн бол эрүүл мэндийн талаас нь хор хөнөөлийн асуудлыг ярьдаг. Гаалийн тэр лаборатори эрхлэгч бол гааль ногдуулалтын, татвар ногдуулалтын асуудлаар ингээд байр сууриа илэрхийлдэг, судалгаагаа ярьдаг баймаар байгаа юм.

Тэгсэн сая лаборатори эрхлэгч маань Чинбүрэн гишүүний нэрийг ашиглаад хорт хавдрын асуудал яриад гишүүдийг ингээд төөрөгдөлд оруулах санаатай юм уу санаагүй юм уу ийм үйлдэл гаргалаа. Би энэ байнгын хороо эхлэхэд Байнгын хорооны даргад бас, Байнгын хорооны даргаа би танд хэлж байгаа юм. Наранбаатар дарга хууль сануулаарай гэж би хэлсэн тээ? Хууль сануулсан. Энэ хүн дээрээ хуулийн арга хэмжээг нь аваад дараагийн Байнгын хорооны хурал дээр ямар арга хэмжээ авсан талаарх асуудлыг эргээд гишүүдэд мэдэгдээрэй.

Мөн Сайнзориг гишүүний саяын ярьсан асуудалтай холбоотойгоор. Эрүүл мэндэд хортой асуудлаар энэ чинь ерөөсөө бид нар нэгдсэн ойлголттой байх ёстой байхгүй юу. Гэтэл Гаалийн лабораторийн эрхлэгч гаалийн тэр орж байгаа тэр бодисын талаар байдаг юм уу мэдээлэл өгөх ёстой болохоос биш ингээд аль тамхи нь илүү ингээд хорт хавдар тусгадаг гэсэн асуудлыг өнөөдөр сая ингээд илт худлаа ярилаа л даа. Би худлаа юм уу, үнэн юм уу мэдэхгүй байна. Эрүүл мэндийн яам бол тийм биш гэж. Тэгээд эрүүл мэндтэй холбоотой асуудлаар бол уг нь бид нар Эрүүл мэндийн яамнаасаа мэдээллээ авдаг. Гаалийн татвар ногдуулалттай холбоотой Гаалийн тэр лабораторийн эрхлэгч юм уу гаалийн татварынхан нь ингэж мэдээлэл өгдөг. Тэгээд тэр тусмаа гишүүдэд хариулт өгөх хэмжээний албан тушаалтан энэ дээр орж ирээд сууж байх ёстой байсан. Одоо бид нарын цагийг үрээд тэгээд гишүүдийг хооронд нь маргалдуулаад тэгээд ингээд бүүр энэ хуулиа гацаах тал руу нь оруулж байгаа байхгүй юу. Тийм учраас яг энэ хүн дээр арга хэмжээ авсан талаар эргээгээд мэдэгдэхийг хүсэж байна Байнгын хороон даргаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгэхээр би бол ялангуяа Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал, дүгнэлт авдаг иймэрхүү нэлээн мэргэжлийн зүйлүүд дээр энэ арай өөр горим баймаар байна. Төсвийн байнгын хороо урьдчилаад тодорхой асуудлуудаар асуудаг. Тэгээд яг үнэндээ хэлэхэд энэ дарга нарт хэлчихье. Даргын зөвлөл гээд юм хуралддаг юм шиг байна та хэд.

Ерөөсөө мэдээлэл өгөхгүй. 3 дахь өдрөө хуралдчихдаг юм уу, яадаг юм, эсвэл 5 дахь өдрөө хуралддаг юм уу. Ирэх долоо хоногт юу орох гэж байгааг мэдэхгүй байж байж бид хэд яаж саналаа бэлдэх юм бэ? Өнөөдөр 3 дахь өдөр. 2 дахь өдөр хуралдаж байгаа Байнгын хороо бараг 5 дахийг нь та нарын үдээс хойш гаргаж байгаа хуваарийн чинь дагуу санал бэлдэж амжихгүй амжихгүй байна. Тэгээд ийм сонин сонин логикгүй жүжгүүдээс чинь болоод энэ парламентын үйл ажиллагаа өөрөө хошин шог шиг харагдаж байна шүү дээ ард түмэнд.

Тэгээд үнэхээр энэ асуудал байгаад байгаа бол Ганхуяг гишүүн, Бадамаа гишүүн хэн байдаг юм саналаа, зарчмын зөрүүтэй саналаа гаргаад өгөх ёстой байхгүй юу. Дэгээрээ боломжгүй. Тэгээд энэ парламентын юм чинь ерөөсөө их сонин болсон. Энэ хүний нөөцийн бодлогоосоо эхлээд энэ дээр чинь томъёолол бичиж чаддаг ажилтнууд маш ховор болсон юм байна. Зохион байгуулалтууд нь ерөөсөө нууц. Тэгээд хэдэн дарга нар комментоороо саналаа өгөөд хуваариа баталчихдаг тэгээд ингээд гишүүдээ хэрэлдүүлдэг. Үгүй энэ өөрсдөө зохион байгуулалтад оруул л даа. Манайхаар ийм чухал асуудлыг нь дагаж байгаа хуулийн Онцгой албан татварын хууль орж ирэх гэж байна. Энэ дээр Хассуурийн Ганхуяг гишүүн, Бадмаа гишүүн, Үүрийнтуяа гишүүн байдаг юм уу, Мөнхбаясгалан гишүүн 3 гишүүн ингээд санал, дүгнэлт гаргаад энэ бол албан ёсны санал, дүгнэлт биш ажлын хэсгийн. Судлаад бас энэ асуудлаа үгүй мэдэхгүй ер энэ явахгүй байна.

Тэгээд бүтээмж нэхээд байгаа мөртөө бид нар өөрсдөө ингээд бүтээмжтэй ажиллах ерөөсөө зохион байгуулалт хийж чадахгүй байна шүү дээ дарга нар аа. Би Төсвийн байнгын хорооны даргад бас хэлчихье. Тэгэхэд чинь хүрээ хязгаараа халилаа гээд байдаг. Ийм утгагүй юм зохион байгуулаад, хэлэлцүүлээд бүр тал өдөр аваад хаячхаж байгаа байхгүй юу. Таны Байнгын хороо хамгийн чухал шүү дээ Наранбаатар дарга аа. Үгүй харин тийм. Тэгээд зөв зохион байгуулаад ажлаа хий л дээ. Энэ чинь ажил хийж байгаа ямар ч юм алга байна шүү дээ. Одоо ингээд бүхэл бүтэн өглөөнөөс хойш би хэлэх үгээ хэлж байна. Та сонсоод дараа нь комментоо хэлж болно шүү дээ. Энэ ирц яалаа одоо яг яах гэж байгаа юм энэ чинь санал, дүгнэлт гаргахгүй, зарчмын зөрүүтэй санал гаргах ямар ч бололцоогүй болчихлоо. Тэгээд ийм утгагүй байдлаар энэ чухал чухал хуулиудын асуудал дээрээ гацаа тээг үүсгэдэг.

Дээрээс нь энэ байнгын хорооны хурал зөвлөгөөнд дуудаж байгаа ажлын хэсгүүдээ дарга нарыг дууд. Би дарга нартай харьцах гээд байгаадаа биш. Эцсийн хариуцлагыг нь хүлээх хүмүүсээ дууд. Зүв зүгээр сууж байгаа гаалийн лабораторийн хүн хариуцлагад орохоор болчихлоо. Тэр Гаалийн ерөнхий газрын дарга нь өөрөө ирээд хариултдаа ..., Эрүүл мэндийн яамны хэн нь байдаг юм өөрөө ирээд яана энэ битгий мэргэжилтнүүдийг ингэж авчирч улалзуулаад тэгээд ингээд элдэв янзын хариуцлага яагаад бичгээр өг, та нарын араас явж хариуцлагыг нь тооцуулна боль л доо энийгээ. Ийм арчаагүй байдлаар төрийн ажлыг явж өөрсдөө ийм зүв зүгээр явж.../минут дуусав./

Н.Наранбаатар: 5 дахь өдрийн Даргын дэргэдэх зөвлөлөөр энэ чинь батлагдчихсан. Тэгээд одоо байгаа Дэгийн хуулиар, 5 дахь өдөр шийдвэр нь гарсан шүү дээ. Тэгээд зарчмын зөрүүтэй санал өгөх хугацаа одоогийн дэгээрээ л явна шүү дээ. Тэгээд бид нар одоогийн байгаа хүчин төгөлдөр хуулиараа л явна.

Хуулийн төслийн хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан хугацаанд, 39.14-д заасан хугацаанд урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Одоо энэ хуралд нээрээ бүлгийн дарга ч байгаа юм байна. Манай Байнгын хорооны дарга ч байна. Энэ дэгийн хууль дээрээ энэ өөрчлөлт оруулахгүй бол бид нар чинь нөгөө ингэж хэлэлцээд энэ ажлын хэсгээс нь мэдээлэл авч байж санал гаргахгүй болохоор чинь урьдчилаад юуг нь ч мэдэхгүйгээр аль нь илүү хор хөнөөлтэйг нь мэдэхгүйгээр яаж санал гаргах юм бэ? Тэгээд энэ ерөөсөө ингээд ерөөсөө нөгөө логик алга байна. Энэ чинь ингээд асууж байж, ингээд ярилцаж байж, мэдээлэл авч байж ингээд бид нар чинь санал гаргадаг юм байгаа биз дээ. Ингээд ямар ч нөгөө юу байхгүйгээр шууд хуулийнх нь төсөл дээр нь хараад л санал өгөөд байна гэдэг чинь юу гэсэн үг юм ямар ч мэдээлэлгүйгээр, хэлэлцэхгүйгээр. Энэ дээрээ нээрээ жоохон өөрчлөлт оруулахгүй бол болохгүй юм байна.

Тэгээд яг энэ татвартай холбоотой хэсэгтэй нь одоо ингээд жоохон мэдээлэлтэй болчихсон бид нар уг нь татвар дээрээ магадгүй тусдаа ажлын хэсэг байгуулаад, тэгээд ажлын хэсгийн үндсэн ажлын хэсэг рүү нь санал болгож өгдөг байхгүй бол үгүй тэгээд яах юм санал, дүгнэлт ч байхгүй, зарчмын зөрүүтэй санал ч байхгүй ингээд явдаг. Тэгээд гол асуудал нь бид нар энэ нийгмийн хамгийн хор хөнөөлтэй байгаа асуудлаа цэгцлэх ёстой байтал энэ чинь ингээд гацаанд оруулахаар хэмжээний юм болчихоод байна шүү дээ.

Н.Наранбаатар: Энэ гишүүд ээ нэг юм анхааръя. Дөнгөж гэнэт гарч ирээд манай Байнгын хороогоор орж байгаа юм биш шүү дээ. Өмнө нь энийг чинь d.parliament-аар тавиад өвөлжин, зунжин, хаваржин, намаржин яриад дахиад Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороогоор хэлэлцэх эсэх нь яригдаад тэн дээр танин мэдэхүйн асуулт бүх юмнуудаа явчихсан байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр орж ирээд гэнэт сэрж байгаа юм шиг ингээд байж болохгүй шүү.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

2 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд хугацаанд урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан бичгээр санал ирүүлээгүй байна.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Юугаа дарна.

Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ олон улсын байгууллагууд гэдэг юм уу бүс нутгийн байгууллагуудтай харилцаа хамтын ажиллагаа, тэр тусмаа эдийн засаг, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой тусгай гэрээ хэлцлүүд байгуулагдаж байна. Евроазийн улс орнуудтай чөлөөт худалдааны түр гэрээ байгуулах асуудал яригдаад манайх Их Хурлаараа дэмжчихсэн. Одоо тэнд ярих юм байхгүй гэсэн үг. Тэн дотор тэр 367 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний нь энэ байгаа. Тэгээд тэр тэг байхаар үндсэндээ гэрээнд тохирсон гэсэн үг.

Тэгэхээр буцаагаад бид энийг онцгой албан татвар руугаа шингээж энэ үндэстэн олны өмнө хүлээчихсэн үүргээрээ гаалийн татваргүй болж байна шүү дээ тэр бүс нутагтаа. Тэгэхээр зэрэг буцаагаад энд орж ирж байгаа юмаа өөр хууль

дээрээ зохицуулалтаа хийж шингээх ёстой гэж үзээд. Сая ярьсан мэдээллээр бол Засгийн газар өнөөдрийнхөө хуралдаанаар энэ тамхины гаалийн татвар тэр олон улсын гэрээгээр тэглэгдэж байгаатай холбогдоод онцгой албан татвар руугаа татлаа гэдэг ийм юм ярьсан.

Тэгэхээр харин бид хэд энд тогтоол батлах хэрэг байна уу гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу. Гаалийн татвар дээр зохицуулалт хийх биш онцгой руугаа асуудал яригдах юм байна гэдэг юм ойлгогдож байна л гэж би бол тэгж ойлгоод байна шүү дээ. Бидэнд байгаа эрх нь тэр болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр тодорхой бүс нутагтай тодорхой төрлийн бүтээгдэхүүн дээр нэгэнт татварын хөнгөлөлт эдлүүлээд байгаа юм бол бусад бүс нутгуудаас ирж байгаа ижил төрлийн бүтээгдэхүүн дээр ялгаатай байдал байх юм уу байхгүй юм уу гэдэг л асуудал шүү дээ эндээс чинь үүдээд. Тэгэхээр ер нь бол тамхины төрлийн бүтээгдэхүүн дээр гаалийн татваргүй, онцгой дээрээ өндөр ачааллаа аваад бүс нутгуудын жигд харилцааг хангахтай холбоотой асуудал болж хувирах юм байна л гэж би бол тэгж л ойлголоо шүү дээ. Мөн үү биш үү?

Н.Наранбаатар: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Би ч гэсэн бас энэ дээр нөгөө асуулт асуух гэж байсан. Гэхдээ Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ ийм юм байна лээ Евроазийн эрээн хэлтсээр чинь зөвхөн янжуур тамхи, дүнсэн тамхи дээр гаалийн албан татварыг нь тэглээд хаячихсан байхгүй юу. Тэгэхээр манай энэ орж ирж байгаа тогтоолоор чинь бид нар шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнээ тамхи гэж үзээд одоо бас гаалийн албан татвар авдаг болох гэж байгаа юм.

Тэгэхэд Засгийн газраар өнөөдрийн хуралдаанаар орсон гэж би бол мэдээлэл авсан. Нэн яаралтай оруулна гээд. Тэгэхээр тэн дээр бол харах нь зөвхөн тэр янжуур тамхи, дүнсэн тамхиныхаа гаалийн албан татварыг онцгой руугаа шилжүүлсэн юм хийсэн байна лээ. Бусад юмыг нь ерөөсөө хөндөөгүй. Бусад юм нь угаасаа Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа энэ хууль дээр байгаа учраас нэгдээд нийлүүлээд явъя л гэдэг асуудал. Энэ бол яах вэ нөгөө зарчмын хувьд бид нар Улсын Их Хурлаас 04 сарын 15 гэхэд Засгийн газар энэ асуудлаа шийдэж заавал орж ир гэдэг үүрэг даалгавар өгсөн.

Гэхдээ ингээд 2 сарын дараа хоцорч орж ирж байгаа юм. Тэгэхээр алдаа хийсэн бол энийгээ Засгийн газар нь өөрөө залруулдаг байх ийм л зарчмын дагуу орж ирж байгаа. Тэгэхээр тэр орж ирэх орж ирэх, үгүйгээс хамаарахгүйгээр манай энд бол баг бүгдээрээ бас хөндөгдсөн байгаа.

Тэгэхээр энийгээ бид нар бас ингээд засаад явчих боломжтой. Тэр нөгөө янжуур байна уу юу байна уу татварыг нь байхгүй болж байгааг нь заавал онцгой дээр нь нэмээд явах тэр бичилт техникийг нь энэ дээрээ хийгээд явсан нь илүү бас ойлгомжтой болно. Засгийн газраас мэдээж тэр нь өргөн баригдах нь ойлгомжтой болж байгаа. Энийгээ засах нь ойлгомжтой болж байгаа учраас бид бас тэр чиглэлээр нь нийцүүлж цаг хугацааны хувьд ажиллах нь их чухал байгаа гэж харж байгаа.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Онцгой албан татварыг бол бид хэд түрүүн нэгж бүтээгдэхүүн дээр, нэгж бүтээгдэхүүн дээр тогтмол мөнгөн дүнгээр авчихсан. 10 мянга ч гэдэг юм уу, 5 мянга. Энэ бол болж байгаа юм.

Гэтэл тодорхой хэмжээний нэмүү өртөг шингээд үнэ цэн нь өсчихсөн бүтээгдэхүүнүүд дээр одоо энэ гаалийн албан татварыг бол бид хувиар тооцох гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хэсэг дээрээ маш өндөр ачаалал ирнэ. Ойлгож байна уу? 10 мянган төгрөгийн үнэтэй бүтээгдэхүүн дээр 30 хувиар тооцохоор хэд гардаг юм? 3 мянган төгрөг гарна тийм үү? Тэгвэл 50 мянган төгрөгийн үнэтэй бүтээгдэхүүн дээр 30 хувиар тооцохоор хэд гардаг юм? 15 мянган төгрөг тооцно, ногдоно. Тийм учраас.../минут дуусав./

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн асуулт асууя. Хариулт байгаа юм байна. Индрийн мик. Индрийн микийг нь өгөөрэй.

Ж.Төрболд: Сайн байцгаана уу? Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Төрболд. Гаалийн албан татвар болон онцгой албан татвар чинь гаалиар орж ирдэг CIF үнээсээ тооцогддог учраас энэ дээр хувийг шилжүүлж байгаа л асуудал болохоор одоо НӨАТ шиг бодогдохгүй гэсэн үг. Тэгэхээр зөвхөн CIF үнээс бодогдож байгаа нь нөгөө тал руугаа ороод яаж байгаа. Тэн дээр болохоороо зөвхөн 3 төрлийн тамхины асуудал яригдаж байгаа.

Яагаад дүнсэн, задгай тамхинд чинь хамрын тамхи орчхож байгаа учраас хамрын хамрын тамхи дээр болохоор онцгой албан татвар татвараас чөлөөлөгддөг. Тэгсэн хэр нь задгай тамхитай ордог учраас энийг зүгээр тусад нь авч үзэж 3 төрлийнх байгаа юм шиг харагдаж байгаа юм. Ер нь бол янжуур тамхи болон тэгээд задгай тамхи. Задгай тамхи нь болохоор усан хоолойгоор татдаг шиша, тэгээд янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхи, хамрын тамхи гэсэн.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ чинь ингээд жоохон ер нь асуудалтай л болох гээд байна л даа. Энэ чинь Казахстанд үйлдвэрлэсэн янжуур ингээд зах зээл дээр хамгийн хямдхан болоод энэ 10 мянган төгрөг дотор байх юм байна. Тэгээд бусад нь ингээд бусад оронд үүссэн янжуур нь ч тэр, янжуур нь 17, 8 болоод л цахилгаан тамхи нь 170, 80 мянга болох юм байна л даа энэ чинь. Тэр нь дахиад гаалийн дотор нэмэгдэж байгаа юм байна шүү дээ. Саяын яриад байсан дүнгүүд дээр гааль болон гаалийн энэ чинь 30 хувь болгож байгаа юм байна шүү дээ 5 хувиа. Тэгээд энэ чинь Евроазийн хэлэлцээр рүү ингээд буцаад бид нар яагаад ч юм энэ Евроази руу тамхин бүтээгдэхүүн оруулчихсан юм. Би тэрийг чинь гайхгаад олохгүй юм.

Тэгээд энэнээс чинь болоод яах юм. Тэгээд улс даяараа ингээд хямдхан Казакстан тамхи татдаг. Тэгээд бусад нь ингээд жигтэйхэн үнэтэй юмнууд татдаг. Тэгээд Казахстан тамхи нь хор хөнөөл багатай. Бусад нь их л хор хөнөөлтэй гэдэг л ийм л логик гарч ирдэг юм шүү дээ. Яг эндээс харах юм бол. Энэ Засгийн газраас өргөн барих гэж байгаа хуулийн төсөлтэйгөө энэ жоохон бараг яг энэ татварын хэсэг нь бусад энэ ху юмнуудаа ингээд явуулчихаад яг энэ татварын хэсэг нь тэрэнтэйгээ хамтатгаад явахгүй бол энэ чинь ерөөсөө их л замбараагүй л юм болох нь дээ.

Уг нь бол бид нар чинь энийгээ хяналтад оруулаад зөв болгомоор байдаг. Ингээд ялт ч үгүй ингээд олон талаас ингээд олон салаа хэлэлцээр ч орж ирээд л хуулиуд ч орж ирээд ингээд их л замбараагүй л юм болох нь. Сангийн яам яагаад энэ дээр ингээд та нар өдий хүртэл энэ тэр арга хэмжээ аваагүй, энэ хуулиудаа та нар нэгтгээд өргөн бариагүй юм бэ? Тэгээд хэдэн өргөн барьсан гишүүд нь хардагдаж сэрдэгдээд л. Ингээд хэдэн татварууд нь ингээд хоорондоо тэнгэр, газар шиг болох нь байна шүү дээ. Казакстан чинь янжуур тамхи хийдэг, дүнсэн тамхи хийдэг. Тэд нар нь зах зээл дээр хамгийн хямдхан тамхи болох нь байна. Тэгээд хэрвээ хүүхдүүд татахгүй гэсэн баталгаа нь яг юу юм? Эрүүл мэндийн талаасаа янжуур дүнсэн тамхи чинь илүү л хор хөнөөлтэй баймаар юм. Сая Эрүүл мэндийн яамны тэр мэргэжилтний хэлснээр бол байхаар байна гэж ярилаа. Тэр янжуур тамхи татахаар яах юм хорт хавдар тусахгүй юм уу? Зүрх судасны өвчин тусахгүй юм уу? Энэ чинь ингээд явсаар байгаад энэ Казастаны тамхины үйлдвэрүүдийн лоббины л юу болж харагдаад эхэллээ шүү дээ. Яг энэ байдлаар явах юм бол.

Н.Наранбаатар: Асуулт уу? Тэнд Чимидсүрэн байна л даа. Хариулъя. Индрийн микрофон.

Ч.Чимидсүрэн: Евроазийн түр хэлэлцээртэй холбоотой бол холбоотой бас Улсын Их Хурлын 115 дугаар тогтоол гарсан. Тэгээд түүний хэрэгжилтийг бас энэ Улсын Их Хуралд бас санаачилсан хуулийн хэсэгтэй нэгтгээд явах бололцоотой юу гэдэг талаас бас тодорхой хэмжээнд бас цаг хугацааны хувьд бол алдсан зүйл бий. Тэгээд энэ асуудлаа өнөөдрийн Засгийн газрын хуралдаанаар гаалийн татваруудаа тэглээд онцгой албан татвараар жигдлээд энэ улс орнуудад бол жигд хандах энэ асуудлаа шийдвэрлэхээр бол өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар өргөн бариад Улсын Их Хуралд яаралтай горимоор хэлэлцүүлэхээр бол өргөн барих гэж байна.

Н.Наранбаатар: Тодруулъя. Номинчимэг гишүүн хариулъя. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ их их чухал асуудал. Бид яг энэ хуулийг ингээд хийгээд явж байхад Евроазийн гэрээ хэлэлцээр батлагдчихсан. Орилоод орилоод энэ чинь болохгүй шүү дээ хүн амаа хавдарт нэрвэгдүүлэх нь үү гэдэг юм хэлсээр байгаад л ийм болсон. Тэгээд аргаа ядаад Улсын Их Хурлын тогтоол гаргуулаад. Өө онцгойгоороо нөхөөд олчихно олчихно гээд тухайн үеийнх нь салбарын сайд нар хэлэлцээр ахалж байсан хүмүүс нь хэлж байсан. Та нарт ёстой улс төрийн үлгэр болов гээд би анхааруулж л байсан. Тэгээд үнэхээр үлгэр болохоо шахлаа. 04 сарын 15 гэхэд орж ирэх нь үү гээд л би чинь Засгийн газраас асуулга ч тавилаа, шаардлаа, бүлэг дээрээ ч ярилаа. Тэгээд харин Учрал Ерөнхий сайд бас манлайлж энэ дээр анхаарч бас ингээд оруулж ирж байгаад бол би баяртай байгаа. Тэгээд энийг нь бол хэлэлцээд энэ хямдхан янжуур тамхи орж ирж Монгол Улсыг хавдарт нэрвэгдүүлэхгүй, хүүхдүүдийг эрүүл мэндийг нь хордуулахгүй байх үүднээс бид нар бас тэр дээр анхаарсан. Тэгээд энэ хуультай бол тэр бол хамаагүй асуудал байсан. Бид бол энэ хуулиараа янжуурын татварыг өндөр болгох ёстой гэсэн бодлого байсан. Одоо ингээд.../минут дуусав./

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Ер нь энэ тамхины импорт болон дотоодын үйлдвэрлэлийн харьцаа ер нь хэд байдаг юм? Өөрөөр хэлбэл, дотоодын үйлдвэрээс ер нь

дотоодын хэрэгцээнд яг хэдэн үнийн дүнтэй, ямар үнийн дүнтэй, хэдэн ширхэг ийм тамхи нийлүүлэгддэг юм? Импортоор аль аль улсаас орж ирдэг юм? Жишээлбэл Евразийн орнуудаас хэдэн хувь нь, бусад орноос хэдэн хувь нь ийм статистик мэдээлэл байна уу? Нэг.

Хоёрдугаарт ер нь сүүлийн жилүүдийн байдлаар тамхины импорт болон тамхины хэрэглээ нэмэгдэж байгаа юу, буурч байгаа юу? Энэ статистик энэ тоо баримттай уялдаж энэ татварын асуудал бас яригдах ёстой байх л даа. Яах вэ ганцхан Евроазаар бол авч үзэж бас болохгүй байх. Гэхдээ Евроазийн хэлэлцээрийн дагуу зарим төрлийн тамхиныуд нь ингээд татваргүй орж ирэхээр энийг нь онцгой албан татвараар зохицуулъя гэдэг ийм бодлогыг холбогдох байгууллага, Засгийн газар баримталж байгаа юм байна гэж ойлголоо. Нэг.

Хоёрдугаарт нь энэ яг татварын орлогоор ер нь яг хэдэн төгрөг энэ дээр бүрддэг юм бол? Энийг ер нь мэргэжлийн байгууллагууд яг юу гэж үздэг юм бол? Энэ зохицуулалт нь ер нь хэр оновчтой байна аа? Эсвэл өөрчлөх шаардлага байгаа гэж үздэг үү? Энэ тал дээр хариулт авмаар байна.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Индрийн микрофон нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Ч.Чимгэрэл: Гаалийн ерөнхий газрын Чимгэрэл байна. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Тамхины импортын хэмжээ бол сүүлийн 3 жилд бол өссөн байгаа янжуур тамхи дээр ялангуяа. Одоо бол 3.9 сая тэрбум тамхи орж ирсэн. Дотоодын үйлдвэрлэлтэй холбоотой тамхины асуудлыг бол Татварын ерөнхий газраас хариулах байх гэж бодож байна.

Нийтдээ бол тамхин бүтээгдэхүүнээс 305 орчим тэрбум төгрөгийн татвар бол ногдуулж улсын төсөвт төвлөрүүлж байгаа. Энэ дотроосоо бол янжуур тамхи дээр бол 275.5 тэрбум төгрөгийн албан татвар төвлөрүүлж байгаа. Бусад нь бол электрон янжуур. Тэгээд дүнсэн болон задгай тамхи гэсэн ийм төрлүүдээс улсын төсвийн орлого бүрдэж байгаа. Татварын орлого бүрдэж байгаа.

Евроазийн бүс нутгийн гишүүн улсуудаас нийт янжуур тамхины 35 орчим хувь бол бүрдүүлдэг. Бүгд Найрамдах Солонгос Улсаас бол нийтдээ 70 орчим, 65 орчим хувь бол бүрддэг. Ингээд бусад улсуудаас орж ирж байгаа.

Электрон тамхины хувьд бол 90 орчим хувь нь бол зөвхөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортлогдож орж ирж байгаа

Н.Наранбаатар: Өшөө нэмж хариулах. Индрийн микрофон өгөөрэй.

Р.Мягмаржав: Татварын ерөнхий газар, Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга Мягмаржав. Гишүүний асуултад хариулъя.

Дотоодод үйлдвэрлэж байгаа тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй бол одоогийн байдлаар 4 компани үйл ажиллагааны бүртгэлтэй байгаа. Үүнээс өмнө 1 компани бол үндсэн үйл ажиллагаагаа бол хэвийн явуулж байна. Үйлдвэрлэгч компанийн хувьд өнгөрсөн 2025 оны байдлаар бол 406 орчим сая тамхи бол үйлдвэрлэсэн гэсэн бол тайлан, мэдээллийг ирүүлсэн байгаа.

Орлогын буюу татвар төлөлтийн байдлын хувьд бол тус дотоодын үйлдвэрлэгч компани маань тамхины онцгой албан татвараар 2025 онд 2.1 тэрбум төгрөгийн онцгой албан татварыг төлсөн. 2024 онд бол 9.5 тэрбум төгрөгийн татварыг ингээд төлсөн гэсэн мэдээлэл байна.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд ирүүлсэн саналуудаар санал ирээгүй байна. Санал ирээгүй байна.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулна.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.47 цаг.

Хоёр дахь асуудал Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын. Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар, удирдлага, арга зүйн газрын дарга, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Дамдинпүрэвын Цогтжаргал Нийслэлийн Татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлого амьдрах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нэгтгэн нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр хуралдаан даргалагчаас төслийн зарим хэсэг, заалтыг гүйцээн боловсруулж, холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулах чиглэлийн дагуу Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2026 оны 06 дугаар сарын 16, 17-ны өдөр хуралдаж асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу бэлтгэн томъёолж, дараах саналыг Байнгын хороонд танилцуулж байна.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах саналын хувьд нэмэгдсэн өртгийн албан татварын татвар суутган төлөгчийг бүртгүүлэх босго нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгсэл бус, татварын тогтолцоог үр ашигтай хэрэгжүүлэх захиргааны зохицуулалт байх бөгөөд олон улсын зарчим нь тодорхой бүлэгт татварын дагуу давуу байдал олгох бус харин татварын бодитой, үр ашигтай, хэрэгжих боломжтой байхаар зохицуулдаг байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгээс НӨАТ-тай холбоотой 86 мянган санал ирүүлснээс НӨАТ суутган төлөгчтэй холбоотой 14 мянган санал ирсэн байх бөгөөд босгыг нэмэгдүүлэхийг эсэргүүцсэн бүх нийтээрээ шударга тэгш татвар төлдөг санал дийлэнх хувийг эзэлж байна.

Мөн 2019 оноос хойш татварын систем эрчимтэй цахимжиж, тайлагнал, төлөлттэй холбоотой зардал буурсан үзүүлэлттэй байна.

Ажлын хэсэг олон улсын зарчмын хүрээнд татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг харгалзан НӨАТ-ын тогтолцоо, хамгаалалтаа хамгаалах үүднээс НӨАТ суутган төлөгч бүртгүүлэх босгыг хэвээр үлдээх саналыг гаргаж байна.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах саналын хувьд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг хууль зүйн нэр томъёоны хувьд ойлгомжтой, хоёрдмол утгагүй нэг мөр ойлгох агуулгаар болон хууль зүйн техникийн дагуу дахин томъёоллоо.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Татварын хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүнд баярлалаа. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ?

Мөнхсоёл гишүүн танилцуулна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.52 цаг.

Гурав дахь асуудал. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 1 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Гишүүд танхимд орж ирээрэй. Гишүүд орж ирээрэй санал хураалт явуулах гэж байна. Гишүүд орж ирээрэй. Төсвийн байнгын хорооны гишүүд орж ирээрэй.

Сая орж ирсэн гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. 6 хүн л бэлдсэн байна. Бадамсүрэн гишүүн санал хураалтад бэлдэх ёстой юм байна. Батболд гишүүн бэлдэх ёстой юм байна. Булгантуяа, Ганбаатар, Ганзориг, Жаргалсайхан. Мөнхсоёл гишүүн санал хураалтдаа бэлдэх ёстой юм байна. Пүрэвдаваа, Үүрийнтуяа гишүүн санал хураалтдаа бэлдэх ёстой юм байна. Цогтбаатар, Чойжилсүрэн, Энхтүвшин гишүүн. Одоо 11 хүн бэлтгэсэн байна. Саналын томьёолол уншиж танилцуулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах санал .

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1.5 тэрбум” гэснийг “2.5 тэрбум” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, 26.2 дахь хэсэг, 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “05-ны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “05-ны” гэж тус тус өөрчилсүгэй.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Бадамсүрэн, Батбаяр, Батболд, Болормаа, Ганзориг, Жавхлан, Мөнхбат, Пунсалмаа, Соронзонболд, Сэддорж, Тэмүүлэн, Хосбаяр, Энхтүвшин, Энхцэцэг. Цаашид ажлын хэсэг гэх. Гишүүд санал хураалтад бэлдчихсэн үү? 11 хүн санал хураалтад бэлдсэн байна. Санал хураалт

52.4 хувиар дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ Аж ахуйн нэгжийг?

Энхтүвшин гишүүн танилцуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.06 цаг.

Дараагийн асуудал.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүн .

М.Бадамсүрэн: Энэ миний хувьд мэдээлэл авахдаа түрүүн Байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцээд дэмжсэн гэж ойлгосон. Тэгээд яагаад дахин санал хураалгаж байгаа юм бол?

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Х.Ганхуяг: Энэ асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл Улсын Их Хурлын чуулганы үед аваад тэгээд ажлын хэсэг дээр нэлээн тал талаас нь ярилцсан. Тэгээд асуудал нь юу байсан бэ гэхээр 2 хувилбараар ажлын хэсэг дээр санал оруулаад тэгээд энэ саналаар орж ирсэн байгаа юм.

Яагаад энэ асуудал ярих болсон бэ гэхээрээ татвар төлөгчдийн нийтээрээ өгсөн, нийт бол 86 мянган хүн энэ саналыг өгсөн байдаг юм. Бүх нийтээрээ жигд татвар төлдөг больё гээд. Аль эсвэл ерөөсөө бүгдээрээ төлөхөө больё гэдэг л ийм зарчмыг яриад байгаа юм. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал НӨАТ суутган төлөгч 69 мянган аж ахуйн нэгж байгаа өнөөдрийн байдлаар. Тэгээд яг 400-гийн саяын босго тавьчихаар 34 хувь буюу 23 мянга нь НӨАТ төлөгч байхаа больчихно гэсэн үг. Тэр нэг ёсондоо өнөөдрийн байгаа зах зээл дээр байгаа НӨАТ-тай бараа, НӨАТ-гүй бараа гэдэг юм чинь бүүр гаарна гэсэн үг. Тэр утгаараа эргээгээд манай яг дундын хүнсний үйлдвэр, тэр тусмаа хүнсний үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрүүд өөрсөд дээрээ НӨАТ-ын ачааллыг авна гэсэн үг. Нэг ёсондоо зардал нь 10 хувиар нэмэгдэх болчихоод байгаа.

Тэгээд энийг бол бид нар энэ нэг дэх өдөр аж ахуйн нэгжүүдтэй дахиж хэлэлцүүлэг хийсэн. Ажлын хэсгийн хурлыг хийхээсээ өмнө. Нэг дэх өдөр аж ахуйн нэгжүүдтэй хийгээд хоёр дахь өдөр ажлын хэсгээ хуралдуулаад энэ санал гарсан байгаа юм.

Гуравдугаарт өнөөдөр НӨАТ хамрагдалтын түвшин бол яг энэ сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн өндөр үе 75 хувьд хүрсэн бол энэ босгыг баталснаар 68 хувь руу буурахаар байгаа. 68 хувь руу буурна.

Тэгээд энэ НӨАТ-ын хамрагдалт багасах тусам бид нар яг хэн ямар орлоготой гэдгийг угаасаа мэдэхээ болино гэсэн үг. Бид нар угаасаа яг тэр

орлогын албан татвар дээрээ аж ахуйн нэгж байна уу, хувь хүний байна уу орлогын албан татвар дээрээ хангалттай хэмжээний хөнгөлөлт өгдөг байх. НӨАТ-аа бол хамрагдалтаа 95 хувь руу л аваачих хэрэгтэй гэсэн үг. Сая ажлын хэсэг дээр бол босгыг нь 100 сая болгоё. Өнөөдрийн инфляцын түвшинтэй уялдуулан 100 сая байхаар байгаа. 100 сая болгоё. Тэр сайн дураараа яах нь бол 10 саяас дээш байа гэдэг санал хураалт хийгдсэн. Тэр дэмжигдээгүй. Гүйцээн боловсруулах чиглэл аваад тэгээд буцаагаад энэ 50 сая гэдэг дээрээ байх нь зүйтэй байна гэдэг ажлын хэсэг дээр бол санал хураалт хийгдээд өнөөдөр Байнгын хороогоор орж байна гэсэн үг.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт давтаж дууслаа.

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 1 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй гишүүд. Санал хураалт явах учраас танхимд орж ирээрэй. Төсвийн байнгын хорооны гишүүд танхимдаа орж ирээрэй санал хураалт явах гэж байна. Ажлын алба гишүүдийг дуудаарай.

Ганхуяг гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая.

Х.Ганхуяг: Энэ гуравны хоёроор хураалгах ёстой байгаа 2 санал байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр бид нар өмнө нь Байнгын хороон дээр ч хураачихсан, чуулган дээр ч дэмжигдсэн саналууд байгаа. Тэгээд тэрийг яагаад юуг нь тодорхойлолтыг нь илүү тодорхой болгож өгөхгүй бол энэ байраа зарвал татварыг нь байхгүй болгох гэж байгаа шүү дээ. Үл хөдлөхийн татварыг. Гэхдээ энийгээ хязгаарлалтад тавихдаа иргэний гэдгээр оруулж байгаа юм. Иргэний гэхгүй бол зүгээр албан татвар төлөгчийн гэхээр аж ахуйн нэгжүүдийн бүх үл хөдлөхийн татвар нь байхгүй болчих гээд байгаа юм. Нөгөө борлуулахад. Тэгэхээр нөгөө барилгын компаниуд чинь ямар ч татваргүй болчих гээд. Тэгээд энэ дээр иргэний гэдэг асуудал оруулж өгч байгаа юм.

Аялал жуулчлалын бүс гэдгийгээ аялал жуулчлалын бүс болон тусгай хамгаалалтад баригдсан орон сууц гэж оруулж өгөхгүй бол бас болохгүй байгаад байгаа юм. Тэгээд энийг нь энэ 2 байдлаар тодруулж оруулж өгч байгаа шалтгаан тэр юм. Тэгэхгүй бол энэ өмнө нь санал хураагдчихсан болохоор заавал ч үгүй гуравны хоёроор Байнгын хороонд хураалгах болчихоод байгаа юм гишүүд ээ. Сайн байна.

Хоёр дахь санал нь болохоор энэ аж ахуйн, хувь хүний орлогын татварыг нэгтгэсэн шүү дээ. Тэгээд нэгдэхдээ үйлчлэх хугацааг нь нэгийг нь 27 оны 01 сарын 01-нээс 27 оны 12 сарын 31. Энэ бас хураагдсан санал.

Хоёр дахийг нь болохоор 28 оны 01 сарын 01-нээс иргэд дагаж мөрдөнө гэдгийг нь нэг заалтад орчихсон байсныг нь салгаж байгаа юм. Заалт юу байдаг юм. Энэ хууль зүйн техникийг нь заавал ч үгүй салах ёстой болчихоод. Тэгээд ийм л 2 саналыг заавал ч үгүй гуравны хоёр дахь болчихоод байгаа юм. Айн? Гуравны хоёр дахь.

Н.Наранбаатар: Дэгийн дэгийн тухай хуулийн 31.5-д энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-д заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатад оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна.

Сангийн сайд байхгүй бол дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна гэж заасны дагуу хойшлууллаа. Маргааш өглөө 9 цагт санал хураалтыг явуулна. .

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

15.15 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР